

Calamus fortior gladio

Үзэг бол илднээс хүчтэй

ОРШИЛ

Уншигч та энэ товхимлоос олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай (ОНӨН) тодорхой ойлголт авах болно. ОНӨН гэдэг олон нийтийн төлөөллөөс бүрдсэн хараат бус удирдах байгууллагатай, олон нийтээс санхүүждэг, олон нийтийн хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг радио, телевизийн тогтолцоо юм. Тэгэхээр энэ товхимолд төрийн ч бус, засгийн газрын ч бус, хувийн ч бус та бидний өөрсдийн радио, телевизийн тухай өгүүлнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, бид олон нийтийн эрх ашиг, сонирхолд үйлчилдэг хэвлэл мэдээллийн байгууллагын мөн чанарын тухай хөндөнө. Энэ нь иргэд бидний Үндсэн хуулиар баталгаажсан мэдээлэл хүлээн авах, түгээх эрхээ эдлэхтэй салшгүй холбоотой билээ. ОНӨН-ийн тухай бүр 1990 оноос яригдаж байгаа хэдий ч монголын олон нийт өнөө хэр радио, телевизийг өөрийн хяналтад авч амжаагүй л байна.

1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэж заасан бөгөөд энэ хуулийг хэрэгжүүлэх тухай УИХ-ын тогтоолд засгийн газрын мэдэлд байгаа Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрыг Олон нийтийн радио, телевиз болгон өөрчлөн байгуулахаар заасан билээ. Харамсалтай нь энэ шийдвэр өнөө хэр хэрэгжээгүй хэвээрээ байгаа юм.

Хэвлэл мэдээлэл дотроос хамгийн хүчирхэг нөлөөтэй хэрэгсэл болох радио, телевизийг эрх баригчид хараа хяналтаасаа гаргахыг төдийлөн яаравчлахгүй байгаа. Энэ нөхцөлд олон нийт гагцхүү төр, засгийн эрх барьж буй хүчнээс бидэнд тулган өгч буй мэдээллийг хүртэж байгаа юм. Бид урьд өмнө ард түмэн нь төрдөө үйлчилж, хэвлэл мэдээлэл нь нэг намын үзэл сурталд шүтсэн нийгэмд амьдарч байв. Харин одоо төр нь иргэддээ үйлчилж, хэвлэл мэдээлэл нь олон ургальч үзэлд шүтдэг нийгэмд амьдрах болжээ. Ийм нөхцөлд Засгийн газар хэвлэл мэдээллийг социализмын үеийнх шиг хянахыг хүссэн хэвээр байх нь угтаа ардчиллын зарчимд харш бөгөөд хүний эрхийн тулгуур зарчмыг хүлээн зөвшөөрөхгүй, үгүйсгэж буйтай агаар нэг юм. Нөгөө талаар иргэдийн сонгосон УИХ иргэддээ эргэн үйлчилж, эрх ашгийг нь хамгаалах үүрэгтэй. Энэ үүргийнхээ дагуу радио, телевизийг либеральчилж, өөрсдийн хяналтаас чөлөөлөн иргэд- олон нийтэд хүлээлгэн өгөх нь хууль ёсны, мөн зүйн ёсны билээ. Ардчилсан нийгэмд иргэд өргөн хүрээтэй бодит мэдээлэл авч чадахгүй бол жинхэнэ ардчилал үгүй. Эрх мэдэлтнүүд ардчиллын утга учир, зарчмуудыг ойлгон ухамсарлаж, иргэдийнхээ эрх ашигт үйлчлэх цорын ганц зорилготой гэдгээ ямагт санаж явбал зохино.

Иймд энэ үзэл санааг зөв зохистой зохицуулсан хууль зайлшгүй шаардлагатай байна. ОНӨН-ийн тухай хуультай болсон цагт радио, телевизийг өөрсдийн халааснаас санхүүжүүлж буйнхаа хувьд чухамхүү бидэнд хэрэгцээтэй, шаардлагатай мэдээллийг хүлээн авч, бидний хүссэн, таалсан, бидний оюуны хэрэгцээг хангасан нэвтрүүлгүүдийг шаардах эрх зүйн үндэстэй болно.

Бид энэхүү товхимолд чухам яагаад олон нийтийн радио телевиз хэрэгтэй болох, түүнийг үүсгэн байгуулах нөхцөл, шаардлагын тухай олон улсын хэм хэмжээ, судалгаа туршлага, мөн энэ салбарт мэргэшсэн манай мэргэжилтнүүдийн үзэл бодлыг багтаасан болно.

Товхимлыг “Глоб Интернейшнл” ТББ-аас Будапешт хот дахь “Нээлттэй нийгэм (Соросын сан) хүрээлэн”-гийн Хэвлэл мэдээллийн сүлжээний хөтөлбөрийн санхүүжилтээр хэргэжүүлж буй “Хэвлэл мэдээллийн хууль эрх зүйн шинэтгэл” төслийн хүрээнд эрхлэн гаргав.

Энэхүү товхимол хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлч, хуульч боловсруулагч, тогтооч болон өргөн олон нийтэд чухал хэрэгцээт гарын авлага төдийгүй Монголд чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаар хөгжүүлэх эрхэм үйлст бага ч атугай нэмэр хандив болно гэдэгт найдаж байна.

Х.Наранжаргал (сэтгүүлч)

Ю. Эрдэнэтуяа / дэд доктор /

МОНГОЛЫН ТЕЛЕВИЗИЙН ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР...

XXI зууны соёлт ертөнцөд мэдээлэл харилцаа улам бүр глобальчлагдаж, мэдээллийн технологийн хөгжил дэвшлийн үр шим хүний өдөр тутмын хэрэглээнд асар түргэн хурдацтай нэвтэрч байгаа өнөө үед өнгөрсөн зууны нэгэн гайхамшиг гэгдэж байсан телевизийн үе өнгөрч байна гэж үзэх учиргүй. Хэдийгээр информатик, компьютер, телекоммуникацийг холбосон мэдээллийн хүчирхэг сүлжээ тив, дэлхийг торлож байгаа ч гэсэн орчин үеийн хүний амьдралыг телевизгүйгээр төсөөлөх аргагүй. Учир нь телевиз мэдээллийн хүчирхэг хэрэгслэлийнхээ хувьд нийгмийн сэтгэл зүй, олны санаа бодлыг төлөвшүүлж, тэр ч бүү хэл түүнийг хааш нь ч залж чиглүүлэх нөлөө бүхий удирдлагын хэрэгслэл гэж үздэг тал бий. Ингэхээр телевиз нийгмийн хөгжилд чухал үүрэгтэй болох төдийгүй түүнийг хэрхэн яаж хөгжүүлэх нь аль ч улс орны төр засгийн анхаарал, ивээлд байдаг асуудлын нэг болдог байна.

Манай оронд анх 1967 онд телевизийн тогтмол нэвтрүүлэг явуулж эхэлснээс хойш даруй хөгжлийн 30 гаруй жилийг үдэж, чамлахааргүй их амжилт, арга туршлага, уран бүтээлийн баялаг сан хөмрөгтэй, дотоод, гадаадын үйл явдлыг түргэн шуурхай түгээн дамжуулдаг үндэсний мэдээллийн өргөн сүлжээ болтлоо өсч хөгжлөө.

Телевизийн бүтэц, тогтолцоо:

Монгол орны нийгмийн байгуулал ардчилсан өөрчлөлт шинэчлэлтийн замд шилжсэн 1990 оноос хойш монголын телевизийн хөгжилд ихээхэн өөрчлөлт гарч телевизийн бүхэл бүтэн шинэ тогтолцоо бүрэлдэн тогтож байна.

1990 оноос өмнө манайд эрх баригч МАХН-ын үзэл суртлын хэрэгслэл болох үндэсний хэмжээний цорын ганц радио, телевизтэй, цөөн хэдэн аймаг, хотын төвд орон нутгийн радио станц, телевизийн студитэй байсан боловч тэдгээр нь ихэнхдээ өргөн нэвтрүүлгийг хүлээн авч, дахин дамжуулах чиглэлээр ажилладаг байсан юм.

Нийгэмд олон ургальч үзэл бодол хөгжин дэлгэрэхийн хирээр үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө бодит биелэлээ олж, нийтлэлийн агуулгыг хянадаг цензурын систем ч үгүй болсон. Олон намын тогтолцоотой, ардчилсан төр засгийн байгуулалтай болсноор радио, телевиз ч гэсэн нэг намын мэдлийн байхаа больж Засгийн газрын харъяанд шилжснээр өнөөг хүртэл төрийн телевизийн статустай үйл ажиллагаа явуулж байна.

1990-ээд оноос Монгол телевизийн бүтэц, бүрэлдэхүүнд уран бүтээлийн нэгдлүүд байгуулагдан ажиллаж эхэлсэн нь цаашид телевизийн бие даасан студи, хувийн телевиз байгуулагдан ажиллах нэг ёсны гараа болсон гэж үзэж болно. Тиймээс ч 1991 онд батлагдсан Аж ахуйн нэгжийн тухай хуулийн дагуу уран бүтээлийн олон хамтлаг хуулийн этгээдийн гэрчилгээ авч телевизийн нэвтрүүлэг бэлтгэх болсон. Тухайлбал: Монголын мэдээлэл дамжуулах телевиз Эм-би-си /Ж.Түвшинбат, гадаадын хөрөнгө оруулалттай/, Монголын чөлөөт телевиз /Ц.Төрмандах/, Зохиогчийн телевиз /Ш.Гүрбазар/, Жолоо зохиогчийн телевиз /Галаарид, Солонго/, Худалдаа арилжааны чөлөөт телевиз /Сумхүү/, Мэдээлэл арилжааны Тэнхлэг чөлөөт телевиз /Д.Гарам-Очир/, Тулах цэг телестуди /Г.Жаргалсайхан/, Капитал телестуди /Д.Цондовдорж/, Өмнөговь аймгийн Баянговь телевизийн хамтлаг, Хэнтий аймгийн Ар ма хувийн телевиз гээд Хууль зүйн яаманд албан ёсоор бүртгүүлж аж ахуйн нэгжийн гэрчилгээ авсан олон

«телевиз» үүсч гараад төдөлгүй сураг ажиг тасарсан билээ. Үүнд тэднийг буруутгах аргагүй. Учир нь телевиз гэгч мэдээллийн хүчирхэг хэрэгслэл ТҮЦ байгуулан ажиллуулахтай яавч адилгүй, техник, хүн хүч, санхүүгийн чадвахи шаардсан амар хялбар бус ажил гэдэг нь ойлгомжтой.

Тухайн үед сэтгүүлч, уран бүтээлчдийн цалин хөлс тогтмол, нийтлэлийн урамшил бага, ажиллах нөхцөл тааруу байсан нь зарим хүнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж орлого олох, амьдралаа дээшлүүлэх, хамгийн гол нь чөлөөтэй, уран бүтээл хийх гэсэн эрмэлзлэлээ хэрэгжүүлэхэд нь зүй ёсоор нөлөөлсөн юм. Үүний ололттой зүйл нь гэвэл телевизийг мэдээллийн төдийгүй арилжааны хэрэгслэлийн зориулалтаар ажиллуулж болдогийг харуулж өгсөн явдал байлаа.

Харин 1991 оноос мэдээлэл арилжааны Тэнхлэг компани өөрийн телевизийн хөтөлбөрөө цацаж жил шахам хугацаанд ажиллаж эхэлснээр Монголд анхны хувийн телевизийн хөгжлийн эхлэлийг тавьсан юм. Энэ үеэс хойш Улаанбаатар хотын телевиз, МН 25-р суваг телевиз, Монгол-Америкийн хамтарсан Бүргэд телевиз болон орон нутгийн төрийн болон хувийн телевизүүд үүсч хөгжин нийгмийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулан бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслэлтэй амжилттай өрсөлдөж байна.

Өнөөдөр монголын мэдээллийн зах зээлд тогтмол, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн нийт хэрэгслэлийн 15 орчим хувийг телевиз эзэлж байна. Хууль зүйн яаманд албан ёсоор бүртгэгдсэн нийт 24 телевиз, 9 кабелийн телевиз 2001 оны эхний хагас жилийн байдлаар тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ажээ. Монголын хэвлэлийн хүрээлэнгээс явуулсан мониторингийн судалгаанд дурьдснаар одоогоор тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 241 мэдээллийн хэрэгслэлтэй, үүнээс: сонин 144, сэтгүүл 36, радио 27, телевиз 24, кабелийн телевиз 9, агентлаг 1 байгаа юм.

Бүтцийн хувьд авч үзвэл, үндэсний хэмжээнд хөтөлбөрөө дамжуулдаг нэг телевизтэй, нийслэлийн телевизтэй, орон нутгийн телевизийн студитэй байна. Харин харъяалал буюу эзэмшлийн хувьд одоогоор төрийн өмчийн, хувийн өмчийн гэсэн хоёр хэвшлийн телевизтэй байна. Энэ нь Улаанбаатар хот, бусад томоохон хот, суурин газарт төрийн болон хувийн телевиз зэрэгцэн оршиж өрсөлдөх болсон давуу талтай болжээ. Хувийн телевизүүд төрийн мэдлийн телевизүүдтэй хүч тэнцвэргүй тулаанд өрсөлдөж чамгүй амжилттай ажиллаж байна. Ялангуяа тэдгээр нь зарим талаараа мэдээллийн алтернатив эх сурвалж болж байгаагаараа үзэгч олны сонирхолыг татсаар байна.

Одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа нийт телевизийн 60 шахам хувь нь төрийн байгууллагын харъяалалд, 30 гаруй хувь нь хувийн эзэмшлийнх байна. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль гарснаар төр өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгслэлтэй байх ёсгүйг хуульчлан заасны дагуу телевизүүд Засаг даргын тамгын газрын харъяанд байснаа тухайн аймаг, хотынхоо ИТХ-ын мэдэлд шилжснээр «олон нийтийн» телевиз гэсэн тодотголтой болсон. Үнэн чанартаа тэдгээр телевиз төрийн мэдлийн телевиз хэвээрээ байгаа бөгөөд олон нийтийн буюу нийтийн эзэмшлийн телевизийн эрх зүйн болоод үйл ажиллагааны зарчим огтхон ч байхгүй байгаа болно.

Мөн томоохон төв, суурин газруудад кабелийн телевизтэй хөгжиж байгаа. Одоогоор Сансар, Хийморь, Их монгол, Сүлжээ 1, Сүлжээ 2, Нарлаг монгол, Мэдээлэл, Нислэг, Лха /Дархан-Уул аймаг/, Од /Төв аймаг/ зэрэг кабелийн телевизүүд гадаад, дотоодын телевизийн программыг 12-30 сувгаар дамжуулж байна.

Телевизийн зах зээл:

Хэвэл мэдээллийн хэрэгслэл түүний дотор телевиз нийслэл хотод төвлөрөн хөгжиж байгаа. Тиймээс Улаанбаатар хот телевизийн хамгийн том зах зээл. Төрийн өмчийн 2 телевиз /MYTB, UBS/, хувийн 2 телевиз /МН-25-р суваг, Eagle/, кабелийн 9 телевиз тогтмол үйл ажиллагаа явуулж байна Мөн

төрийн захиргааны зарим байгууллага болон МАХН ивээлдээ ажиллуулдаг уран бүтээлийн хэд хэдэн студитэй. Тэдгээр нь тодорхой сэдвээр нэвтрүүлэг бэлтгэж үндэсний телевизээр гаргадаг.

Харин хөдөө орон нутагт хэвлэл мэдээллийн дээрээс доошоо босоо шугамт тогтолцоо үгүй болсноор түүнийг орлох ямар нэгэн тогтвортой систем хараахан бүрэлдэж амжаагүй байна. Ихэнх аймгийн төвд телевизийн студи байгаа нэртэй боловч үнэн чанартаа тогтмол нэвтрүүлдэг нь цөөн. Орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэг цацдаг телевиз өнгөрөгч 2000 оны байдлаар 24 байсан бол энэ онд Өвөрхангайн телестуди, Өргөө телевиз, Чойбалсан хотын Скорпион телевизүүд, Багануур дүүргийн Ноён телестудийн үйл ажиллагаа зогсож, Цэцээ гүн зэрэг телевиз тогтмол бус нэвтэрч байна. Орон нутгийн хэмжээнд нэвтрүүлэг цацдаг телевиз өнгөрөгч 2000 оны байдлаар 24 байсан бол энэ онд Өвөрхангайн телестуди, Өргөө телевиз, Чойбалсан хотын Скорпион телевизүүд, Багануур дүүргийн Ноён телестудийн үйл ажиллагаа зогсож, Цэцээ гүн зэрэг телевиз тогтмол бус нэвтэрч байна.

Орон нутгийн телевизээс Сэлэнгэ аймгийн Нарны хүлэг, Дарханы А-Жи-Би хувийн телевиз, Дархан телевизийн программ 7 хоногт 55- 120 гаруй цагийн хөтөлбөр үзүүлдэг гэсэн тооцоо судалгаа гарчээ. Нэг зүйлийг тэмдэглэхэд дээрх телевизүүд нь Улаанбаатарт нэвтрүүлдэг 25-р суваг телевизийн хөтөлбөрийн бичлэгийг зөөвөрлөн өөрийн үзэгчиддээ хүргэдэг юм. Бусад телевизүүдийн тухайд 7 хоногт дунджаар 10-аас дээш цагийн хөтөлбөр үзүүлдэг 3 телевиз /Номин, Орхон, Минжит Булган ТВ/, 6-10 хүртэл цагийн хөтөлбөр үзүүлдэг 4 телевиз /Баян-Өлгийн ТВ, Говьсүмбэр ТВ, Ховд ТВ, Хэтий телестуди/, 1-5 цагийн хөтөлбөр нэвтрүүлдэг телевиз 9 байна. Үүнээс харахад ихэнх орон нутгийн телевиз монголдоо «ганц» гэгдэх үндэсний телевизийн хөтөлбөрийг хүлээн авч үздэг ба завсар чөлөөгөөр нь орон нутгийн мэдээллээ хүргэдэг ганц нэг цагийн хөтөлбөр үзүүлэхээс хэтэрдэггүй байдалтай байна.

Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Өлгий, Мөрөн зэрэг томоохон хотуудад байдал арай өөр. Энд телевизийн хөгжил өөрийн гэсэн өнгө төрхөө олон хөгжиж байгаа юм. Дархан хотод орон нутгийн анхны хувийн телевиз /А-Жи-Би / үүсч байгуулагдаад эдүгээ долоо хоногт 50 гаруй цагийн хөтөлбөр бэлтгэн үзүүлдэг томоохон телевиз болтлоо хөгжиж байна.

Үндэсний телевиз зар суралчилгааны зах зээлд давуу байдалтайгаар ноёрхож байна. Төрийн мэдлийн телевизүүд санхүүжилтийнхээ нэлээд хувийг зар сурталчилгаанаас олдог. Өөрөөр хэлбэл төрийн радио, телевизүүд ч гэсэн рекламаас хамааралтай болж байна. Судалгаанаас үзэхэд төрийн телевизүүд нийт программынхаа 12-15 хувийг зар сурталчилгаанд зориулж байхад орон нутгийн радио, телевизүүд хөтөлбөрийнхөө 1-3 хувийг, хэт богино долгионы радио станцууд 3-6 хувийг зарцуулдаг гэсэн тооцоо гарчээ.

Уран бүтээл, үйлдвэрлэл:

Телевизүүд одоогийн байдлаар ихэнх нэвтрүүлгээ өөрсдөө үйлдвэрлэж байна. Сүүлийн жилүүдэд телевизийн нэвтрүүлэг бэлтгэдэг уран бүтээлийн студүүд бий болж байгаа боловч тэдгээр нь ихэнхдээ өөрийн бүтээлээ үндэсний болон хувийн телевизэд худалдаж чаддаггүй, харин ч дамжуулах сувгийн төлбөр өндөр учраас бараг өөрсдөө багагүй мөнгө төлж байж бүтээлээ үзүүлдэг шахам байдаг. Телевизүүд ч гэсэн гадаад, дотоодын телевизийн бүтээлийг тэр бүр худалдаж авах санхүүгийн чадавхи султай. Тиймээс программ солилцоо, худалдааны аргаар авдаг ганц нэг бүтээлийг эс тооцвол ихэнхдээ ахуйн хэрэглээний зориулалттай, хямд, чанар муутай видео кино, эсвэл гадаадын телевизийн хөтөлбөрөөс хулгайн замаар хуулж бичсэн зарим бүтээлийг орчуулан гаргах байдалтай байна.

Телевизийн жүжиг, кино, сериал хийх санхүүгийн болоод бусад боломж ихэнх телевизэд нэн хязгаарлагдмал байдгаас гадаадын телевизийн бүтээлүүд хөтөлбөрт нь нэлээд хувийг эзэлдэг. 2000 онд явуулсан судалгаанаас харахад нийслэлд үзүүлж байгаа телевизүүдийн хөтөлбөрийн 25-57 хувь нь гадаадын телевизийн бүтээлийг орчуулан үзүүлдэг байна. Тиймээс телевизийн өөрийн уран бүтээл үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх нь чухал юм.

Телевизийн нэвтрүүлэгт ивээн тэтгэгчдийн хүчийг татан оролцуулах хэлбэрийг аль ч телевиз өргөн ашиглаж байна. Харин тэдний хүчийг дэлгэцийн томоохон бүтээл хийхэд ашиглахаасаа илүү аливаа байгууллагын ой, тэмдэглэлт үйл явдлыг сурталчлахад гол төлөв ашигладаг нь учир дутагдалтай. Тэтгэх, тэтгүүлэх сэтгэлгээ, арга хэлбрийн шинэчлэл шаардагдаж байна.

Телевизийн үзэгчид:

Аль ч телевиз өөрийн үзэгчдийнхээ эрэлт хэрэгцээ, сонирхлыг сайтар судалж, хэнд зориулж юуг, хэдийд үзүүлэх вэ гэдгээ тодорхойлж байдаг.

Өмнө нь телевиз олон жилийн турш үзэл суртлын дайчин зэвсэг байж, хүнийг бүх талаар хүмүүжүүлэх, намын шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэхэд олон түмнийг зоригжуулан зохион байгуулагч, намын бодлого шийдвэрийг ухуулан таниулагч үүргийг нэр төртэй биелүүлж ирсэн. Тиймээс сайн, саар бүхнийг заавал үзүүлэх ёстой хэмээн ойлгож, жил улирлын хатуу сүлжээнд баригдан, хөдөлмөрчдөөс ирүүлсэн захидлын тоогоор тайлан тооцоо гаргаж, заримд нь ая дууны мэндчилгээ дэвшүүлж, заримынх нь гомдлоор «дурандаж» ирсэн. Ард иргэд, олон нийт ч гэсэн ийм л байх ёстой хэмээн ажил амьдралынхаа олон асуудлыг телевизээр дамжуулан шийдвэрлүүлэх нийгмийн сэтгэл зүйн уур амьсгал давамгайлж байлаа.

Тэгвэл өнөөдөр тэр үе нэгэнт өнгөрч нийгэм, оюун санаа, улс төр, эдийн засгийн бүх хүрээнд эрх зүйн харилцаа тогтож, иргэд байгууллага, хуулийн хүрээнд ажил амьдралаа зохицуулдаг боллоо. Энэ нөхцөлд телевизийн үүрэг зорилго нэгэн адил өөрчлөгдөн цоо шинэ маягийн телевиз болох учиртай. Харамсалтай нь манай телевизүүдэд төржсөн, үзэл сурталжсан байдал амь бөхтэй оршсоор ухуулга сурталчилгааны урт сунжруу яриа, тайлан, ярилцлагаар үзэгч олноо залхааж байна. Төрөөр тэтгүүлэх гэсэн олон нийтийн санаа бодол хэвээр байна.

Өнөөгийн үзэгчдийн хэв шинж, сонирхол хэрэгцээ өчигдрийн үзэгчдээс зарчмын эрс ялгаатай байгааг тооцохгүй байхын аргагүй. Чухам л аль болох олон үзэгчдийг өөртөө татахын төлөө тэмцэх нь өрсөлдөөний жам. Үүний цаана ашиг орлого гэсэн арилжааны хууль үйлчлэх нь гарцаагүй. Тиймээс ч өөрсдийн бүтээлээ үзүүлсний төлөө үзэгчдээс зохих хэмжээний хураамж нэг ёсондоо төлбөр авч байгаа билээ.

Бусад орны жишгээс харахад гол төлөв олон нийтийн телевиз улсын төсөв, зар сурталчилгааны орлогоос гадна үзэгчдээс тодорхой хэмжээний хураамж авч санхүүждэг. Энэ нь тухайн телевизийг үзэгчдийн өмнө өндөр хариуцлага хүлээлгэх, тэдний ашиг сонирхолд нийцсэн нийтлэл нэвтрүүлэг үзүүлэх нэг ёсны хөшүүрэг болдог байна.

Монголын телевизийн хөгжлийн өнөөгийн түвшинд ямар бэрхшээл тулгарч байгааг авч үзье.

- Юуны түрүүнд радио, телевизийн хууль, эрх зүйн бааз суурь байхгүй байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Харилцаа холбооны хууль, Долгионы тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зарим харилцаа нь зохицуулагдаж байдаг. Радио, телевизийн бие даасан хууль хэд хэдэн хувилбараар

- боловсрогдож байсан хэдий ч биелэлээ олсон хууль өнөө хир батлагдан гараагүй л байна. Үүнд гол нь төр, засгийн эрх барих хүчин өөрийн мэдэл, харъяандаа үндэсний радио, телевизийг ажиллуулж, бодлого шийдвэрээ өргөн олонд хүргэж байхын зэрэгцээ өөрийн эрх ашигт үйлчилдэг нөлөө бүхий мэдээллийн хэрэгслэлтэй байх үүднээс ханддагтай холбоотой. Энэ нь ялангуяа сонгуулийн үеэр илт харагддагийг хэн бүхэн мэднэ.
- Мэдээллийн зах зээл дэх төрийн монополь, хяналт хүчтэй хэвээр байсаар байна. Телевизүүд, ялангуяа орон нутагт бие даасан байдалтай болох, улс төрийн шахалт дарамтыг амжилттай сөрж чадах олон нийтийн дэмжлэгтэй болж хараахан чадаагүй, түүнд хүрэхэд нэлээд зай байна. Олон нийтийн буюу нийтийн эзэмшлийн радио, телевиз байгуулагдаагүй, хувь заяа нь тодорхойгүй байна. Нэг үеэ бодвол энэ талаар олон нийт, эрх баригчид, сэтгүүлчдийн хувьд ямар нэг ойлголттой болсон боловч бас төдийлөн цэгцрээгүй, хаа хаанаа нэгдсэн ойлголтод хүрээгүй байна.
 - Телевизийн нэвтрүүлгийн тухай ерөнхий хууль, эсвэл олон нийтийн радио, телевизийн тухай бие даасан хууль яаралтай батлан гаргах нь чухал байна. Мөн энэ чиглэлд олон нийтийн болон радио, телевизүүдийн хүчин чармайлтыг идэвхжүүлэх шаардлагатай. Гадаад орнуудын олон нийтийн радио, телевизийн туршлагыг судлахад сэтгүүлчдийг өргөн оролцуулах, түүнээс биш олон улсын байгууллагын хөрөнгөөр үе үеийн хууль тогтоогчид, радио, телевизийн шинэхэн удирдлагууд шил шилээ харан олон удаа явцаасан, олигтой үр дүнд хүрсэнгүй.
 - Орон нутгийн радио, телевизүүдийн хөгжил харьцангуй удаан, тэгш биш, нэгдсэн бодлогогүй, гадаад дотоодын хөрөнгө оруулалт бараг байхгүй шахам, тэднийг татах нөхцөл бололцооны хувьд ч тааруухан байна. Харин сүүлийн үед олон улсын хөгжлийг дэмжих сан, байгууллагаас тендер шалгаруулж, төслөөр хувийн богино долгионы радио станцыг санхүүжүүлж буй нааштай эхлэл гарч байна.
 - Хэвлэлийн эрх чөлөөний тулгуур үндсэн зарчмаас авч үзвэл ардчилсан нийгэмд зайлшгүй хэрэгжих ёстой шалгуур болсон үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө манай улсад хуульчлан баталгаажсан бөгөөд бас ч гэж амжилттай хэрэгжиж байгаа билээ. Харин нөгөө нэг шалгуур болох хүссэн мэдээллээ хүлээн авах, хайх, түгээх эрх чөлөөний хувьд анхаарах зүйл нэлээд бий. Энэ нь ялангуяа хөдөө орон нутгийн хувьд ийм боломж нөхцөл нэлээд хязгаарлагдмал байгаа нь бодит үнэн юм. Энэ нь цаад утгаараа хөдөөгийн иргэдийг орон нутгийн хэмжээнд болон үндэсний хэмжээнд ардчилалын үйл явцад идэвхтэй оролцох боломж нэгэн адил хязгаарлагдмал байгаатай утга адил юм. Үүнд мэдээллийн хамгийн хүчирхэг, нөлөөтэй хэрэгслэл болохынхоо хувьд телевизийн гүйцэтгэх үүрэг роль дутагдалтай байгааг тойрон гарахын аргагүй.
 - Орон нутгийн хэвлэл мэдээллийн байдлыг нухацтай судалж, сайжруулах талаар тулхтай бодлого боловсруулах, шийдвэрлэх оновчтой арга зам, хэлбэрүүдийг олж, идэвхтэй, санаачилгатай ажиллах нэгдмэл ажиллагаа илт үгүйлэгдэж байна. Энэ бүгд нь мэдээж телевизийн эзэмшил, харъяалал, санхүүжилт, зориулалт, хүний нөөц, менежмент, маркетингийн асуудал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалах нь мэдээж билээ.
 - Нэвтрүүлэх эрхийн зөвшөөрөл буюу лиценз олгох систем бүрэлдэн тогтож байгаа хэдий ч энэ нь хараат бус зөвлөл, комисс бус, харин Засгийн газрын яам олгодог нь төдийлөн нийцтэй биш юм. Цаашид нэвтрүүлгийн болон лицензийн тухай хууль хэрэгтэй байгааг харуулах бөгөөд ингэснээр лицензжүүлэх үйл явц илүү шудрага болж, хүнд суртал, элдэв дарамт шахалтаас чөлөөлөгдөх бололцоотой болно.

- Үзэгчдийн эрэлт хэрэгцээг судлах, рейтинг тогтоох ажил бараг эхлээгүй шахам гэж хэлж болно. Аудио болон видеометрийн хэмжилт судалгаа хийдэггүй, тийм боломж ч үгүй. Хараат бус ажиглалт, судалгааны албад бараг байхгүй. Ер нь телевизийн маркетинг, менежментийн ойлголт муутай, энэ талаар сонин хэвлэлээс нэлээд хоцорч байгаа. Бэлтгэсэн боловсон хүчин ч байхгүй гэхээр байна.
- Монголын телевизийн хөгжилд улс төр, арилжаа, бизнесийн ашиг сонирхлын нөлөөлөл бодитой оршиж, энэ эрх ашгаас хамааралтай байна. Мөнгө олохын тулд далд зар сурталчилгааны мэдээлэл бэлтгэдэг. Энэ нь үндэсний хэмжээний телевиз, радиод ч орон нутгийн телевизэд нэгэн адил газар авч байгаа. Энэ нь цаад утгаараа хараат бус, бодит сэтгүүл зүй хөгжихөд зохих саад тотгорыг учруулж, хэвлэл мэдээлэлд ухуулга сурталчилгаа голлох хандлагыг төрүүлж байгаа юм.
- Телевизийн нийтлэл нэвтрүүлгийн, ялангуяа мэдээллийн нэвтрүүлгийн хийц, арга барил, тогтсон хэв загварыг зоригтой өөрчлөх нь тулгамдсан асуудал болж байна. Төрийн байгууллага, албан тушаалтан, үйл явдал тойрсон албаны мэдээллээс өөр үзэж харах, бодож санах зүйлээр хомс байна. Сэтгүүлчдийг сургаж бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажилд эрс өөрчлөлт гаргах нь чухал бөгөөд ингэхгүйгээр сэтгэлгээ, арга барилын хэвшмэл загвараас салахад хэцүү байх болно.

Телевизийн хөгжлийн хандлага:

Телевиз хөтөлбөрөө цацах, газар орныг хамрах хүрээгээрээ олон улсын, нийт үндэсний, хотын, орон нутгийн, /мужийн, бүсийн г.м./ гэх зэргээр ялгагддаг байна. Программын зориулалт чиглэлээрээ ч мөн адил төрөлжсөн телевизүүд байдаг. Жишээ нь бидний мэдэх мэдээллийн, танин мэдэхүйн, сургалтын, хөгжмийн, спортын гэх зэрэг. Манайд ч бас хөгжмийн, киноны, хүүхдийн төрөлжсөн сувгууд гарч ирж байгаа нь олзуурхуштай.

Бэлтгэсэн хөтөлбөрөө дамжуулах байдлаар кабель шугамын, радио релейны, сансрын хиймэл дагуулын гэх мэт, техник технологийн хувьд электрон дамжуулагчийн, тоон үзүүлэлтийн, өндөр үелзэл, тод нягтралын гэх мэт олон чиглэлээр хөгжиж байна.

Мэдээлэл харилцааны том том хүчирхэг сүлжээг телевизийн хөгжилд өргөн ашиглаж телевиз-үзэгчдийн хамтын харилцан оролцооны /интерактив/ шинэ хэв маяг ч буй боллоо.

Харин олон улсын жишгээс харахад телевиз нь эрх зүйн байдлынхаа хувьд улсын, олон нийтийн буюу нийтийн үйлчилгээний /зарим газар улсын гэдэг/, хувийн гэсэн үндсэн төрөл хэлбэрээр оршин тогтнож байдаг байна.

Улсын телевиз нь төрийн өмчид тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд улсын төсвөөс санхүүждэг. Харьяалалын хувьд улсын мэдлийн телевиз нь чухам хэний эрх ашигт үйлчлэхээс шалтгаалан Засгийн газрын, олон нийтийн гэсэн статустай байдаг байна. Тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналтын зүгээс олон нийтийн телевиз нь удирдлага, зохион байгуулалтын хараат бус, бие даасан бүтэцтэй байхын зэрэгцээ үзэгчдээс тодорхой хэмжээний хураамж авдаг байна.

Хувийн телевиз нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг. Орлогын гол эх сурвалж нь зар сурталчилгааны орлого болдог. Иймд хувийн телевиз нь аль болох ашигтай ажиллахын тулд мэдээллийн салбарт олон талт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг арилжааны хүчирхэг компани, корпорацийн маягаар ихэвчлэн оршин тогтнож харьяандаа сонин хэвлэл, радио, кабелийн телевиз, дуу, дүрс бичлэг, зар сурталчилгааны төрөлжсөн үйлдвэрлэл зэргийг багтаадаг байна.

Энэ бүхнийг тэмдэглэхийн учир нь манай орны телевизийн хөгжилд нэгэнт бүрэлдэн тогтож буй олон төрөл хэлбэрийн телевизийн бүтэц тогтолцоонд олон нийтийн телевизийн бүтэц үгүйлэгдсээр байгаа бөгөөд ийм телевизийг байгуулж хөгжүүлснээр төр засаг, өргөн олон үзэгчид хэн хэнд нь хожоотой байх болно.



Вернер Рамхорст (Европын зөвлөл)

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай ойлголт, түүний үүрэг

Олон нийтийн өргөн нэвтрүүлэг бол хосгүй ойлголт юм. Хэдийгээр үүнийг ойлгоход хялбар ч заримдаа алсын бодлоготойгоор, заримдаа санаатайгаар үл ойлгосон мэт дүр үзүүлэх нь тохиолддог.

Чухам юуг хүлээн зөвшөөрдөггүй вэ?

Зарим хэлэнд английн “**public**” гэдэгтэй бүрэн нийцэх тодорхойлолт байдаггүй бөгөөд **state, government**, эсвэл **official** зэрэг үгийн утгатай ойролцоо орчуулагддаг байна. Улсын мэдлийн өргөн нэвтрүүлэгтэй байсан улс оронд дээрхтэй адил үг утгын хүндрэл гарах тохиодолд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай жинхэнэ ойлголтыг тодруулахад хэл зүйн чанартай саад тотгор эхлээд учирдаг.

Ялангуяа арилжааны өргөн нэвтрүүлгийн олон жилийн уламжлалтай улс орнуудад олон нийтийн өргөн нэвтрүүлгийг засгийн газрын биш гэхэд үүнтэй ойролцоо, улсаас санхүүждэг гэсэн төөрөгдмөл ойлголт байдаг.

Хуучин социалист орнуудад олон нийтийн өргөн нэвтрүүлгийг албан ёсны өргөн нэвтрүүлгийн нэг төрөл, төр, засгаас (буюу Коммунист намаас) санхүүждэггүй ч ардчиллын зарчмаар сонгогдсон парламентад ихэнх суудал авсан намын хяналтанд байдаг гэсэн ойлголт өргөн тархсан байдаг. Өөрөөр хэлбэл, хэн улс төрийн эрх мэдэлтэй нь өргөн нэвтрүүлгийг хянадаг, өнөөдрийн эрх мэдэл бол ардчилсан хууль ёс гэж үздэг ажээ.

Олон нийтэд зориулсан өргөн нэвтрүүлэг

Тэгвэл олон нийтийн өргөн нэвтрүүлэг гэж юу юм бэ? Нэрнээсээ эхлээд олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь :

- Олон нийтэд зориулагдсан
- Олон нийтээс санхүүждэг
- Олон нийт хяналт тавьдаг байгууллага юм.

“Олон нийт” гэдэг нь тухайн улсын (эсвэл тухай бүсийн) нийт хүн ам бөгөөд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь түүнд үйлчлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

“Нийт хүн ам ” гэдэг 2 ижил утга агуулна:

- **Нэгд**, техникийн үйлчилгээний утгаар бол үйлчилгээний хүрээнд хамрагдаж буй айл өрх бүр нэвтрүүлэг хүлээн авах боломжтой. Энэ нь ус, хий, цахилгаан, утас, нийтийн тээврийн үйлчилгээ гэх мэт нийтийн бусад түгээмэл үйлчилгээтэй адил юм.
- **Хоёрт**, энэ нь нийгмийн бүх хэсэг бүлэг болох баян ядуу, хөгшин залуу, боловсролтой, бага боловсролтой, соёл, шинжлэх ухаан, шашин шүтлэг, спорт, нийгэм, эдийн засгийн зэрэг аливаа тусгай сонирхол бүхий нийгэм бүхэлдээ гэсэн үг юм. Энэ утгаар бол хүн нэг бүрийг цаг ямагт тойлохгүй юм гэхэд нийт хүн ам олон нийтийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийг хүртэж үйлчлүүлэх ёстой.

Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь олон нийтэд, нийт хүн амд зориулагдсан болохоос биш Засгийн газар, Ерөнхийлөгч, Парламент, улс төрийн нам, сүм хийд, эсвэл аливаа хувийн сонирхол бүхий бүлэг, хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан бус билээ. Энэ бол дээрх бүхнээс хараат бус байж,

хэрэглэгчийн гэхээсээ илүү иргэдийнх нь хувьд хүмүүст, гагцхүү хүн амын ашиг сонирхолд үйлчлэх ёстой гэсэн үг.

Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн санхүүжилт

Олон нийтийн өргөн нэвтрүүлэг нь монополь, эсвэл хагас монополийн байдалтай, үндэсний хүн амын тоо нь чухал үзүүлэлт болдог улс орноос бусад газар ганцхүү арилжааны орлогоор санхүүжихэд хэцүү. Яг ийм жишээ Испанид байсан юм. 1980-иад онд бүс нутгийн хэмжээний өргөн нэвтрүүлэг, хожим нь үндэсний хэмжээний арилжааны телевиз байгуулагдах хүртэл үндэсний олон нийтийн өргөн нэвтрүүлэг эрхэлдэг RTVE байгууллага телевизийн салбарт монополь байв.

Зарим тохиолдолд олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага ивээн тэтгэлэг, зар сурталчилгааны орлогогүй байдаг. Нэвтрүүлгийн худалдаа, хэвлэл эрхлэх зэрэг бусад орлогоос гадна цорын ганц орлогын эх үүсвэр нь үйлчилгээний хураамж байдаг. Ийм тохиолдолд үйлчилгээний хураамжийг нэвтрүүлэг хүлээн авах хүрээнд хамрагдаж буй төхөөрөмж бүрээс авах ёстой. БИ-БИ-СИ (Их Британи) нь бол цэвэр үйлчилгээний хураамжаараа санхүүждэг олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын шилдэг бөгөөд танил жишээ юм.

Баруун Европын ихэнх оронд холимог (ивээн тэтгэлэг, сар сурталчилгаа, үйлчилгээний хураамж) санхүүжилт зонхилсон байдаг. Зарим газар үйлчилгээний хураамжийн оронд засгийн газар төсөв хуваариладаг. Гэхдээ энэ нь түүний илүү төр, засгийн мэдэлд байгааг харуулдаг.

Үйлчилгээний хураамж

Үйлчилгээний хураамжийн төрийн санхүүжилтээс ялгаатай давуу талууд.

Нэгд, улсын төсвийн хуваарлалтыг шийдвэрлэдэг улс төрийн этгээдээс хараат бус байна гэсэн үг юм. Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр, ялангуяа улс төрийн утга агуулгатай нэвтрүүлэг, сурвалжлагад нь шаардлагатай хөрөнгө мөнгийг баталгаатай болгохын тулд эрх мэдэлтнүүдэд тал засах тийм урьдчилсан нөхцөл байж таарахгүй. Гэсэн ч үйлчилгээний хураамжийн хэмжээг зохицуулах (өсгөх ч юм уу) шийдвэрийг аль нэг албан ёсны этгээд (Засгийн газар, эсвэл Парламент) гаргах шаардлагатай болдог. Энэхүү лут арга хэмжээг зохистой хуулийн хүрээнд, гагцхүү олон нийтийн эрх ашгийг хангах үүднээс шаардлагатай бодит хэрэгцээг үндэслэн хэрэгжүүлэх ёстой. Учир нь хүмүүсээ бодоод дундыг барьсан шийдвэр гаргах тохиолдол байдаг юм.

Хоёрт, олон жилийн туршлагын үндсэн дээр үйлчилгээний хураамжийн орлогын хэмжээг төсөв хуваарилахаас илүү урьдчилан тооцох боломжтой байдаг. Энэ нь үйл ажиллагааны дунд шатны, тэр бүү хэл стратегийн хэтийн төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулахад нэн ач холбогдолтой.

Гуравт. улсын төсвөөс санхүүжиж байгаа өргөн нэвтрүүлгийн байгууллага бүх талаараа улсынх байх нь тодорхой. Ялангуяа тухайн өргөн нэвтрүүлгийн байгууллагын ажилтнууд нь улсаас тогтоосон цалингийн сүлжээнд хамрагдана. Энэ нь арилжааны өргөн нэвтрүүлгийн байгууллагатай өрсөлдөөн бүхий тогтолцоонд хямралт байдал бий болгодог. Харин үйлчилгээний хураамжаар санхүүждэг байгууллага нь өөрийгөө захирах эрхтэй болохыг шаардах нь зүй бөгөөд олон нийтийн хяналт дор үйл ажиллагаа явуулна.

Үйлчилгээний хураамжийн хамгийн гол, бас нэг давуу тал бол хураамж төлж, өргөн нэвтрүүлгийг хүлээн авч буй иргэд түүнийг эрхлэгчдийн хоорондын сэтгэл зүйн чухал холбоо юм. Иргэд юунд мөнгөө

төлж байгаагаа мэдэх учир үнэ цэнийг нь үнэлнэ. Өргөн нэвтрүүлэг эрхлэгч чухам хэнд нэвтрүүлэг зориулж буй, чухам хэн үүнд сэтгэл хангалуун байх ёстой вэ гэдгийг ухаарна.

Олон нийтийн хяналт

Олон нийт бол олон нийтийн өргөн нэвтрүүлгийн шимийг хүртэгсэд төдийгүй төлбөр төлөгч, мөн хянагч мөн.

Тэгвэл олон нийтийн хяналт гэж юу вэ?

Энэ нь олон нийтийн төлөөлөгчид бол тухайн олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын олон нийтэд үйлчлэх зорилгоо аль болох дээд зэргээр биелүүлэхийн баталгаа болдог юм.

Өргөн нэвтрүүлгийн удирдах зөвлөл

Олон нийтийн дээр дурьдсан төлөөлөгчид нь компанид бол хувьцаа эзэмшигчтэй харьцуулахуйц үүрэг хүлээдэг. Өргөн нэвтрүүлгийн зөвлөл тухай өргөн нэвтрүүлгийн байгууллагадаа хамаарагддаг ч байж болно, эсвэл тусдаа хараат бус этгээд байж болно. Олон нийтийн төлөөлөгчдийг 2 өөр загвараар өөр өөр аргаар байгуулж болно.

- **Нэгд**, иргэний нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага, бүлэг Зөвлөлд өөрсдийн сонголтоор төлөөлөлөө холимог хугацаатайгаар батлан томилдог. Үүнд жишээ нь, их сургууль, урлаг соёлын байгууллага, сүм хийд, зохиолч, сэтгүүлч, хөгжимчин, газрын эзэн, эмэгтэйчүүд, залуучууд, спортын холбоод, байгаль орчин хамгаалагчид, ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийнхэн гэх мэт байж болно.
- **Хоёрт**, тодорхой тооны гишүүдийг (9 эсвэл 12), Парламент эсвэл хэд хэдэн олон нийтийн байгууллагаас (жишээ нь 1/3 нь Их хурал, 1/3 нь Засгийн газар, 1/ 3 нь Ерөнхийлөгчөөс) томилдог байна. Удирдах зөвлөлийн гишүүд нь иргэний нийгмийн ашиг сонирхлыг төлөөлөх учир хэрэг дээрээ өөрсдий нь томилсон этгээдүүдийн улс төрийн үзэл бодол, эрх ашгийг төлөөлөхгүй байх арга замыг хамгийн зохистой хангаж өгөх ёстой.

Өргөн нэвтрүүлгийн зөвлөл нь 3 гол үүрэгтэй.

- Тухайн байгууллагын ахлах албан тушаалтан бөгөөд бүх нэвтрүүлэг хөтөлбөрийн төлөө эхний бөгөөд эцсийн хариуцлага хүлээх Ерөнхий захирлыг томилох;
- Байгууллагын захиргаа, санхүүгийн асуудлаар хяналт, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий Захиргааны зөвлөлийг томилох;
- Хөтөлбөрийг шинэчлэх, боловсронгуй болгох талаар зөвлөгөө өгөх, тэр бүү хэл шаардлага тавихуйц байдлаар түүнд хяналт шалгалт хийх;

Дүгнэж хэлбэл, олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлэг гэдэг нь олон нийтэд зориулагдсан, олон нийтээс санхүүждэг, олон нийтийн хяналттай гэсэн үг юм. Тэгвэл өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн мөрдөх гол зүйл гэж юу вэ?

Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийн мөрдөх зарчим

Тухайн улсын хууль тогтоомжийн арга барил, зан заншил, ялангуяа эдийн засаг, нийгэм, түүх болон бусад бодит байдал нь өөр өөр учир мөрдөх зарчим нь бас өөр өөр байдаг. Гэсэн хэдий ч хаана ч түгээмэл нийтлэг зүйл байдаг. Европын Зөвлөл (1994 оны Прагийн Сайд нарын Бага хурал), Европын Парламент (Европын Холбооны) нар доорхи нийтлэг зарчмыг мөрдөхийг хүлээн зөвшөөрчээ.

Прагийн тогтоол

“Радио, телевиз болон өргөн нэвтрүүлэг нь ардчилсан нийгмийн улс төр, хууль эрх зүй, нийгмийн тогтолцооны үнэт зүйлсийг дэмжихийн зэрэгцээ ялангуяа хүний эрх, улс төрийн олон ургальч үзлийг хүндэтгэн үзэж байна.”

“Ардчилсан нийгэмд олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлэг чухал ач холбогдолтой.”

“Хүн бүрт хүртээмжтэй олон ургальч харилцаа холбооны зайлшгүй хүчин зүйл тул олон нийтэд үйлчлэх өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг эн тэргүүнд чухалчлана.”

“Олон нийт, бүлэг, давхаргат хүртээмжтэй байж, нийгмийн бат нэгдэл, хувь хүмүүс, хэсэг бүлгийг нэгтгэх хүчин зүйл мөн.

“Соёл, хүйс, шашин шүтлэг, ялгаварлан гадуурхах хийгээд нийгмийн ялгааны аливаа хэлбэрээс татгалзана.

“Олон нийтийн хэлэлцүүлэг мэтгэлцээний аль болох өргөн хүрээтэй үзэл бодол, санаа бодлын индэр байна.”

” Мэдээ, мэдээлэл, тайлбар шударга, алагчлалгүй, тал тохой татаагүй, хараат бус байна.”

“Өндөр ёс суртахуун, чанарын хэм хэмжээнд нийцсэн олон ургальч, шинэлэг, олон хэлбэрийн хөтөлбөртэй байна.”

“Зах зээлийн хүчин зүйлд дулдуйдахгүй, золиослогдохгүй байна.”

” Өргөн олон түмний ашиг сонирхолд нийцсэн хөтөлбөр, үйлчилгээг хангахдаа хүн амын цөөнхийн хэрэгцээг тусгана.”

“Үндэстэн ястан хоорондын харилцан ойлголцол, хүлцэл (толерантност), эв найрамдлыг бэхжүүлэх, янзын бүрийн үндэстэн угсаатан, олон хэлбэрийн соёл бүхий нийгмийг хөхүүлэн дэмжих зорилгоор нийгэм дэх гүн ухааны янз бүрийн санаа, шашны итгэл үнэмшлийг илэрхийлнэ.”

ЕВРОПЫН ПАРЛАМЕНТИЙН ТОГТООЛ

1996 оны Европын Парламентын тогтоол дээрхтэй маш ойролцоо утга агуулгатай бөгөөд зарим нэгийг жишээ татав.

“ Олон нийтийн санаа бодлыг бүрдүүлж, нэгэн цогц болгодог нийгмийн янз бүрийн бүлэг давхаргыг төлөөлөх олон ургальч үзлийг дэлгэрүүлэгч, тодорхой мэдээлэл бүхий иргэдэд туслагч юм.”

“Нийт хүн амд бүхий л төрөл зүйлээр бүтээсэн чанартай бүтээгдэхүүнийг өргөн хүрээгээр толилуулна.”

“Үзэгч, сонсогчдын талархан хүлээн авдаг, алдартай хөтөлбөр нэвтрүүлэгт чанарын хэм хэмжээ тогтооно.”

“ Цөөнхийн ашиг сонирхолд болон хүн амын янз бүрийн хэсэг бүрт хүрч үйлчилнэ.”

“Түргэн өргөжиж буй мэдээллийн зах зээлийг мэдэрч, үзэгч, сонсогчдын итгэлийг хүлээхүйц чадвар бүхий мэдээ сурвалжлага, уран сайхны нэвтрүүлэгт ч алагчлалгүй, тал тохой татаагүй, бүрэн хараат бус мэдээллээр хангана.”

“Ардчилсан үйл явцыг төгөлдөржүүлэхэд туйлын чухал болох олон нийтийн мэтгэлцээнийг хөхүүлэн дэмжихэд голлох үүрэг гүйцэтгэж, нийгмийн бүхий л бүлэг давхарга, байгууламжийн индэр болно.”

“Спортын уралдаан тэмцээн зэрэг нийт олон нийтийн ашиг сонирхол бүхий үйл явдлуудыг нийт хүн амд хүргэх”

Өргөн нэвтрүүлгийн цаашдын гүйцэтгэх үүрэг

Эцэст нь хэлэхэд, өргөн нэвтрүүлгийн ирээдүй нь түүний эрхэм зорилго, иргэний нийгэмд болон түүний төлөө гүйцэтгэх үүргээр тодорхойлогдоно. Мэдээллийн эх сурвалж улам олон янз, улам хувийн шинжтэй болж, үзэгч, сонсогч хуваагдахын хэрээр өнөөгийн нөхцөлд үндэсний хэмжээний, улс үндэстнээ хүндэтгэсэн олон нийтийн санаа бодлыг уралдуулах үүрэг хүлээсэн, үгүйдээ нэг хүчтэй үйлчилгээг дэмжих нь чухал болж байна. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн санхүүжилтийн хувьд Прагийн Сайд нарны Бага хуралд оролцсон улс орнууд “ОНӨН эрхлэгчийг өөрсдийнх нь зорилгыг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг бий болгох” тухай тохиролцсон юм. Ийм утга үгийг Европын Парламентын тогтоолд ч бас хэрэглэсэн байдаг.

Үүний зэрэгцээ техник технологи хөгжиж (тоон систем нягтрал г.м), нэвтрүүлгээ хүргэх хэлбэрүүд (сансарын хиймэл дагуул, кабель, интернет) нэмэгдэж, сэдэвчилсэн сувгаар дамжуулдаг олон төрлийн хөтөлбөрүүд бий болж, санхүүжилтийн шинэ арга (төлбөртэй телевиз, төлбөртэй суваг) нэвтрэхийн хэрээр ОНӨН ч бас нүүрээ улайлгахгүйгээр цаг үеийн шаардлагын дагуу хамгийн зохистой хэлбэрээр олон нийтэд үйлчлэх ёстой.

Боломж

ОНӨН-ийн мөн чанарыг бүрэн ойлгосон бол хэрэгжүүлэхэд бодитой санагдаж байна уу? Ийм өргөн нэвтрүүлэггүй улс оронд үүнийг байгуулах бодит боломж байна уу?

Зөвхөн төрийн мэдлийн, эсвэл зөвхөн арилжааны нэвтрүүлэгтэй улс орнууд ОНӨН-тэй болох нь гагцхүү улс төрийн гол асуудалтай холбоотой болох нь :

Өргөн нэвтрүүлэг нь төрийн эзэмшилд хэвээр байгаа улс орнуудад түүнд тавих хяналтаа зогсоох, түүнийг олон нийтэд үйлчилдэг жинхэнэ хараат бус болгон өөрчлөн шинэчлэх талаар эрх мэдэлтнүүдийг ухуулж ятгах нь хялбар, амар биш юм. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд эдгээр улс оронд ардчиллын утга учир, зарчмуудыг ойлгон ухамсарлаж, иргэд анхаарлын төвд байх болжээ. Ардчилал иргэдээс эхэлдэг ч гэсэн тэд өргөн хүрээтэй бодит мэдээлэл авч чадахгүй бол жинхэнэ ардчилал үгүй. Төв ба Зүүн Европ, дэлхийн бусад олон оронд байдал ийм байна. Ийм орнуудад ОНӨН-ийн үнэ цэнийг гойд ойшоохгүй байгаа ч өнөөдрийн нөхцөл байдалд төрийн эзэмшлийн өргөн нэвтрүүлэг ийм маягаар байгаад байвал цаашид утга учиргүй гэдэг нь тодорхой болжээ.

Төрийн мэдлийн өргөн нэвтрүүлэг цэцэглэж байсан цаг үеийг өнөөдрийнхтэй харьцуулахад олон улс оронд огт өөр нөхцөл байдал бий болсон байна.

- Харилцаа холбооны салбарт том хэмжээний өөрчлөлт гарч, төрийн зохицуулалт үгүй болсон.
- Арилжааны өргөн нэвтрүүлэг бий болж, түүнийг хүлээн зөвшөөрч аль болох бага зохицуулдаг болсон.
- Дэлхийн, гадаадын өргөн нэвтрүүлэг үндэсний хил хязгаарыг үл харгалзан түгэж, тухайн орны хэл дээр, эсвэл нийт хүн амын тодорхой хэсгийн ойлгодог хэлээр нэвтрүүлэх болов.
- Техникийн хөгжил, ялангуяа тоон систем, нягтрал олон нэмэлт суваг бий болох боломж олгож байна

- Интернэтийн нэвтрүүлэг мөн л хил хязгааргүй цацагдаж дуу авиа, дүрс дуу авианы тоймгүй олон хөтөлбөр бий болж байна.

Ийм нөхцөлд төр өөрийн өргөн нэвтрүүлгээр дамжуулан мэдээлэлд нөлөөлж , түүнд, тэр бүү хэл хүмүүсийн санаа бодолд хяналт тавина гэдэг үнэхээр утопи бодол юм.

Хүн амын харьцангуй цөөн хэсэг төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн хэрэгслээс, дийлэнх нь хаа сайгүй тархаж буй мэдээллийг хүртдэг. Төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийн хэрэгслээс мэдээлэл авч буй хүмүүс ч түүнд шүүмжлэлтэй, үл итгэсэн маягтай хандах болно. Учир нь түүнийг бусад мэдээлэлтэй харьцуулах бүрэн боломж байгаа юм.

Ийм учраас төрийн өргөн нэвтрүүлгийн хэрэгсэл удаан хугацаанд оршин тогтнохгүй нь ойлгомжтой бөгөөд түүнийг ардчилсан замаар олон нийтийн болгон өөрчлөх нь муугүй билээ.

Жинхэнэ хараат бус олон нийтийн өргөн нэвтрүүлэгтэй болж зохицож амьдрах нь эрх мэдэлтнүүдээс ихээхэн зүрх зориг шаардах нь мэдээж. Гэсэн хэдий ч тэднийг иргэд сонгосон бөгөөд иргэдийн туйлын эрх ашиг, сонирхолд үйлчилнэ гэдэг цорын ганц зорилго нь мөн гэдгийг цагт ямагт санаж явбал зохино.

Арилжааны өргөн нэвтрүүлэгтэй улс орнууд

Арилжааны өргөн нэвтрүүлэгтэй улс оронд ОНӨН-тэй болох, ялангуяа жинхэнэ хараат бус ОНӨН-ийн амин чухал зүйл болох заавал төлөх үйлчилгээний хураамжаар санхүүжих систем бий болгоход зайлшгүй дэмжлэг олж авах нь түвэгтэй асуудал юм.

Өргөн нэвтрүүлэг нь олон жилийн турш зах зээлийн хуульд захирагдан үйл ажиллагаагаа явуулж байсан тохиолдолд хүмүүс өөр нэгэн хэрэгцээ, эсвэл өөр нэгэн зүйлийг илүү хүсэн хүлээж болох юм. Анх 1970 онд АНУ-д олон нийтийн өргөн нэвтрүүлэг бий болоход урьд нь үнэ төлбөргүй радио телевиз үзэж дассан хүмүүсээс үйлчилгээний хураамж авна гэдэг хамгийн том бэршээл байлаа.

Ер нь өргөн нэвтрүүлгийн бүх төрөл хэлбэр бүгд ямар нэг байдлаар иргэдээс санхүүждэг. Энэ нь төрд татвар төлөгч (улсын санхүүжилт), үйлдвэрлэгч, үйлчлэгч (зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг), сувгийн захиалагч (төлбөртэй телевиз), хүлээн авагч-эзэмшигч (хураамжийн төлбөр) байж болно. Аль ч тохиолдолд хэрэглэгч-иргэнд сонголт байхгүй. Тэр төлбөр хийх үүрэгтэй.

- Хэрэв иргэн татвар төлөгч бол төрийн ашиг сонирхлыг хамгаалсан нэвтрүүлэг, хөтөлбөрийг санхүүжүүлнэ гэсэн үг.
- Хэрэв иргэн зар сурталчилгаа, ивээн тэтгэгчээр дамжуулан төлбөр хийж байгаа бол (радио телевизээр сурталчлагдаж буй бүтээгдэхүүнийг худалдан авч үйлчилгээг хүртэж байгаадаа) тэр арилжааны өргөн нэвтрүүлэг эрхлэгчийн үзэгчдийн тоогоо дээд зэргээр нэмэгдүүлэх, ашгаа дээд зэргээр нэмэгдүүлэх зорилготой нэвтрүүлэг, хөтөлбөрийг санхүүжүүлнэ гэсэн үг.
- Хэрэв иргэн тодорхой сувгийн нэвтрүүлгийн захиалагч бол тэр үйлчилгээндээ төлбөр өгч байна гэсэн үг.
- Хэрэв иргэн үйлчилгээний хураамжаар дамжуулан төлбөр хийж байгаа бол өөрт нь иргэнийх нь хувьд зориулагдсан олон нийтийн үйлчилгээг санхүүжүүлнэ гэсэн үг.

Өргөн нэвтрүүлгийн бүх төрөл хэлбэр хэрэглэгч-иргэдээс санхүүжиж байгаа нь ойлгомжтой тул иргэд яагаад чухамхүү өөрт нь зориулагдсан өргөн нэвтрүүлгийг бус, харин эрх мэдэлтнүүдэд үйлчилдэг байгууллагыг санхүүжүүлэх ёстой билээ?



ОЛОН НИЙТЭД ҮЙЛЧИЛДЭГ ТЕЛЕВИЗ РАДИО:

ХУУЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Тоби Мендель

Хуулийн Хөтөлбөрийн Дарга
“19 ДҮГЭЭР ЗҮЙЛ” байгууллага

ОРШИЛ

Түүхийн явцад олон нийтийн хэтэвчээс санхүүждэг үндэсний телевиз радиогийн байгууллагууд ихэнхи орнуудад тус салбарын зайлшгүй чухал нэг хэсэг болж хөгжсөн бөгөөд арилжааны телевиз радиогийн нэвтрүүлгээс ялгаатай шинж чанартай нэвтрүүлгийн сүлжээгээ олон нийтэд хүргэх эдгээр байгууллагуудын зорилго нь одоо хүртэл хүчтэй хэвээр байна. Нөгөөтэйгүүр, олон нийтээс санхүүждэг телевиз радиогийн байгууллагуудад дараахи хоёр зүйл аюул учруулдаг. Нэгдүгээрт, эрх баригч хүчнүүд олон нийтээс санхүүждэг телевиз радиогийн байгууллагуудад тавих хяналтаа улам чангалах оролдлого байнга хийдэг нь тэдгээр байгууллагуудын хараат бус байдлыг алдагдуулж, мэдээ болон бусад нэвтрүүлгийн чанарыг бууруулах явдал олон орнуудад ажиглагддаг. Хоёрдугаарт, аливаа засгийн газарт уг байгууллагуудын үйл ажиллагааны төсвийг хасах хүсэл тогтмол байдаг бөгөөд энэ нь тэдгээрийн олон нийтийн санхүүжилтийн дарамтыг ихэсгэдэг ба санхүүжилтийн бусад эх үүсвэр хайхад хүргэдэг юм.

Энэ судалгаа нь үндэсний, олон нийтээс санхүүждэг телевиз радиог ихээхэн дэмждэг Австрали, Канад, Франц, Япон, Өмнөд Африк болон Нэгдсэн Вант Улс зэрэг зургаан оронд эдгээр байгууллагуудын удирдлагын ба санхүүжилтийн хувьд хэрхэн зохион байгуулдаг туршлагаас уншигч Таньд толилуулах болно. Судалгааны гол чиглэл нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн эдгээр байгууллагуудын олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, удирдлагын бүтэц ба санхүүжилтийн журам зэрэг хууль эрх зүй болон зохион байгуулалтын асуудлууд юм. Судалгаа нь дээр дурдсан аюултай хэрхэн тэмцэж, түүнчлэн тус байгууллагуудын нийтлэлийн эрх чөлөө, хараат бус байдлыг баталгаажуулахын зэрэгцээ олон нийтийн өмнө хүлээсэн үүргийг хэрхэн тооцож санхүүжилтийг олгох нөхцлийг хэрхэн бүрдүүлсэн талаар танилцуулах болно.

Өнгөрсөн үед олон нийтээс санхүүждэг төвийн байгууллага нь цорын ганц үндэсний радио, телевиз байсан болоод дэлхийн ихэнх орнуудад энэхүү байгууллагууд одоо хүртэл ноёрхож байна. Түүнчлэн, олон орнуудад нийт олон түмэн олон нийтээс санхүүждэг телевиз радиод үнэнч хэвээрээ бөгөөд энэ нь олон нийтийн дэмжлэг, засгийн газрын санхүүжилт болон сонсогч үзэгчдийн тоогоор илэрхийлэгддэг. Үүнд хэд хэд үндэслэл шалтгаан бий. Тус байгууллагууд нийгмийн бүх бүлэг, хэсэг хүмүүсийн хэрэгцээг хангасан өргөн хүрээний чанартай нэвтрүүлэг бэлтгэн олон түмний хүртээлд цацах

баталгаа гаргаж өгөх чадалтай. Тус салбар дахь бусад байгууллагууд, үүний дотор арилжааны сувгууд зохих хэмжээнд хангахгүй байгаа мэдээллийн хэрэгцээ ба сонирхолыг олон нийтийн телевиз радио хангаж үр ашигтай үйл ажиллагаа явуулах боломжтой. Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн тэргүүлэх байгууллагууд нь өргөн хүрээний нэвтрүүлгийн сүлжээг ажиллуулж аливаа зүйлийг мэдэх олон нийтийн эрх чөлөөг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг юм. Мөн үндэсний үзэл бодол болон ардчилсан ба аливаа эрх чөлөөг хүндэтгэх соёл заншлийг хөхүүлэн дэмжих төв болон үйл ажиллагаагаа явуулдаг.

Гэвч олон орнуудын засгийн газар төрөөс санхүүждэг телевиз радиод тавих хяналтаа улам өргөжүүлэх бодлого явуулдаг бөгөөд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилго бус харин засгийн газрын цагаан хоолой мэтээр эдгээр байгууллагуудыг ашигладаг. Хараат бус байдал болон олон нийтэд үйлчлэх үүргээ хууль зүй болон зохион байгуулалтын хувьд баталгаажуулсан тохиолдолд л эдгээр байгууллагууд нь олон нийтийн сонирхолд үйлчилж олон талт чанартай мэдээллийг олон нийтэд түгээдэг боломжтой болдог билээ.

Арилжааны болон телевиз радиогийн бусад хэлбэр маш хурдацтай хөгжиж байгаа нь олон нийтээс санхүүждэг телевиз радиогийн өмнө шинэ зорилт тавьж байна. Технологийн хөгжил телевиз радиогийн салбарыг үндсээр нь өөрчилж дэлхийн олон орнуудад нэг өрх арав ба түүнээс дээш суваг хүлээн авах боломжтой боллоо. Дижитал технологи нь хязгаарагдмал давтамжтай долгионоор олон тооны сигнал хүлээн авах боломж олгож агаарын долгионыг олон тооны телевиз радиогийн байгууллагуудад нээлттэй болгосон билээ. Хиймэл дагуулыг болон кабелийн сүлжээний хөгжил ахиц нь телевиз радио дэлхий даяр улам нээлттэй болгоход маш их нөлөө үзүүлж байна. Мөн дээрхи технологийн хөгжилтэй холбоотой өөрчлөлтийн зэрэгцээ телевиз радио үүсгэн байгуулахтай холбоотой зардал ч улам багасаж байна. Интернетийн сүлжээ одоо байгаагаас илүү сонирхолтой бөгөөд хялбар боломжуудыг олгож удахгүй тусгай бус харин суурь тоног төхөөрөмжтэй хүн бүр телевиз радиогийн үйл ажиллагаа эрхлэх болно.

Дээр дурдсан хөгжлийн хандлагууд засгийн газрын хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг телевиз радиод аюул учруулж байгаа юм. Олон тооны иргэд засгийн газрын цагаан хоолой болох үндэсний телевиз радио гэхээсээ илүү, боломжтой бол хараат бус арилжааны сувгууд үзэх сонирхолтой байдаг. Энэ нь олон нийтээс санхүүждэг телевиз радиод үзүүлэх дэмжлэгийг багасгаж, яваандаа олон нийтийн ашиг сонирхолыг шамшигдуулах аюултай. Ийм нөхцөлд засгийн газрын хяналт нь хүсэж хүлээж буй үр дүнд хүрэхээ больсон гэдгийг сонсогч үзэгчдийн тоо буурч буй статистикийн тоо мэдээ илэрхийлдэг бөгөөд эцэст нь засгийн газрын дэмжлэг ч багасахад хүргэдэг.

Засгийн газрын уламжлалт үүргийн тухай давамгайлсан ойлголт өөрчлөгдөж буйтай холбогдоод олон нийтээс санхүүждэг телевиз радиогийн хувьд шинэ сорилтууд бий болж байна. Засгийн газрыг цомотгох ба төрийн өмчийн үйлдвэрлэлийн салбар болон байгууллагуудыг хувьчлах, үйл ажиллагааг нь арилжааны чиглэлтэй болгон өөрчлөх хандлага сүүлийн үед хүчтэй хэрэгжиж байна. Зам засвар болон нийтийн үйлчилгээ зэрэг олон нийтийн эх үүсвэрээс уламжлалт ёсоор санхүүждэг үйл ажиллагаа хүртэл энэхүү хандлагад автагдсан юм. Үүний зэрэгцээ, жишээлвэл эрүүл мэндийн үйлчилгээ болон боловсрол зэрэг салбаруудад олгох санхүүжилтийн хэмжээг ихэсгэх шаардлага хурцаар тавигдаж байгаа нь олон нийтийн эзэмшил дэхь санхүүгийн хомс эх үүсвэрт улам их дарамт үзүүлж байна.

Дээрхи нөхцөлд үндэсний телевиз радиод олон нийтийн зүгээс үзүүлэх шууд тусламжийн хүрээ болон эх үүсвэрийн тухай асуудал улам хурцдаж буй бөгөөд зарим орнуудад арилжааны шинж чанартай нэвтрүүлгийн сүлжээг нөхөн орлох шинэ арга замыг эрчимтэй судлахад хүргэсэн билээ. Энэхүү бусад арга замын нэг нь хувийн телевиз радиод олон нийтийн өмнө хүлээх зарим үүргийг даалгах явдал мөн. Олон

орнуудад энэхүү шийдлийг үйл ажиллагаа явуулах эрх бүхий бүх телевиз радиогийн байгууллагын хувьд хэрэгжүүлдэг боловч хууль эрх зүйн орчныг өөрчлөн тус салбарын байгууллагуудад үйл ажиллагаагаа явуулахад нь таатай нөхцөл бүрдүүлэх ерөнхий хандлага бий болоод байна. Учир нь үндэсний засгийн газруудын хувьд тус салбарын үйл ажиллагааг үр ашигтай зохицуулахад улам их хүндрэл гарч байгаатай холбоотой юм.

Олон нийтийн сонирхол хэрэгцээг хангадаг аливаа нэг нэвтрүүлгийн сүлжээнд олон нийтийн санхүүжилт олгох бусад хэлбэрийг хайх нь бас нэг шийдэл болно. Зарим орнуудад телевиз радиогийн тодорхой байгууллагад харьяалагдахгүй, хараат бус нэвтрүүлгийн продюсер зарим нэг нэвтрүүлэгтээ олон нийтээс санхүүжилт авч болох нь энэхүү хэлбэрүүдийн нэг юм. Нөгөө талаас, хувийн телевиз радиогийн байгууллага нь олон нийтийн хэрэгцээнд зориулан бэлтгэн цацдаг зарим нэвтрүүлэгтээ олон нийтээс санхүүжилт авах захиалга өгөх хэлбэр байж болно. Телевиз радиогийн бусад байгууллагууд хангахгүй байгаа нийгмийн ба олон нийтийн хэрэгцээг коммюнити телевиз радио хангаж улам чухал үүрэг гүйцэтгэх болоод байна. Хараат бус продюсеруудаас бэлтгэн гаргасан нэвтрүүлгийг өөрийн нэвтрүүлгийн сүлжээнд тодорхой хэмжээгээр оруулахыг олон нийтээс санхүүждэг телевиз радиогийн байгууллагуудаас шаардах нь нийтлэг туршлага болсон билээ.

Дээр дурьдсан бусад арга зам, хэлбэрүүдийн ач холбогдол өсөж шинэ боломж үүсэж байгаа боловч дэлхийн ихэнх орнуудад үндэсний телевиз радиогийн байгууллага буюу олон нийтээс санхүүждэг хэд хэдэн телевиз радиогийн байгууллагууд энэ салбар дахь олон нийтийн хэрэгцээг голчлон хангаж байна. Дээрх байгууллагуудын зарим нь олон нийтийн зүгээс хүчтэй дэмжлэг авдагийн учир нь эдгээр байгууллагууд засгийн газар болон бусад нөлөөллөөс хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулж, хувийн телевиз радиогийн нэвтрүүлгийг нөхөн орлох чанартай нэвтрүүлгийн сүлжээг бий болгон нэвтрүүлж буйд оршино.

Дээрх нөхцлийг хангаж үйл ажиллагаагаа явуулдаг телевиз радиог “олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага” гэж нэрлэдэг бөгөөд тэдгээр нь хэд хэдэг онцлог шинж чанартай байдаг. Энэ судалгааны эхний бүлэгт дээрхи онцгой шинж чанарыг товч тайлбарлах болно. Хоёр дахь бүлэг нь төрөл бүрийн шүүх танхим болон албаны байгууллагуудаас тодорхойлсон хүний эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг асуудалтай холбоотой олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд мөрдвөл зохих олон улсын стандартыг танилцуулна.

Судалгааны дараа дараагийн бүлгүүдэд тухайн орны олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага буюу байгууллагуудын дүн шинжилгээг уншигч Таньд толилуулна. Орон орны бүлэг бүр “Оршил”, “Үйл Ажиллагаа”, “Олон Нийтэд Үйлчлэх Үүрэг”, “Удирлагын Тогтолцоо Үдотод Удирлага ба Зохицуулах механизм” болон “Санхүүжилт” гэсэн таван гол сэдвээр тус тус хуваагдсан болно. “Үйл ажиллагаа” нэртэй хэсэг нь үндэсний олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын гол үйлчилгээ, нэвтрүүлгийн сувгийг танилцуулна. “Олон нийтэд үйлчлэх үүрэг” нь тус байгууллагуудын хуулийн болон захиргааны тусгай үүрэг хариуцлагыг тайлбарлана. “Удирлагын тогтолцоо” нь хоёр хэсэгт хуваагдсан бөгөөд эхний хэсэг тухайн байгууллагуудын дотоод удирдлага, түүний зохион байгуулалт, хоёр дахь хэсэг нь тэдгээрийг удирдаж хянах үүрэг бүхий бусад байгууллага, этгээдийг танилцуулах болно. Сүүлийн хэсэг тус байгууллагуудын санхүүжилтийн гол эх үүсвэрийг Та бүхэнд танилцуулна.

Судалгаанд хамрагдсан зургаан орны олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудыг танилцуулсан бүлгүүдийн дараагийн бүлэгт тус байгууллагуудын туршлага, зохион байгуулалтыг харьцуулсан хоёр хүснэгт багтана. Үүний дараа олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын зорилгуудыг үнэлэн шинжилсэн, орон бүрийн туршлага, зохион байгуулалтын эерэг болон сөрөг талыг танилцуулна.

ОЛОН НИЙТЭД ҮЙЛЧИЛДЭГ ТЕЛЕВИЗ РАДИОГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОНЦГОЙ ШИНЖ ЧАНАР

Төрөөс санхүүждэг телевиз радиогийн байгууллагууд дэлхийн ихэнхи орнуудад байдаг. Гэвч эдгээр телевиз радиогийн зөвхөн зарим хэсэг нь л олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудад хамаарах стандарт, жишигт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг юм. Судалгааны энэхүү хэсэг олон нийтэд үйлчилдэг байгууллагуудын нийтлэг шинж чанарыг танилцуулж байна.

Ерөнхийдөө, олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд хэд хэдэн онцгой шинж чанартай бөгөөд тэдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаанд үндэслэсэн байдаг. Нэмж хэлэхэд, эдгээр онцлогууд нь телевиз радиогийн ажиллагаа тодорхой нийтлэг зарчмын дагуу олон нийтийн эх үүсвэрээс санхүүждэгтэй холбоотой юм. Эрик Барентын тэмдэглэсний дагуу олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага доорхи гол зургаан онцлогтой . Үүнд:

- Газар зүйн тархалт
- Үндэсний үзэл бодол болон соёлыг илэрхийлсэн бодлого
- Төрийн болон арилжааны сонирхолоос хараат бус байдал
- Аливаа нэгэн талын үзэл бодлыг баримтлахгүй нэвтрүүлгийн бодлого
- Нэвтрүүлгийн өргөн хүрээ болон төрөл
- Хэрэглэгчдийн хураамжаас ордог их хэмжээний санхүүжилт

зэрэг зургаан онцлог багтана.

Энэ зургаан онцлогийг Нэгдсэн Вант улсын засгийн газрын 1994 оны Би Би Си Корпорацийн ирээдүйн тухай тайланд тодорхой тусгасан байдаг билээ.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын эхний онцлог нь тус үйлчилгээний олон нийтийн мөн чанартай шууд холбоотой юм. Бүс нутаг болгонд ижил төрлийн үйлчилгээ үзүүлэхгүй боловч олон нийтийн үйлчилгээг тухайн хүн амын зөвхөн нэг хэсэгт зориулан бий болгох нь буруу зүйл. Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд аливаа зүйлийг мэдэх олон нийтийн эрх чөлөөг тус улсын нутаг даяар ижил тэгш хангах үүрэгтэй болохоор энэхүү онцлог шинж чанар нь тус байгууллагуудын хувьд чухал юм.

Хоёр дахь онцлог болох үндэсний үзэл бодол ба соёлыг илэрхийлж тусгасан бодлого нь олон орнуудад олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын маш чухал, зайлшгүй хүлээх үүрэг хариуцлага байсан бөгөөд одоо хүртэл ч хэвээрээ байгаа юм. Энэ нь үндэсний үзэл бодол, үндэсний бахархал болон үндэсний үйл хэрэгт хамаарах сэтгэлгээг бий болгох тус байгууллагуудын үүргийг илэрхийлж байгаа билээ. Нөгөөтэйгүүр, энэхүү онцлог нь үндэсний ардчилсан, аливаа эрхийг хүндэтгэсэн соёлыг хөхүүлэн дэмжих, илүү өргөн утгатай олон нийтийн телевиз радиогийн байгууллагуудын үүрэг юм. Үүний зэрэгцээ, энэхүү үүрэг сөрөг талтай бөгөөд нийтлэлийн эрх чөлөөг хязгаарлахын зэрэгцээ хэт үндсэрхэх үзэл бодлын эх үүсвэр болох аюултай. Гэвч өнөө үед үндэсний үзэл бодлыг дэмжих бодлогыг зөвхөн тухайн оронд давамгайлж буй соёл уламжлалыг хөхүүлэн дэмжих гэсэн явцуу ойлголт үгүй болж тэрхүү бодлого нь олон талт соёлыг хөгжүүлэх гэдэг утгаар олон орнуудад хэрэгжиж байна.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын гол зорилго нь тухайн улсын хүн амын олон төрлийн болон өргөн хэрэгцээг тусгасан мэдээлэл, цэнгээнт ба боловсрол танин мэдэхүйн чанартай нэвтрүүлгээр хангахад оршино. Олон нийтийн телевиз радиогийн байгууллагууд арилжааны телевиз радиотой нэгэн адил арга замаар санхүүжилтийн төлөө өрсөлдөнө гэвэл энэхүү зорилгодоо хүрч

чадахгүй нь ойлгомжтой. Арилжааны чанартай үйл ажиллагаа давамгайлж буй нөхцөлд олон нийтийн телевиз радио нэвтрүүлгийн бодлого өөрчлөгдөж, олон нийтийн сонирхол бус харин тухайн нэвтрүүлгүүдийн сонсогч үзэгчдийн тоон дээр үндэслэн гол шийдвэрүүдээ гаргах нь зайлшгүй. Өнөөгийн байдлаар, олон нийтэд үйлчилдэг олон тооны телевиз радиогийн байгууллагууд олон нийт ба арилжааны үйл ажиллагаанаас олсон санхүүжилтийг хоёуланг ашиглаж байгаа боловч хувийн санхүүжилтаас хамааралтай байснаар тэдгээр байгууллагууд нь олон ургальч үзэл бодол болон дээр дурдсан бусад зорилгын хэрэгжилтийг шамшигдуулах нь ойлгомжтой. Иймд, олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хувьд арилжааны аливаа сонирхлоос хараат бус байж үйл ажиллагаагаа явуулах нь маш чухал зарчим юм.

Олон орнуудад олон нийтийн чанартай телевиз радиод учирч буй гол аюул нь төрөөс санхүүждэг телевиз радиог хяналтандаа байлгаж, өөрийн сонирхолд ашиглах гэсэн засгийн газрын оролдлогууд юм. Төрөөс санхүүждэг телевиз радиог олон нийтийн сонирхолыг шамшигдуулж, олон талт мэдээ мэдээллийг хүлээн авах иргэдийн эрхийг зөрчин засгийн газрын цагаан хоолой болон үйл ажиллагаагаа явуулдаг гэж шүүмжилдэг. Олон нийтээс санхүүжиж буй олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагад тухайн засгийн газар эсвэл төрийн аль нэгэн байгууллага нөлөө үзүүлэх нь зүй бус гэдэг нь ойлгомжтой бөгөөд үүнийг олон улсын ба тусгай хуулиудад хүлээн зөвшөөрсөн билээ. Гэвч арилжааны сонирхлоос хараат бус байснаар тус байгууллагууд олон нийтийн санхүүжилтээс хамааралтай болж, улмаар засгийн газрын нөлөөнд автагдах аюулд учирдаг юм.

Аливаа нэгэн талын үзэл бодлыг баримтлахгүй бодлого нь хараат бус байдлын зарчимтай нягт холбоотой зүйл болно. Засгийн газар олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагад олгож буй олон нийтийн санхүүжилтийг ашиглан өөрийн үзэл бодлын сурталчилах нь буруу гэж байгаа бол олон нийтийн өмнө үүрэг хүлээж буй олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага ч гэсэн аливаа нэгэн үзэл бодол эсвэл аливаа нэгэн улс төрийн намыг тусгайлан дэмжих нь бас буруу.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын тав дахь онцлог нь өргөн хүрээний ба олон төрлийн нэвтрүүлгийн сүлжээ ажиллуулж үүн дотроо боловсрол танин мэдэхүй ба мэдээллийн чанартай нэвтрүүлгүүдийг уг сүлжээндээ зайлшгүй багтаахад оршино. Энэ талаараа олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд дэлхийн олон орнууд дахь хувийн телевиз радиогоос ялгаатай бөгөөд хувийн байгууллагуудын хувьд кино болон шоу зэрэг бага өртөгтэй нэвтрүүлэгт үйл ажиллагаагаа чиглүүлэх хандлага ихэссэж байна. Өргөн хүрээний, олон төрлийн нэвтрүүлгийн сүлжээтэй байх олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын үүрэг нь аливаа зүйлийг мэдэх олон нийтийн эрх чөлөөнд тулгуурладаг ба өргөн хүрээний сэдэв ба тулгамдсан асуудлаар мэдээлэл авах боломжийг ард түмэнд баталгаажуулж өгдөг юм.

Барентд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын зургаа дахь онцлог нь хэрэглэгчдийн хураамжаас бүрддэг тэдгээрийн санхүүжилт гэж заасан. Доор тайлбарласнаар, олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд бүгдээрээ бус харин зарим нь л тухайн орны хууль эрх зүйн дагуу хэрэглэгчдийн хураамж эсвэл үйл ажиллагааны эрхийн хураамжаар санхүүждэг. Үүний оронд, олон орнуудад үндэсний хууль тогтоогч байгууллага буюу парламент нь тус байгууллагуудын төсвийг шууд санал хураалтаар шийдэж олгодог туршлага бий. Үйл ажиллагааны эрхийн хураамж үүнээс илүү тогтвортой санхүүжилтийн хэлбэр бөгөөд төрийн байгууллагууд энэхүү хураамжийн хэмжээнд хязгаарлалт тогтоож олон нийтийн телевиз радиогийн байгууллагуудын хооронд хуваариладаг боловч засгийн газрын хөндлөнгийн нөлөө багатай санхүүжилтийн хэлбэр мөн. Нөгөөтэйгүүр, хураамжийг цуглуулах үйл ажиллагаа хүндрэлтэй ба өндөр өртөгтэй байдгийн зэрэгцээ энэхүү санхүүжилтийн хэлбэр нэвтрээгүй орнуудад хураамжийн тухай асуудал улс төрийн хувьд хэцүү шийдвэр болж хувирдаг нь

батлагдсан билээ. Нэмж хэлэхэд, ерөнхий хураамжаар санхүүжиж буй байгууллагууд нэвтрүүлгийн чанараа сайжруулан, хүрээгээ өргөжүүлэхийн оронд хураамжийн хуваарилалтыг өсгөх үүднээс рэйтингийн төлөө өрсөлдөөнд автагдах нь ажиглагддаг.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Хүний Эрх Түгээмэл Тунхаглал \ХЭТТ\ нь олон улсын хуулинд тооцогддог олон улсын хүний эрхийн тухай гол баримт бичиг болоод дэлхийн улс орон бүр түүнийг мөрдөх ёстой. Энэхүү Тунхаглал үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дараахь байдлаар тусгадаг. Үүнд:

Хүн бүр өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй. Үүнд гадны аливаа оролцоогүйгээр өөрийн үзэл бодолтой байх, хэл хязгаарыг үл харгалзан бүхий л хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан аливаа мэдээлэл ба үзэл санааг эрэн хайх, хүлээж авах болон ашиглах эрх чөлөө мөн орно.

гэж заасан байдаг.

Олон Улсын Иргэний болон Улс Төрийн Эрхийн Пакт ЮУИУТЭП\ 145 орон гарын үзэг зурж хүлээн зөвшөөрсөн, олон улсын гэрээ бөгөөд ХЭТТ-д заасан хэд хэдэн хүний эрхтэй холбоотой заалтыг мөрдүүлэх зорилго бүхий хууль эрх зүйн баримт бичиг юм. Тус баримт бичгийн 19 Дүгээр зүйлд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ХЭЧТТ-ай ижил төстэй хэлбэрээр баталгаажуулсан байдаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг бүс нутгийн чанартай хүний эрхийн гол гурван баримт бичиг болох Хүний ба Ард Түмний Эрхийн тухай Африкийн Гэрээний 9 Дүгээр зүйл, Хүний Эрх ба Суурь Эрх Чөлөөг Хамгаалах Европын Конвенцийн 10 Дугаар зүйл, Хүний Эрх Чөлөөний тухай Америкийн Конвенцийн 13 Дугаар зүйлд мөн тусгаж баталгаажуулсан байдаг.

Ардчилалын хөгжлийг дэмжихэд суурь үүрэг гүйцэтгэдгийн хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ОУИУТЭП болон хүний эрхийн бусад олон улсын гэрээнд баталгаажуулсан хамгийн чухал эрх чөлөөний нэг мөн. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Чуулган 1946 онд болсон хамгийн анхны хурлаараа баталсан 59(1) Дүгээр Тогтоолдоо “Мэдээллийн эрх чөлөө нь хүний суурь эрх бөгөөд ... Нэгдсэн Үндэсний Байгууллагын мөрдөж хамгаалах .. эрх чөлөөнүүдийн гол нь мөн” гэж заасан билээ. Хүний Эрхийн Европын Шүүх Танхим нь үүнийг илэрхийлэхдээ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь \ардчилсан\ нийгмийн амин суурь бөгөөд түүний дэвшил ба хүн бүрийн хөгжлийн гол нөхцөл мөн Энэ нь зөвхөн эерэгээр хүлээж авах буюу эерэг нөлөөтэй бус харин төр засаг эсвэл нийгмийн аливаа хэсгийг доромжилон, цочирдуулсан буюу сатааруулсан “мэдээлэл” ба “санаа бодолд” хамаарна. Энэхүү эрх чөлөө нь олон ургальч үзэл бодол, бусдын үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чанар болон олон талт үзэл бодлыг хүлээж авах чадвар зэрэг ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай нөхцлийн дор хэрэгжинэ.”

гэж тусгасан байдаг.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа нь ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үүн дотроо телевиз, радио болон олон нийтэд үйлчилдэг телевиз, радиогийн байгууллагуудаар дамжуулан хэрэгждэг. Жишээлбэл, Хүний Эрхийн Нэгдсэн Америкийн Шүүх Танхим нь “ Үзэл бодлоо илэрхийлэх эрх

чөлөөг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бодит амьдралд хэрэгжүүлдэг” гэж тунхагласан билээ. Хүний Эрхийн Европын Шүүх Танхим “хуулийг дээдлэн хүндэтгэдэг Улсад хэвлэл мэдээлэл нь голлох үүрэг гүйцэтгэдэг” гэж заасан байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний дор хамгаалалтын онцгой үүрэг гүйцэтгэдэг нь “олон нийтийн сонирхол бүхий мэдээ, мэдээлэл ба санаа бодлыг” олон нийтийн хүртээлд хүргэх үүрэгтэй нэг талаар холбоотой юм. Хэвлэл мэдээлэл нь энэхүү мэдээ мэдээлэл болон санаа бодлыг олон нийтэд хүргээд зогсохгүй олон нийт ч мөн тэдгээрийг хүлээн авах эрхтэй. Эсрэг тохиолдолд хэвлэл мэдээлэл нь “олон нийтийн сонирхлыг хамгаалах хоточ нохойны” үүргээ хэрэгжүүлж чадахгүй.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэн хэрэгжүүлэх үүрэг хэвлэл мэдээллийн эрх зүйн үүрэг бус харин Төр засгийн үүрэг гэдгийг энд тэмдэглэх нь чухал. Гэвч энэхүү үүрэг төрөөс санхүүждэг телевиз радиогийн хувьд онцгой хамааралтай нь эдгээр байгууллагууд Төр засагтай хууль эрх зүйн холбоотой бөгөөд хүний эрхийн олон улсын хууль эрх зүйн баталгаа, заалтыг хэрэгжүүлэх тэдгээрийн үүрэгт шууд үндэслэдэг болно. Нэмж хэлэхэд, төрөөс санхүүждэг телевиз радиогийн байгууллагууд олон нийтийн аливаа зүйлийг мэдэх эрх чөлөөг ханган хэрэгжүүлэх онцгой байр суурь баримталж олон ургальч үзэл бодлыг баталгаажуулах ба сурталчилах үүрэгтэй учир эрх чөлөөний дээрхи төрлийг хөхүүлэн дэмжих нь тэгээрийн хувьд зайлшгүй ач холбогдолтой юм.

Олон ургальч үзэл бодол

ОУИУТЭП-ын 2 Зүйлийн дагуу аливаа Төр засаг “Тунхаглалд заасан эрх чөлөөг үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай хуулийн ба бусад бүхий л арга хэмжээ, нөхцлийг бүрдүүлэх” үүрэгтэй. Үүнийг тайлбарлахад, аливаа Төр засаг нь дээрхи эрх чөлөөг хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох бус харин үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зэрэг бусад ач холбогдол бүхий эрх чөлөөг баталгаажуулхад эерэг алхамыг авах нь зүйтэй гэж ойлгоно. Үүний үр дүнд аливаа засгийн газар нь олон талт, хараат бус хэвлэл мэдээлэл цэцэглэн хөгжиж олон нийтийн аливаа зүйлийг мэдэх эрхийг зохистой биелүүлэхэд тохиромжтой таатай нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй юм.

Үзэл бодлоо илэрхийлэх ба хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хөхүүлэн дэмжих Төр засгийн үүргийн нэг чухал хэсэг нь хэвлэл мэдээллийн хүрээнд олон ургальч үзэл бодлыг дэмжиж хүн бүр хэвлэл мэдээллийн аливаа хэлбэрийг ижил тэгш нөхцлөөр хүлээн авахыг баталгаажуулахад оршино. Хүний Эрхийн Европын Шүүх Танхимын тогтоосноор “Олон ургальч үзэл бодлын зарчимд тулгуурлаагүй нөхцөлд олон нийтийн ерөнхий сонирхол бүхий мэдээ мэдээлэл ба санаа бодлыг түгээх үүрэг амжилттай хэрэгжих боломжгүй”. Хүний Эрхийн Нэгдсэн Америкийн Шүүх Танхим зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь “харилцаа холбооны чанартай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ялгаварлан гадуурхах аливаа бодлогогүйгээр хүн бүрийн хүртээлд нээлтэй байх ёстой бөгөөд хувь хүн бүр энэхүү хэвлэл мэдээллийг хүлээж авахад аливаа хязгаарлал байх ёсгүй” гэсэн нөхцлийг шаарддаг.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын үйл ажиллагааны гол зарчмын нэг нь тэдгээр байгууллагууд олон ургальч үзэл бодлыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулхад оршино. Герман улсын Холбооны Үндсэн Хуулийн Цэц нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудад хэд хэдэн үүрэг ноогдуулж түүнийг үндсэн хуульд тусгасан билээ. Уг шалтгааны улмаас олон улсын хэд хэдэн тогтолцоо нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын ач холбогдол ба олон талт, олон ургальч үзэл бодлыг дэмжихэд оруулах эдгээр байгууллагуудын хувь нэмрийг онцгойлон заасан байдаг. Эдгээр тогтоолцоо бүгд зайлшгүй мөрдөх ёстой хууль эрх зүйн

чанартай биш боловч олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба ардчиллыг хөхүүлэн дэмжих үүргийг улам бататгаж байгаа явдал юм.

Жишээлбэл, Европын Зөвлөл *Зөвлөл ба Гишүүн Орнуудын Засгийн газрын Төлөөлөгчдийн Тогтоолдоо* олон төрлийн эх сурвалжаас үүсэл гаралтай мэдээллийн урсгалыг олон нийтийн хүртээлд хүргэх олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын ач холбогдол бүхий үүргийг хүлээн зөвшөөрсөн билээ. Европын Зөвлөл зах зээл ба мөнгөний нэгдсэн байдлыг бүрэн дэмжиж буй 15 гишүүн орноос бүрддэг. Тус зөвлөлийн Протоколд зааснаар олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд нь ардчилал, нийгмийн ба соёл уламжлалын хэрэгцээ болон хэвлэл мэдээлэл дэхь олон ургальч үзэл бодлыг дэмжих үйл ажиллагаанд шууд хамааралтай. Үүний дагуу гишүүн орнууд дахь эдгээр байгууллагуудын төрөөс авдаг санхүүжилт нь Амстердамын Гэрээний ерөнхий заалтаас чөлөөлөгдсөн байдаг. Мөн энэ шалтгааны улмаас ЮНЕСКО-гийн ивээл дор байгуулагдсан 1992 оны Алма Ата-гийн Тунхаглал нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудыг хөхүүлэн дэмжихийг бүх Төр засагт уриалсан билээ.

Олон Нийтийн Хэвлэл Мэдээллийн Бодлогын асуудлаар зохион байгуулагдсан Европ тивийн Сайд нарын Зөвлөлийн 4 дүгээр уулзалтаас гаргасан *“Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн салбарын ирээдүй” нэртэй 1 дугаар Тогтоол* дээрхи заасантай адил зарчмыг мөн дэмжсэн юм. Энэ Тогтоол хүний эрх ба нийт ардчиллын хувьд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд чухал үүрэг биелүүлдэгийг тэмдэглэхийн зэрэгцээ тэдгээр байгууллагууд нь өргөн хүрээний асуудлаар хэлэлцүүлэг олон нийтийн дунд өрнүүлэх, зах зээл арилжааны сонирхол бус нэвтрүүлгийн шинэ хэлбэрүүдийг зохион сэдэх, телевиз радиогийн үндэсний үйлвэрлэлийг дэмжихэд өөрийн үүргийг гүйцэтгэх ёстой гэж заасан билээ. Иймд тус Тогтоол бүх олон нийтэд хүртээлтэй, олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн хамгийн наад зах нь нэг байгууллага ажиллуулан үйл ажиллагааг нь баталгаажуулхыг гишүүн орнуудын Төр засагт зөвлөмж болгосон юм.

Хараат бус байдал ба санхүүжилт

Олон ургальч үзэл бодол болон мэдээ мэдээлэл, санаа бодлын чөлөөт урсгалыг олон аргаар, түүний дотор хэвлэл мэдээллээр дамжуулан бий болгон дэмжих Төр засгийн үүрэг нь телевиз радиогийн байгууллагуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдахыг зөвшөөрдөггүй юм. Үйл ажиллагааны эрх олгох зохицуулалт нь агаарын долгионыг зөв зохистой ашиглахад чиглүүлсэн үйл ажиллагаа боловч үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаан дор явагддаг бөгөөд үүнийг телевиз радио, түүний дотор төрөөс санхүүждэг телевиз радиогийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавихад ашиглаж болохгүй. Хүний Эрхийн Европын Шүүх Танхим үйл ажиллагааны эрх олгохоор дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах тохиолдол бүр нь энэхүү хязгаарлалтыг хянан шалгах олон улсын хуулийн хүрээнд тогтоогдсон журмаар зохицуулагдах ёстой гэж шийдвэрлэж байсан билээ. Жишээлбэл, аливаа хязгаарлалт нь хууль эрх зүйн нэг буюу хэд хэдэн үндэслэлтэй байх ёстойгоос гадна энэ үндэслэлийг ч гэсэн мөн хамгаалж батлах шаардлагатай. Үүний адил Хил Дамжсан Телевизийн тухай Европын Конвенцийн оршил хэсэгт зааснаар Төр засаг нь “мэдээ, мэдээлэл ба санаа бодлын чөлөөт урсгалын зарчимд үнэнч байж телевиз радиогийн хараат бус байдлыг баталгаажуулах” ёстой.

Энэ баталгааны чухал нөхцлийн нэг нь телевиз радиогийн хэрэг эрхлэх газар эсвэл төрөөс санхүүждэг телевиз радиогийн удирдах зөвлөл зэрэг эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах бөгөөд бусад аргаар хянадаг хууль зүйн этгээд нь бусдаас хараат бус байх нөхцөл юм. Энэ зарчмыг олон улсын хэд хэдэн эрх зүйн актаар баталсан байдаг.

Дээрхи актуудаас магадгүй хамгийн чухал нь Европын Зөвлөлийн Сайд нарын Зөвлөлөөс баталсан *Олон Нийтэд Үйлчилдэг Телевиз Радиогийн Байгууллагуудын Хараат Бус Байдлын Баталгааны R(96)10 тоот Зөвлөмж* юм. Өнөөгийн байдлаар Европын Зөвлөл нь 41 гишүүн орноос бүрддэг бөгөөд гишүүн орнуудын хүний эрх болон нийгмийн хөгжлийг дэмжих зорилго бүхий байгууллага юм. Энэхүү баримт бичгийн нэрээс харахад тус байгууллага ба түүний гишүүн орнууд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хараат бус байдалд хэр их ач холбогдол өгч буй нь илэрхий. Телевиз радиогийн тэрхүү байгууллагуудыг удирдах ба хянах байгууллагуудын эрх мэдлийг хуулиар тодорхойлж, эдгээр нь нэвтрүүлгийн холбогдолтой асуудалд хөндлөгөөс оролцохгүй байх шаардлагатай гэж тус Зөвлөмжид заасан юм. Олон ургальч үзэл бодол, ажлаас халах ба сонирхлын зөрчлийн тухай асуудлуудыг нарийвчлан тусгасан, гишүүдийг ил нээлтэй байдлаар томилох журам зэрэг аргаар дамжуулан удирдах байгууллагуудыг үйл ажиллагааны эрсдэл, тэдгээрийн үйл ажиллагаанд хөндлөнгийн оролцоог багасгах нөхцлийг баталгаажуулах нь чухал.

ЮНЕСКО-гийн ивээл дор батлагдсан хэд хэдэн Тунхаглалд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн хараат бус байгууллагуудын ач холбогдлыг онцгойлон тэмдэглэсэн байдаг. 1996 оны *Санагийн Тунхаглал* олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулж буй нөхцөлд л тэдгээрт дэмжлэг тусламж үзүүлэхийг олон улсын нийгэмлэгт хандан уриалсан бөгөөд Төр засаг бүр энэхүү хараат бус байдлыг хангах нь зүйтэй гэж заасан билээ. 1997 оны *Софиагийн Тунхаглал* төрийн эзэмшлийн телевиз радиог нэвтрүүлгийн хараат бус байдлыг баталгаажуулсан, хараат бус удирдах хянах байгууллагуудтай олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд болгон шинэчлэх шаардлага байгааг тэмдэглэсэн юм.

Дээр дурьдсан Олон Нийтийн Хэвлэл Мэдээллийн Бодлогын асуудлаар зохион байгуулагдсан Европ тивийн Сайд нарын Зөвлөлийн 4 дүгээр уулзалтаас гаргасан “*Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн салбарын ирээдүй*” нэртэй 1 дүгээр *Тогтоол* нь удирдах байгууллагуудын хараат бус байдал, нэвтрүүлэг нийтлэлийн хараат бус байдал, зохих хэмжээний санхүүжилт зэрэг дээрхи зарчмуудыг мөн онцгойлон тусгасан юм. Засгийн газраас хараат бус байдал, үүний дотор санхүүгийн хараат бус байдал зэрэг нөхцлийг заасан эдгээр зөвлөмжүүд олон нийтийн хэвлэл мэдээллийн асуудлаар зохион байгуулагдсан Европын Зөвлөлийн Парламентийн Ассамблей болон Сайд нарын уулзалтаас гаргасан хэд хэдэн тогтоол ба зөвлөмжөөр баталгаажсан байдаг.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах зорилго бүхий 19 Дүгээр Зүйл, Чөлөөт Илэрхийллийн Дэлхийн Кампанит Ажил нэртэй төрийн бус байгууллагаас телевиз радиогийн үйл ажиллагаатай холбоотой олон улсын хууль болон туршлага дээр тулгуурлан *Телевиз Радиогийн Эрх Чөлөөг Дэмжих ба Хамгаалах Зорилго бүхий Арга Хэмжээ* гэсэн нэртэй цогц зөвлөмж гаргасан байна. Уг баримт бичгийн 1 тоот Зөвлөмж нь дээр дурьдсан зарчмуудыг тусгаж “Олон нийтийн телевиз радиогийн удирдах байгууллагын хараат бус байдлыг хуулиар баталгаажуулсан байх ёстой” гэж заасан байдаг.

Дээрх зарчмууд үндэсний шүүх танхимуудаас гаргасан хэд хэдэн шийдвэрт тусгагдаж байсан юм. Жишээлбэл, Шри Ланка улсын Дээд Шүүх телевиз радиогийн тухай хуулийн төсөл Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчимд нийцэхгүй болохыг тогтоож байсан билээ. Энэхүү хуулийн төслийн дагуу телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийг томилоход ихээхэн хэмжээний эрх мэдлийг засгийн газрын Сайдад олгосон байжээ. Дээд Шүүх “тус удирдах зөвлөл нь хүн бүрийн хүлээн зөвшөөрч буйн дагуу аливаа санаа бодолд нөлөөлөх чадвартай электрон хэвлэл мэдээллийг зохицуулах үүрэг бүхий байгууллагад шаардлагатай хараат бус байдлын зарчмыг хангахгүй байна” гэж шийдвэрлэсэн юм.

Үүнтэй адилаар Гана улсын Дээд Шүүх “Төрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд үндэсний хөрөнгө баялаг мөн бөгөөд тэдгээр нь нийгмийн нэг тустай хэсэг болох Төр засаг бус харин бүхий л нийгмийн эзэмшилд байж төр барьж буй засгийн газар эсвэл намд үйлчлэх ёсгүй. Хэрэв энэхүү үндэсний хөрөнгө баялагийг дээр дурьдсан эрх мэдэл бүхий аливаа этгээд эсвэл тэдгээрийн эвслийн сонирхол, үзэл бодлын цагаан хоолой болгон ашиглах юм бол ардчилал гэдэг нь худал хуурамч зүйл болж хувирна” гэж тэмдэглэсэн байдаг. Удирдах байгууллага болох Үндэсний Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн талаар тус Дээд Шүүх “төрийн хэвлэл мэдээлэл хараат бус амьсгалаар амьсгалж, Засгийн газрын хяналтаас чөлөөт бус байдлаар үйл ажиллагаагаа явуулахыг баталгаажуулах нь Зөвлөлийн үүрэг мөн” гэж тогтоосон билээ.

Дээр дурьдсан олон улсын стандарт тогтоож буй баримт бичгүүд удирдах байгууллагуудын хараат бус байдлыг тусгахын зэрэгцээ үүнтэй холбоотой боловч арай өөр агуулгатай олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын нэвтрүүлгийн хараат бус байдлыг хууль болон зохион байгуулалтаар баталгаажуулах санааг агуулж байгаа юм.

Телевиз Радиогийн Эрх Чөлөөг Дэмжих ба Хамгаалах Зорилго бүхий Арга Хэмжээний 2 тоот Зөвлөмж “Нэвтрүүлгийн хараат бус байдлыг хуулиар баталгаажуулсан байх ёстой” гэж заасан. Бодит амьдралд нэвтрүүлгийн хараат бус байдлыг ихэнх тохиолдолд телевиз радиогийн үйл ажиллагааг ерөнхийд нь хянан удирдах үүрэг бүхий удирдах байгууллага, өдөр тутмын үйл ажиллагааг гардан гүйцэтгэж нэвтрүүлэгтэй холбогдох өдөр тутмын шийдвэр гаргах үүрэг бүхий удирдах ажилтнууд, редакторуудын эрх мэдэл, үүргийг салгаж заагласнаар хангадаг юм. Удирдах байгууллага нь бодлого ба үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог бөгөөд зөвхөн онцгой тохиолдолд л тухайн нэвтрүүлэгтэй холбоотой асуудлыг шийдэж хөндлөнгөөс оролцоно.

Энэ зарчим Европын Зөвлөлийн *R(96)10 тоот Зөвлөмжийн 1* дүгээр Зүйлд тусгасан бөгөөд нэвтрүүлгийн хараат бус байдал болон нэвтрүүлгийн хуваарь, нэвтрүүлгийн агуулга, мэдээ ба зарим бусад асуудлын талаархи байгууллагын бүрэн эрхт байдлыг олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажуулах ёстой гэсэн байдаг. Улмаар, тус Зөвлөмжийн дагуу телевиз радиогийн удирдлага өдөр тутмын үйл ажиллагааг дангаараа хариуцаж, хянах байгууллагууд ба аливаа шүүхийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг хязгаарлах зэрэг замаар улс төрийн нөлөөний эрсдлээс удирдлагыг хамгаалах нь чухал гэж тусгасан юм. Үүнтэй холбоотойгоор дээрхи Зөвлөмжийн 20-22 Дугаар зүйл мэдээний нэвтрүүлгүүд аливаа баримтыг шударгаар тусгаж, өөрийн үзэл бодлыг чөлөөтэйгээр бий болгох боломжийг хүн бүрт олгох ёстой гэж заасан байдаг. Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд аливаа мэдээ мэдээлийг зөвхөн онцгой нөхцөлд байдалд л бусдын шаардлагаар нэвтрүүлэх ёстой.

Үүнтэй адилаар, санхүүжилтийн асуудал засгийн газрын хяналтаас хараат бус байсан нөхцөлд л жинхэнэ бодит хараат бус байдал бий болдог бөгөөд энэ санааг дээр дурьдсан олон улсын хэд хэдэн стандартад тусгасан юм. Нэмж хэлэхэд, олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хангалттай санхүүжилт авж буй тохиолдолд л биелүүлж чаддаг. Европын Зөвлөлийн *R(96)10 тоот Зөвлөмжийн 17-19 дүгээр Зүйл* олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудад олгож буй санхүүжилт нь олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг даалгаварт нийцэх хэмжээгээр олгогдож, олгож буй арга нь ил тод, нээлттэй байх нь зүйтэй гэж заасан. Санхүүжилтийг нэвтрүүлгийн хараат бус байдал эсвэл байгууллагын бүрэн эрхт байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц зохион байгуулалт, аргаар олгох ёсгүй.

19 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 3 тоот Зөвлөмж энэхүү санхүүжилтийн асуудлыг тусгасан бөгөөд “олон нийтэд үйлчилдэг телевиз радио зохих хэмжээгээр болон тус байгууллагуудын төсвийн хуваарилалтад

үзүүлэх хөндлөнгийн зохицуулах нөлөөнөөс хараат бус аргаар санхүүждэг байх ёстой” гэж тэмдэглэсэн билээ. Үүний адилаар, Италийн Үндсэн Хуулийн Цэц үндсэн хуулийн хүрээнд олгосон үзэл бодлоо илэхийлэх эрх чөлөөний дор тус улсын засгийн газар нь үйл ажиллагаагаа зохих хэмжээнд явуулах нөхцлийг хангах үүднээс олон нийтийн телевиз радиод хангалттай санхүүжилт олгох үүрэгтэй гэж тогтоосон юм.

АВСТРАЛИ

Танилцуулга

Австрали улсад олон нийтэд үйлчилдэг хоёр тусдаа байгууллага байдгийн нэг нь Австралийн Телевиз Радиогийн Корпораци (АТРК), нөгөө нь Телевиз Радиогийн Тусгай Үйлчилгээний Корпораци (ТРТҮК) юм. АТРК нь мэдээлэл ба цэнгээнт нэвтрүүлгийн үйлчилгээг телевиз болон радиогоор дамжуулан олон нийтийн ерөнхий сонирхолд зориулан нэвтрүүлдэг байхад ТРТҮК нь АТРК-тай харьцуулахад жижиг байгууллага бөгөөд Австрали улсын олон үндэстэн угсаатан бүхий нийгмийн хэвлэл мэдээллийн хэрэгцээг хангах тусгай үүрэг гүйцэтгэдэг юм. Тус хоёр байгууллага Австралийн холбооны Парламентаас баталсан Дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг олон нийтийн байгууллага юм. Тус байгууллагуудын олон нийтээс авч буй санхүүжилтийн зарцуулалтын талаар засгийн газрын өмнө шууд хариуцлага хүлээдэг боловч тэдгээр нь засгийн газрын хяналтаас хараат бус бөгөөд уран бүтээл, нэвтрүүлгийн ихээхэн хэмжээний эрх чөлөөг эдэлдэг. Судалгааны энэхүү бүлэгт эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны онцлог, олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, удирдлага болон санхүүжилтийн зохион байгуулалтыг тус тус танилцуулах болно.

АВСТРАЛИЙН ТЕЛЕВИЗ РАДИОГИЙН КОРПОРАЦИ (АТРК)

I. Үйл ажиллагаа

АТРК орон нутаг даяар цацагддаг газрын дамжуулалттай үндэсний телевизийн сүлжээг ажиллуулдаг (ABC-TV). Энэ сүлжээ Австрали улсын мужийн нийслэл бүр, үндэсний нийслэл Канберра, Дарвин хотуудад өөрийн салбар, дамжуулах төв ажиллуулдагаараа Австралийн иргэн бүрт нэвтрүүлгээ хүргэх боломжтой. ABC-Radio аудио-радиогийн зургаан суваг ажиллуулдаг бөгөөд үүнд: Муж нутаг бүрт нэг, Дарвин, Канберра, Ньюкасл хотуудад тус бүр нэг, нийт есөн радио станцаас бүрддэг Метрополитен Радио мэдээ сүүлийн үеийн үйл явдал шуурхай мэдээ, яриа хэлэлцүүлэг, мэдээлэл, спорт ба цэнгээнт нэвтрүүлгийн сүлжээтэй юм. Бүс Нутгийн Радио урт долгионы 70, богино долгионы 180 станц болон муж ба үндэсний хэмжээний сансарын дамжуулах станцийн үйл ажиллагаанаас бүрддэг бөгөөд бүс нутаг, муж, тухайн хотын болон үндэсний нэвтрүүлгийг хосолсон сүлжээгээр нийслэл хотын бус сонсогчдод үйлчилдэг байгууллага юм. Үүн дээр нэмээд, АТРК дөрвөн тусгай нэвтрүүлгийн радио ажиллуулдагийн нэг нь Үндэсний Радио ба тус байгууллага урлаг соёл, шашин, улс төр, хууль, мэдээ болон шуурхай мэдээ, сүүлийн үеийн үйл явдал, шинжлэх ухаан ба технологи, түүх, эрүүл мэнд, насанд хүрэгчдийн боловсрол ба нийгмийн өөрчлөлт шинэчлэл, олон улсын явдал, эдийн засгийн нэвтрүүлэг цацдаг. Классик FM зөвхөн сонгодог хөгжим нэвтрүүлдэг байхад Трипл Жей нь залуучуудад зориулсан радио бөгөөд ихэвчлэн орчин

үеийн хөгжим нэвтрүүлдэгийн зэрэгцээ мэдээ болон сүүлийн үеийн үйл явдал, инээдмийн болон тусгай нэвтрүүлгүүдийг өөрийн сонсогчдод хүргэдэг болно. Эцэст нь, Эй Ви Си Ньюс Радио нь мэдээ болон сүүлийн үеийн үйл явдлыг тогтмол сурвалжилдагаас гадна Парламентын сурвалжлага шууд нэвтрүүлдэг радио юм.

II. Олон нийтэд үйлчлэх үүрэг

Австралийн Телевиз Радиогийн Корпорацийн Актын 6 дугаар Хэсэгт батлагдсан АТРК-ийн Дүрэмд заасны дагуу Корпорацийн үйл ажиллагааны үүрэг нь “Австралийн телевиз радиогийн салбар ба үндэсний, арилжааны болон олон нийтийн зэрэг хэсгээс бүрдсэн телевизийн тогтолцооны нэгэн хэсэг болох шинэлэг болон олон талт, өргөн хүрээний телевиз радиогийн нэвтрүүлгийн сүлжээг бий болгон үйл ажиллагаагаа явуулж, телевизийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд Австрали улсын газар нутаг даяар үзүүлэхэд оршино”. Үүнийг тодруулбал, АТРК-ийн Дүрэмд АТРК нь хөгжим, драм болон бусад Австрали улсад хөгжиж буй урлагийн хэлбэрийг хөхүүлэн дэмжсэнээр үндэсний бахархал, үзэл бодлын хөгжилд хувь нэмэр оруулах, мэдээ мэдээлэл, цэнгээнт болон Австралийн нийгмийн олон үндэстэн угсаатны соёл иргэншлийн онцлогийг тусгасан нэвтрүүлгийн сүлжээг ажиллуулах ёстой гэж заасан байдаг. Мөн Дүрэмд АТРК нь нэвтрүүлгийн сүлжээний ихээхэн хувийг эзлэх боловсрол танин мэдэхүйн чанартай нэвтрүүлгийг цацах үүрэгтэй гэж тусгасан байдаг.

АТРК нь олон улсын чанартай тодорхой үүрэг хариуцлага хүлээдэг бөгөөд үүнд: 1\ гадаад орнууд дахь үзэгчдэд зориулсан мэдээ мэдээлэл ба цэнгээнт нэвтрүүлгээрээ дамжуулан Австрали орныг гадаадад сурталчлан таниулах бөгөөд дэлхийд болж буй үйл явдлын талаар Австрали улсын байр суурийг мэдүүлэх, 2\ гадаадад оршин сууж буй болон гадаадад аялаж буй Австрали иргэдэд зориулан Австралид болж буй үйл явдлын талаар мэдээ мэдээлэл хүргэх зэрэг үүрэг багтана. Ингэснээр олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн тус байгууллага нь нэг талаас, үндэсний амьдралыг өөрөөрөө дамжуулан тусгах, нөгөө талаас Австрали орны амьдрал, соёл иргэншлийг дэлхийн ард түмэнд таниулах чухал хоёр үүргийн гүйцэтгэдэг юм.

АТРК-ийн Дүрэм тус байгууллагын үүргийг хэвлэл мэдээллийн ширүүн өрсөлдөөн бүхий орчны хүрээнд ч мөн тодорхойлсон байдаг. Энэ асуудлын хүрээнд АТРК нь Австралийн телевиз радио ба телевизийн тогтолцоонд багтах арилжааны болон олон нийтийн телевиз радиогийн бусад байгууллагуудын үйл ажиллагааг өөрийн нэвтрүүлгээрээ нөхөн орлуулах зорилгыг тавих нь зүйтэй. Дүрэмд зааснаар АТРК хараат бус үндэсний телевиз радио болон телевизийн үйл ажиллагаа явуулдагийн хувьд “өргөн хүрээний болон тусгай телевиз радиогийн нэвтрүүлэг, телевизийн нэвтрүүлгүүдийг хооронд нь тэнцвэржүүлэх” үүрэгтэй. Олон нийтэд үйлчлэх үүргийн хүрээнд АТРК нь Австралийн нийгмийн олон үндэстэн угсаатны мөн чанарыг бүхий л үйл ажиллагаандаа тусгах шаардлагатай.

Тодруулж хэлэхэд, АТРК нэвтрүүлгийн асуудлаар хэд хэдэн үүрэг хүлээх ёстой бөгөөд, жишээлбэл, тус байгууллага нь мэдээ мэдээллийн хараат бус сүлжээг бий болгон ажиллуулж, Австрали улс болон дэлхийд болж буй үйл явдлын талаар үндэсний бүх радио болон телевизийн станцаар дамжуулан, өдөр бүр, тогтмол үндсэн дээр шуурхай мэдээ мэдээлэл нэвтрүүлэх үүрэгтэй.

1946 оны *Парламентын Хуралдааныг Телевиз Радиогоор Нэвтрүүлэх тухай Актын 4 дүгээр Хэсэгт заасны дагуу АТРК нь Сенат болон Төлөөлөгчдийн Танхим эсвэл Хамтын Нийгэмлэгийн хоёр Танхимын хамтарсан Парламентын Хуралдааныг Телевиз Радиогоор Нэвтрүүлэх асуудал хариуцсан Хамтарсан Зөвлөл шийдвэрлэсэн тодорхой өдрүүд болон хугацаанд нэвтрүүлэх үүрэгтэй. Хуралдааныг*

муж нутаг бүрийн нийслэл хот ба Ньюкасл хотод байрлах дундаж долгионы радио станц бүр, бусад шаардлагатай станц бүрээр дамжуулан нэвтрүүлнэ.

III. Удирдлагын тогтолцоо

A. Дотоод зохион байгуулалт

АТРК-ийн Акт нь үндэсний телевиз радиогийн үйл ажиллагааг бүрэн хэмжээгээр явуулахтай холбогдох эрхийг тус байгууллагад олгосон байдаг. АТРК-ийг дээрхи Актын дагуу үүсгэн байгуулсан Захирлуудын зөвлөл удирддаг бөгөөд түүний бүрэлдэхүүнд тус зөвлөлөөс таван жилийн хугацаатай томилогдсон Гүйцэтгэх захирал, Ерөнхий Захирагч нэг ёсоор Засгийн газрын танхим гэсэн үг-ийн томилсон зургаагаас найман Захирал ордог. Нэр дэвшигч тухай албан тушаалд тохирох эсэхийг тэдгээрийн мэргэжлийн шалгуураар үнэлдэг бөгөөд үүнд тухайн нэг дэвшигч нь телевиз радио эсвэл холбоо харилцаа эсвэл удирдлагын ухаантай холбоотой туршлагатай эсэх, санхүү ба техникийн мэдлэгтэй эсэх, соёл болон олон нийтэд үйлчилдэг байгууллагын үйл ажиллагаанд тохирох бусад туршлагатай эсэх зэрэг шалгуураар сонгоно. Эдгээр шалгуурт нийцэхгүй улс төрийн нэр дэвшигчдийг жагсаалтаас хасна. Аливаа зохисгүй үйлдэл гаргасан, сэтгэл зүй болон эрүүл мэндийн шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон, дампуурсан, албан үүргээ гүйцэтгэх чадваргүй гэдгийг нотолсон, Зөвлөлийн хурлыг дараалаад гурван удаа Зөвлөлийн даргын зөвшөөрөлгүйгээр тасалсан тохиолдолд л Захирлуудыг үүрэгт ажлаас нь хална.

Тус Актын 8 дугаар бүлэгт зааснаар Зөвлөл дараах үүргийг хүлээнэ. Үүнд: а) Корпораци үйл ажиллагаагаа үр бүтээлийн өндөр түвшинд, Австралийн нийт ард түмний эрх ашгийн төлөө явуулж байгааг хянах; б) Корпорацийн хараат бус байдал, нэр төрийг хамгаалан хадгалах; в) Корпорацийн мэдээ мэдээллийг бэлтгэн цацах аргачлал нь үнэн зөв, аливаа нэг талын байр суурийг баримтлаагүй, сэтгүүл зүйн олон нийтээр зөвшөөрөгдсөн бодит зарчмыг баримталж буйг баталгаажуулхын зэрэгцээ Корпораци нь телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх зэрэг үүрэг багтана. Мэргэжлийн зөвлөлгөө авах боломжийг ашиглах үүднээс тус хуулийн 11 бүлэгт зааснаар Захирлуудын зөвлөл нь телевиз радиогийн тусгай асуудал болон телевизийн нэвтрүүлгийн талаар зөвлөлгөө өгөх үүрэг бүхий Зөвлөмжийн Зөвлөл дэргэдээ байгуулах эрхтэй. Энэхүү Зөвлөлөөс гаргасан саналыг Захирлуудын зөвлөл зөвхөн мэдээлэл ба ажлын удирдамж болгож ашигладаг бөгөөд заавал мөрдөх ёсгүй. Захирлуудын зөвлөл нь иймэрхүү Зөвлөлийг Австрали улсын аливаа муж, бүс нутаг эсвэл тус улсад харьяалагдах газар нутагт байгуулж болно.

B. Зохицуулах механизм

Австралийн Холбооны Засгийн газар нь телевиз радиогийн үйл ажиллагааны хуулийн зохицуулалтыг шийдвэрлэх эрхтэй бөгөөд АТРК-ийн үйл ажиллагааг хянах бүрэн эрхийг эдэлнэ. Гэвч, олон талт хараат бус мэдээ мэдээллийг Австралийн бүх иргэдэд хүргэх үүрэг болон Корпорацийн Захирлуудыг томилох нөхцлийг тодорхойлсон АТРК-ийн Дүрмийн заалтууд нийлээд тус байгууллагын нэвтрүүлгийг Засгийн газраас ихээхэн хэмжээний хараат бус байдлыг баталгаажуулдаг юм. Дээрх заалтуудыг бодит амьдралд хүндэтгэн хэрэгжүүлдэг бөгөөд Засгийн газар олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагад нөлөө үзүүлэх гэсэн тохиолдол нь тус орны олон жилийн уламжлал болсон улс төрийн хэв хэмжээг зөрчсөн явдал болно.

Австралийн Дээд Шүүх тогтоосны дагуу тус улсын үндсэн хуулийн хүрээнд үүсгэн байгуулагдсан Австралийн ардчиллын суурь байгууллагууд нь улс төрийн харилцаа холбооны эрх чөлөөг үүсгэдэг бөгөөд төр баригч аливаа засгийн газар үүнийг хүчингүй болгох эрхгүй. Энэхүү хууль эрх зүйн баримт бичигт тодорхойлогдсон эрх чөлөөний заалтууд нь бодит амьдралаар шалгагдаж, засгийн газрын зүгээс олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудад тавих хяналтын асуудлын хүрээнд ашиглагдаж байгаагүй ч Австралийн олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хараат бус байдлыг улам баталгаажуулж хамгаалах заалтууд мөн.

Өнөөгийн байдлаар Австралийн телевиз радиогийн хувьд улс төрийн хяналт хурцаар тавигдаж буй асуудал биш боловч дутуу санхүүжилтийн улмаас нэвтрүүлгийн чанар, түүний итгүүлэх чадавхи ба нэр хүнд буурах магадлал одоо хүртэл айдас төрүүлж байгаа юм. Эрх мэдлийн хамгийн гол хөшүүрэг нь олон нийтээс авах санхүүжилтэд засгийн газрын зүгээс тавих хяналт бөгөөд АТРК-ийн үйл ажиллагаа энэ санхүүжилтээс ихээхэн хамааралтай юм.

АТРК-ийн Актын 78 дугаар бүлэгт заасны дагуу Харилцаа Холбооны Сайд үндэсний ашиг сонирхол бүхий гэж үзсэн зарим мэдээ мэдээлэл, нэвтрүүлгийг үнэгүй цацахыг АТРК-аас шаардах эрх мэдэлтэй байдаг. Гэвч, ингэх тохиолдолд сайд уг асуудлын шалтгаан, чиглэлийг Хамтын Нийгэмлэгийн Парламентад нарийвчлан танилцуулах ёстой. Засгийн газар үндэсний ашиг сонирхол бүхий мэдээ мэдээлэл эсвэл бусад хуулинд заасан тохиолдлоос бусад аливаа тохиолдолд АТРК-ийн нэвтрүүлэгтэй холбоотой үйл ажиллагаанд оролцохгүй гэж хуулинд заасан байдаг.

Олон нийт ч гэсэн АТРК-ийн үйл ажиллагаанд хязгаарагдмал хэмжээний хяналт тавих эрхтэй. Энэ хяналт нь олон нийтээс ирж буй санал гомдлыг барагдуулах үйл ажиллагаагаар дамжуулж хэрэгждэг. АТРК-ийн Актын дагуу нэвтрүүлэгт баримтын алдаа гарсан тухай албан ёсны \бичгээр\ гомдол сонсогч үзэгчдээс ирсэн тохиолдолд АТРК түүнийг олон нийттэй харьцах үүрэг бүхий өөрийн албан тушаалтанд аль болохоор хурдан дамжуулах ёстой. Тухайн албан тушаалтан энэ гомдлыг хэр ноцтой болохыг шалган, үүний үндсэн дээр түүнийг үргэлжлүүлэн шалгах эсэхийг шийднэ. Энэ албан тушаалтан нь цаашдын шалгалтаараа гомдол хэр үндэслэлтэй гэдгийг нотолж, энэ тухай олон нийтдээ харьцах ахмад албан тушаалтанд мэдээлэх үүрэгтэй. Энэхүү албан тушаалтан нь тухайн гомдлыг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд гомдол гаргасан этгээд болон АТРК-ийн гүйцэтгэх захиралд энэ тухай мэдэгдэнэ. Уг мэдэгдлийн үндсэн дээр гүйцэтгэх захирал нь энэ тухай олон нийтэд мэдэгдэж эсвэл зохих ёсоор уучлал хүсэх АТРК-ийн үүргийг аль болохоор хурдан биелүүлэхэд хяналт тавина.

Үндэсний телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулдгийн хувьд Австралийн Телевиз Радиогийн Хэрэг Эрхлэх Газар \АТРХЭГ\ нь АТРК-ийн үйл ажиллагааг хянах хязгаарагдмал эрхтэй байдаг. АТРК өөрийн нэвтрүүлгийн асуудалтай холбоотой үйл ажиллагаандаа мөрдөх журам боловсруулж АТРХЭГ-т танилцуулах ёстой.

Телевиз Радиогийн Үйл Ажиллагааны тухай 1992 оны Актын дагуу АТРХЭГ нь АТРК болон ОНҮТК-ийн үйл ажиллагааны талаар санал гомдол хүлээж авах эрхтэй. Гэвч энэ нь санал гомдол хүлээж авах хамгийн эцсийн шатны байгууллага юм. Учир нь эхлээд АТРК эсвэл ОНҮТК-д шууд гаргаж, тус байгууллага нь үйл ажиллагааны журмыг зөрчин гомдол гаргасан этгээдэд 60 хоногийн дотор хариу өгөөгүй буюу илгээсэн хариуг гомдол гаргасан этгээд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд л тухайн гомдлыг Хэрэг Эрхлэх Газар хүлээж авна. Энэ тохиолдолд гомдолтой\хохирогч тал нь АТРХЭГ-т албан ёсоор хандаж, тус байгууллага зөвхөн үндэслэлтэй, зохистой шалтгааны улмаас гаргасан гомдлыг цаашид шалгах үүрэгтэй бөгөөд үйл ажиллагааны журмаар зохицуулагдахгүй асуудлаар гаргасан гомдлыг шалгахгүй.

Ийм боловч АТРХЭГ нь үндэсний телевиз радиогийн талаар гаргасан гомдлыг барагдуулах маш хязгаарагдмал эрх мэдэлтэй байдаг. 1992 Актдад заасны дагуу тус байгууллага гомдол үндэслэлтэй болох, түүнийг үйл ажиллагааны журмын хүрээнд барагдуулах шаардлагатай гэдгийг тогтоосны дараа үйл ажиллагааны журмыг мөрдөх буюу алдаа гомдлын тухай олон нийтэд зарлах болон уучлал хүсэх зэрэг зохих арга хэмжээ авахыг үндэсний телевиз радиогийн байгууллагад санал болгоно. Хэрэг Эрхлэх Газарт өөрийн саналыг хэрэгжүүлэх шууд эрх мэдэл байхгүй. Гэвч, тус байгууллагын саналыг үндэсний телевиз радиогийн байгууллага нь 30 хоногийн дотор хэрэгжүүлээгүй тохиолдолд АТРХЭГ энэ тухай Харилцаа Холбооны Сайдад мэдэгдэж, тэрээр уг мэдэгдлийн нэг хувийг Парламентын хоёр танхимд хоёуланд нь ажлын 7 хоногийн дотор дамжуулах үүрэгтэй.

АТРК-ийн Актын 19 дүгээр Бүлэгт заасны дагуу тус байгууллага нь жилийн тайлан боловсруулах үүрэгтэй бөгөөд энэхүү тайландаа Сайдын захирамжаар нэвтрүүлсэн мэдээ мэдээлэл бүрийн тухай нарийвчилсан тайлбар, үйл ажиллагааны зарчим, жилийн хугацаанд хүлээж авсан бэлэг, хандив, бусад материаллаг зүйлс, Зөвлөмжийн зөвлөлөөс гаргасан зөвлөмж тус бүр, олон нийттэй харьцах үүрэг бүхий ажилтнуудын хийсэн ажлын тухай нэгдсэн тайлан ба санал гомдлын талаар авсан арга хэмжээ тус бүрийн тухай мэдээллийг тусгасан байх ёстой.

IV. Санхүүжилт

АТРК-ийн Актын 4-р хэсэг бүхлээрээ тус байгууллагын санхүүжилтэй холбоотой асуудлыг зохицуулдаг юм. Энэхүү хуулийн дагуу АТРК арилжаа зар сурталчилгааг телевиз радиогоор нэвтрүүлхийг хориглодог учраас тус байгууллагын үйл ажиллагаа нь төрийн санхүүжилтээс ихээхэн хэмжээгээр хамаардаг. АТРК нь 1999 оны 06 сарын 30 өдөр хүртлэх нэг жилийн хугацаанд ойролцоогоор 600 сая австрали доллар буюу нийт санхүүжилтийн 80 хувийг засгийн газраас авсан бөгөөд санхүүжилтийн үлдсэн 20 хувийг сүлжээний үйлчилгээ ба концерт зэрэг өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогоор бүрдүүлсэн байна. Тус байгууллагын Удирдах зөвлөл нь АТРК-гийн санхүүгийн ирэх жилийн орлого, зарлагын төсвийг боловсруулж Парламентад жил бүр өргөн барьдаг бөгөөд Парламент уг төсвийг хэлэлцүүлэн батлаж хөрөнгийн хуваарилалтыг шийдвэрлэдэг юм.

90-ээд оны сүүлээр АТРК болон гадаадын хэд хэдэн орны төрөөс санхүүждэг телевиз радиогийн санхүүжилтийн хэмжээг шат дараалан бууруулсан явдал гарч байсан түүхтэй. 1997 оны 4 дүгээр сард АТРК-ийн Зөвлөл нь тогтвортой санхүүжилтийг баталгаажуулхыг уриалсан мэдэгдлийг засгийн газарт хандан хэвлэл мэдээллээр гаргасан юм. Зөвлөл энэхүү мэдэгдэлдээ санхүүжилтийн тодорхой бус асуудлыг шийдвэрлэхгүй бол АТРК мэдээний нэвтрүүлэг болон шуурхай мэдээ, нийт үндэсний ач холбогдол, сэдэв бүхий нэвтрүүлэг, хөтөлбөрүүдийг багасгаж, бүс нутгийн радио станцуудыг хаах зэрэг хатуу арга хэмжээ авахад хүрнэ гэдгийг дурьджээ. Хэдийгээр АТРК нь нэвтрүүлэгтэй холбоотой үйл ажиллагааныхаа хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн эдэлж байгаа боловч тус байгууллагын энэхүү эрх чөлөөг бодит амьдралд хэрэгжүүлэх, түүнчлэн олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадвар нь эдийн засгийн бодит байдлаас хамаарч, улмаар аюул учруулж байгаа юм.

ТЕЛЕВИЗ РАДИОГИЙН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ КОРПОРАЦИ (ТРТҮК)

ТРТҮК нь 1975 онд үүсгэн байгуулагдсан Австрали орны олон үндэстэн угсаатны төрөл бүрийн сонирхолд үйлчилж, олон үндэстний соёлыг таниулан сурталчилах зорилго бүхий олон талт соёл

иргэншлийн онцлогийг тусгасан, үндэстэн угсаатны олон хэлээр нэвтрүүлгээ цацдаг олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн бусдаас онцгой байгууллага юм. *Телевиз Радиогийн Тусгай Үйлчилгээний тухай Акт*ад \ТРТҮ Акт\ зааснаар ТРТҮК нь өөрийн Дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулах корпораци бөгөөд тус Актын 6-р хэсэгт зааснаар энэхүү байгууллага нь Австралийн ард түмэн үндэстний онцлогийг тусгасан, тусгай үйлчилгээтэй телевиз радиогийн байгууллагатай болох Парламентаар дамжуулан уламжилсан хэрэгцээний илэрхийлэл юм. ТРТҮК-ийн Дүрэмд зааснаар тус байгууллагын үндсэн үүрэг нь “олон үндэстний болон олон хэл дээр радио телевизийн үйл ажиллагааг нийт Австралийн ард түмний хэрэгцээнд нийцсэн мэдээ мэдээлэл, боловсрол танин мэдэхүй, цэнгээнт нэвтрүүлгийн үйлчилгээгээрээ дамжуулан явуулж, ингэснээр олон угсаатан үндэстнээс бүрдсэн Австралийн нийгмийг хэрэгцээг энэхүү нэвтрүүлгийн сүлжээндээ тусгахад оршино”.

Үйл ажиллагаа

ТРТҮК нь ТРТҮК ТВ нэртэй телевизийн суваг ажиллуулдаг бөгөөд энэ суваг бусдаас худалдаж авсан ба тусгайлан бэлтгэсэн нэвтрүүлгийн сүлжээнээс бүрддэг. ТРТҮК-ийн хуваарьт нэвтрүүлгүүдийн тал хувь нь англиас бусад хэлээр цацагддаг болон эдгээр нэвтрүүлгийг долоо хоногт 4.6 сая Австралчууд үздэг. Үүнээс гадна, ТРТҮК нь Радио Мельбурн 1 ба 2, Сидней Радио 1 ба 2, Үндэсний Радиогийн Сүлжээ гэсэн 5 радио сувагтай. Эдгээр сувагийн бүх нэвтрүүлэг мэдээгээр эхэлдэг бөгөөд сүүлийн үеийн үйл явдал, яриа ба үзэл бодол, спорт, нийгмийн мэдээлэл ба хөгжим зэрэг төрөл бүрийн хөтөлбөрөөс бүрддэг.

Олон нийтэд үйлчлэх

ТРТҮК-ийн Дүрэмд зааснаар тус байгууллагын үндсэн үүрэг нь олон үндэстний болон олон хэл дээр радио телевизийн үйл ажиллагааг нийт Австралийн ард түмний хэрэгцээнд нийцсэн мэдээ мэдээлэл, боловсрол танин мэдэхүй, цэнгээнт нэвтрүүлгийн үйлчилгээгээрээ дамжуулан явуулж, ингэснээр олон угсаатан үндэстнээс бүрдсэн Австралийн нийгмийг хэрэгцээг энэхүү нэвтрүүлгийн сүлжээндээ тусгахад оршино. Тус Дүрэм нь ТРТҮК-ийн олон нийтэд үйлчлэх үүргийг үйл ажиллагаагаараа дамжуулан хэрхэн хэрэгжүүлхийг тодорхой тусгасан байдаг. Энэ Дүрмийн дагуу ТРТҮК нь “Австралийн оршин суух бүх үндэстэн угсаатан, уугуул иргэд ба Torres Straight Islander зэрэг олон үндэстэн угсаатнаас бүрдсэн нийгмийн харилцаа холбооны хэрэгцээ шаардлагыг хангахад зохих хувь нэмрээ оруулах; олон төрлийн соёл иргэншлийн Австралийн нийгмийн тууштай хөгжил дэвшилд оруулах хувь нэмрийг олон нийтэд таниулах; Австралийн нийгэм дэхь олон төрлийн соёл, хэл, угсаа зүйг хүндэтгэн хүлээн зөвшөөрөх үзэл бодлыг хөхүүлэн дэмжих; олон төрлийн хэл ба соёл иргэншлийг илэрхийлэх бусад хэлбэрийн хөгжилд хувь нэмрээ оруулах; мэдээ мэдээлэл, боловсрол танин мэдэхүй болон цэнгээнт нэвтрүүлгээ Австрали олон үндэстэн угсаатны иргэдийн хүссэн хэлээр явуулахыг аль болохоор эрмэлзэх; Австрали иргэдийн олон төрлийн уран бүтээлч нөөц баялгийг ашиглах; АТРК болон олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн салбарын үйлчилгээний хүрээг харгалзан Австралийн телевиз радиогийн үйлчилгээний хүрээг улам тэлэх; Австралийн телевиз радиогийн үйлчилгээний цар хүрээг өргөжүүлэхдээ олон ургальч үзэл бодлын үүднээс асуудлыг тайлбарлах ба үүнийг илэрхийлэх шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлэн Австрали улсын нийгмийн өөрчлөгдөж буй шинж чанарыг тусгах ёстой.

Удирдлагын бүтэц

А. Дотоод удирдлага

Дотоод бүтэц, зохион байгуулалтын хувьд ТРТҮК-ийн үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал ба дөрвөөс найман захирлуудаас бүрдсэн Захирлуудын Зөвлөл удирдана. Гүйцэтгэх захирлаас бусад захирлууд орон тооны бус бөгөөд тэдгээрийг Ерөнхий Захирагч 5 жилийн хугацаатайгаар 2-оос дээшгүй удаа томилно. Ерөнхий Захирагч захирлуудыг томилохдоо Захирлуудын зөвлөлийн нийт гишүүд нь ТРТҮК-г үр ашигтай удирдахад шаардлагатай Австралийн олон үндэстэн угсаатнаас бүрдсэн тус байгууллагын сонсогч үзэгчдийн хэрэгцээ сонирхлыг тэнцвэржүүлэн хангах чадвар бүхий бүрэлдэхүүнтэй байх зарчмыг баримтална. Эдгээр захирлууд нь өөрсдөө гарал үүслийн хувьд төрөл бүрийн үндэстэн угсаатныг төлөөлсөн байх ёстой. АТРК-ийн Захирлуудын зөвлөлтэй нэгэн адил захирлуудыг тодорхой заасан шалтгааны улмаас л үүрэгт ажлаас нь халж болох бөгөөд Зөвлөлийн үйл ажиллагаа нь засгийн газраас хараат бус байна.

ТРТҮК-ийн Зөвлөлийн эрх мэдэл, үүрэг хариуцлагын хүрээ нь дээр дурьдсан АТРК-ийн Зөвлөлийн эрх мэдэл, үүрэг хариуцлагын хүрээтэй адилхан болно. Үүний зэрэгцээ, хуулийн 50 дугаар Хэсэгт зааснаар ТРТҮК нь Дүрэмд тодорхойлсон асуудалд хамааралтай асуудлаар нийгмийн төрөл бүрийн хэсэг, бүлгийн хэрэгцээ ба үзэл бодлыг ойлгон хүндэтгэж, шаардлагыг нь хангах үүргийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах комьюнити зөвлөмжийн зөвлөл байгуулах шаардлагатай.

Хуулийн 47 дугаар Хэсэгт зааснаар тус Зөвлөл нь ТРТҮК-ийн зорилтыг тодорхойлон, тус байгууллагын стратеги болон бодлогыг тусгасан үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах үүрэгтэй. Энэ төлөвлөгөөнд орлого, зарлага, зээлийн төсөв, үйл ажиллагааны үр дүн болон түүний үр ашгийг хэмжих үзүүлэлт, Дүрэмд тодорхойлсон асуудалд хамааралтай асуудлаар нийгмийн төрөл бүрийн хэсэг, бүлгийн хэрэгцээ ба үзэл бодлыг ойлгон хүндэтгэж, шаардлагыг нь хангахын тулд авах арга хэмжээ зэрэг зүйл тусгагдсан байх ёстой. Дээрх төлөвлөгөөний нэг хувийг Сайдад өргөн барина. Хуулийн 51 дугаар Хэсэгт заасны дагуу тус төлөвлөгөөнд тусгасан зорилт, стратеги ба бодлого, орлого зарлагын төсвийн зохистой хэрэгжүүлэлтэд саад учруулах эсвэл сөрөг нөлөө үзүүлэх асуудал үүссэн гэж үзэж буй тохиолдолд Зөвлөл энэ талаар Сайдад яаралтай мэдэгдэх ба өөрийн байр суурийг үндэслэлтэй тайлбарлана.

Б. Зохицуулах механизм

ТРТҮК-ийн Актын 13 дугаар Хэсэгт телевиз радиогийн тус байгууллагын нэвтрүүлэг болон уран бүтээлийн нэвтрүүлгийн хараат бус байдлыг баталгаажуулсан байдаг. Тус салбарыг хариуцсан Сайд энэ байгууллагуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаархи өөрийн захирамжийг бичгээр гаргаж болох боловч энэхүү эрх мэдэл нь тодорхой хязгаарлалттай байдаг. Хуулийн 11 дугаар Хэсэгт заасны дагуу Сайд зөвхөн Зөвлөлтэй зөвшилцсөний дараа ТРТҮК-ийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргийн зохистой хэрэгжүүлэлттэй холбоотой асуудлаар л өөрийн захирамжийг гаргах эрхтэй бөгөөд нэвтрүүлгийн агуулга эсвэл хуваарийн талаар аливаа захирамж гаргах эрхгүй. Хуулийн 12 дугаар хэсэгт зааснаар тухайн мэдээ мэдээлэл эсвэл нэвтрүүлэг нь үндэсний эрх ашигт хамааралтай гэж үзэж буй тохиолдолд Сайд энэхүү мэдээ мэдээлэл эсвэл нэвтрүүлгийг ТРТҮК-ийн бүх эсвэл зарим сонгосон станцаар дамжуулан цацахыг тус байгууллагаас шаардах эрхтэй. Энэ нөхцөлд ТРТҮК тухайн мэдээ мэдээлэл эсвэл нэвтрүүлгийг Сайдаас гарсан захирамжийн дагуу үнэгүй нэвтрүүлэх бөгөөд Сайд энэхүү мэдээ мэдээлэл эсвэл нэвтрүүлгийг ямар хэлээр цацахыг заасан тохиолдолд тухайн хэлээр цацах ёстой.

Хуулийн 91 дүгээр Хэсэгт зааснаар Зөвлөл жилийн тайлан боловсруулж Парламентад өргөн барина. Жилийн тайланд Сайдаас гаргасан захирамж, энэхүү захирамжийн дагуу цацсан мэдээ мэдээлэл эсвэл нэвтрүүлэг, ТРТҮК-ийн тухайн жилд бусдаас хүлээж авсан бэлэг, хандив, үнэт зүйлс, жилийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь Дүрэмд тодорхойлсон тус байгууллагын зорилготой хэрхэн уялдан нийцсэн, зар сурталчилгаа ба ивээн тэтгэгчдээс олсон орлогын хэмжээ зэрэг асуудлыг нарийвчлан тусгасан байх ёстой.

ТРТҮК-ийн Зөвлөл нь нэвтрүүлгийн үйл ажиллагааны талаар баримтлах журам боловсруулж, уг журмыг АТРХЭГ-т танилцуулах үүрэгтэй. Гэхдээ ТРТҮК нь АТРХЭГ-аас баталсан нэвтрүүлгийн стандартыг заавал мөрдөх шаардлагагүй. Гэвч, аливаа иргэн нь ТРТҮК өөрийн үйл ажиллагааны журмыг зөрчсөн гэж үзсэний үндсэн дээр тус байгууллагад гомдол гаргаж, зохистой хариу тайлбар аваагүй тохиолдолд уг иргэн АТРХЭГ-т энэ талаар гомдол гаргаж болно. Гомдол хүлээж авах, барагдуулах үйл ажиллагаа нь дээр дурьдсан АТРК-ийнхтай адил зарчмаар хэрэгжинэ.

Санхүүжилт

АТРК-тай нэгэн адил ТРТҮК-ийн орлогын гол эх үүсвэр нь төрөөс жил бүр хуваарилдаг төсөв юм. Гэхдээ АТРК-тай ялгагдах нэг зүйл нь ТРТҮК цагт таван минутын зар сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд энэ нь байгууллагын нэмэлт орлого болдог болно. ТРТҮК-ний Актын 45 дугаар Хэсэгт зааснаар тус байгууллага нь нэвтрүүлгийн өмнө ба дараа эсвэл нэвтрүүлэг хоорондын завсарлагаар эфирийн аливаа цагт таваас хэтрэхгүй минутны зар сурталчилгаа болон ивээн тэтгэгчдийн зар зарлал нэвтрүүлэх эрхтэй. Тус байгууллагын Зөвлөл нь зар сурталчилгаа болон ивээн тэтгэгчдийн зар зарлалын талаар журам боловсруулж нийтэд хэвлэл мэдээллээр дамжуулан хүргэх үүрэгтэй бөгөөд зар сурталчилгаа болон ивээн тэтгэгчдийн зар зарлалыг нэвтрүүлэх хугацаа ба түүний байрлал, төрөл, зар сурталчилгаа агуулж болох нэвтрүүлгийн төрөл зэрэг энэ асуудалтай холбоотой бусад асуудлыг зохицуулах журам гаргаж болно. Тус Зөвлөл нь нийгмийн төрөл бүрийн хэсэг бүлгээс гаргасан мэдээ мэдээлэл, тэдгээрийг сурталчилах материалыг нэвтрүүлэх талаар журам боловсруулж, нийтэд хэвлэл мэдээллээр дамжуулан хүргэх ёстой.

1999 оны 6 дугаар сар хүртэл нэг жилийн хугацаанд ТРТҮК нь өөрийн нийт орлогын 77хувь буюу 90 сая австрали долларын санхүүжилтийг төрөөс авсан бөгөөд үлдсэн орлогыг зар сурталчилгааны үйл ажиллагаанаас олжээ.

КАНАД

Танилцуулга

Канадын Үндсэн Хуульд зааснаар радио, телевизийн үйл ажиллагаа нь энэ салбарын үндэсний хэмжээний ач холбогдлыг харгалзан холбооны хууль тогтоомжоор зохицуулагддаг. Телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулах зохистой тогтолцоо Холбооны Шүүх дараах байдлаар шийдвэрлэсэнээр бий болсон билээ. Үүнд: “телевиз радиогийн улс орны амьдралд гүйцэтгэх ач холбогдлыг *Телевиз Радиогийн Актын* 3-р зүйлд “Канад улсын телевиз радиогийн системийг Канадын иргэд эзэмшин хянах ёстой бөгөөд энэхүү тогтолцоо нь тус улсын соёл иргэншил, улс төр, нийгэм ба эдийн засгийг хөгжүүлэн дэмжихэд чиглүүлсэн үйл ажиллагаа явуулна” гэсэн заалтаар тодорхойлсон юм”.

Канадын телевиз радиогийн байгууллагуудын үүрэг хариуцлага болон мөн чанар, утгыг тодорхойлох 1991 оны *Телевиз Радиогийн Акт* (ТРА) нь энэ салбар дахь эрх зүйн тогтолцооны суурь баримт бичиг юм. Энэ хуулийн дагуу телевиз радиогийн үндэсний бодлогыг хянах болон хэрэгжүүлэх үүрэг бүхий Канадын Радио Телевиз болон Харилцаа Холбооны Зөвлөл (КРТХХЗ) гэсэн нэртэй хараат бус захиргааны агентлаг үүсгэн байгуулагдсан. Мөн хуулиар Канадын Телевиз Радиогийн Корпораци (КТРК)-г олон нийтэд үйлчилдэг Канадын радио телевизийн байгууллага гэж тодорхойлсон юм. Судалгааны энэхүү хэсэгт КТРК-ийн олон нийтийн үйлчлэх үүрэг, түүний үйл ажиллагаа, санхүүжилтийн тогтолцоо болон олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын хувьд КРТК нь телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулдаг КРТХХЗ болон телевиз радиогийн бодлого, үйл ажиллагааг хянах бүрэн эрхт Парламенттай ямар харилцаа холбоотой байдгыг танилцуулах болно.

I. Үйл ажиллагаа

КТРК-ийг анх үндэсний радио бий болгох зорилгоор 1936 онд Парламентын шийдвэрээр байгуулсан бөгөөд Америкийн радио Канадын агаарын долгионд цар хүрээгээ ихээхэн хэмжээгээр тэлж, түүний ноёрхолоос болгоомжилсон нь уг Корпорацийг байгуулах нэг шалтгаан байсан юм. Өнөөдөр КТРК өргөн хүрээний мэдээлэл, цэнгээнт нэвтрүүлгийн сүлжээг газраар дамжуулах болон кабелийн телевиз, урт болон богино долгионы радио ба олон улсын богино долгионоор дамжуулан албан ёсны хэл болох Франц, Англи хэлээр ажиллууж байна.

КТРК нь ерөнхий болон тусгай нэвтрүүлэг цацдаг Эс Би Си Телевижн \Англи хэлээр\ ба Ла Телевизион де Радио Канада \Франц хэлээр\ хоёр телевизийн сүлжээ, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг кабел мэдээ ба мэдээллийн хоёр сүлжээ, англи хэлээр Си Би Си Ньюсвөрд, франц хэлээр Le Reseau de l'information-ыг ажиллуулж байна. Радиогийн салбар тус байгууллага нь үндэсний дөрвөн сүлжээ, Англи болон Франци хэлээр мэдээлэл ба ерөнхий сонирхлын нэвтрүүлэг цацдаг урт долгионы сүлжээ болон мөн хоёр хэлээр сонгодог хөгжим, соёр урлагийн нэвтрүүлэг цацдаг богино долгионы сүлжээ ажиллуулж байна.

Түүнчлэн, алслагдмал хойд бүс нутагт оршин суугчдын онцгой хэрэгцээг хангах үүднээс КТРК Англи, Франц болон уугуул нутгийн найман хэлээр нэвтрүүлгээ явуулдаг бүсийн радио, телевизийг ажиллуулдаг. Үүний зэрэгцээ тус байгууллага долоон хэлээр нэвтрүүлгээ цацдаг Радио Канада Интернэйшнл гэж нэрлэх олон улсын богино долгионы радиогийн үйл ажиллагаа явуулдаг.

II. Олон нийтэд үйлчлэх үүрэг

КТРК-ийн олон нийтэд үйлчилэх үүргийг ТР Актын 3(1)(1) ба (m) зүйлд заасан байдаг. Үндэсний олон нийтэд үйлчилдэг радио телевизийн байгууллага нь “мэдээлэл олгох, гэгээрүүлэх болон цэнгээх зорилготой өргөн хүрээний радио телевизийн нэвтрүүлэг” олон нийтэд хүргэх үүрэгтэй. Түүнчлэн, Корпораци нь нэвтрүүлгийн сүлжээндээ “Канадын онцлогийг голчлон тусгаж, тус улс болон түүний бүс нутгийг үндэсний ба орон нутгийн сонсогч үзэгчдэд танилцуулхын зэрэгцээ бүс нутгийн онцлог сонирхолд нийцсэн, соёл урлагийн солилцоо ба урсгалыг дэмжин хөхүүлсэн, Англи ба Франц хэлээр ижил тэгш чанартай нэвтрүүлэг цацаж, албан ёсны тус хоёр хэлээр ярьдаг ард иргэдийн бүлэг хэсэг тус бүрийн сонирхолд нийцсэн, үндэсний бахархал ба нэгдмэл байдлыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан, хамгийн

зөв зохистой, үр ашигтай арга аргачлал, нөөцийг ашиглан Канадын газар нутаг даяар нэвтрүүлгээ цацаж, Канад улсын олон үндэстэн угсаатны нийгмийн мөн чанарыг тусгах ёстой.”

КТРК байгууллагынхаа үүргийг “Канадын улсын аж амьдралыг үнэн бодит байдлаар тусгах” гэж тодорхойлдог. Канадчуудад олон нийтэд ач холбогдол бүхий үйл явдлыг мэдээлэх үүргийнхээ хүрээнд КТРК нь Сэтгүүл Зүйн Бодлогын Гарын Авлага боловсруулж мэдээ болон өнөөгийн шуурхай үйл явдлын нэвтрүүлгээ энэхүү баримт бичгийн дагуу бэлтгэж цацдаг юм. Ингэснээр Корпораци “Канад улсын нийт иргэдийг олон талт, өндөр чанартай мэдээллээр хангах үүргээ” хэрэгжүүлдэг. КТРК нэгдсэн зорилтоо олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын үүрэг дээр үндэслэн боловсруулсан бөгөөд энэхүү зорилтыг зах зээлийн өнөөгийн шаардлага бус харин олон нийтэд үйлчлэх үүрэгт тулгуурлан хэрэгжүүлдэг гэдгээ сурталчилдаг.

III. Удирдлагын тогтолцоо

A. Дотоод удирдлага

КТРК нь Канадын Засгийн газар, энэ утгаараа Канад улсын иргэдийн, бүрэн эзэмшилд байдаг толгой байгууллага юм. Энэ утгаараа, Холбооны засгийн газар нь КТРК-ийн үйл ажиллагааны нөхцлийг өөрийн хууль эрх зүйн эрх мэдлээр дамжуулан хянадаг. Энэхүү байгууллага нь тусгай хууль зүйн баримт бичгийн дагуу үүсгэн байгуулагдсан компанийн тухай ерөнхий хуулийн дагуу бус харин ТР Актад заасан тусгай нөхцлийн дагуу удирдлагын тогтолцоогоо бүрдүүлдэг. ТР Акт тус Корпорацийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулж сэтгүүл зүй болон нэвтрүүлгийн хараат бус байдлыг улс төр, санхүүгийн сонирхлоос салган ангижруулсан нь маш ач холбогдолтой юм. Ингэснээр КТРК аж ахуйн нэгжийн тухай хууль эрх зүйн зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж буй хувийн телевиз радиотой адил бус байгууллагын “эзэмшигчдийн” сонирхлоос өөрийгөө хамгаалж чаддаг байна.

Тус байгууллагын Захирлуудын зөвлөл хууль, эрүүл мэнд, санхүү, бизнес, урлагийн салбарын бүс нутаг тус бүрийг төлөөлсөн нийгэмд нэр хүнд бүхий иргэдээс бүрдсэн 12 хүртлэх гишүүнтэй бөгөөд КТРК-ийн үйл ажиллагааг ерөнхийд нь удирдан хянах үүрэгтэй. Корпорацийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн хүмүүс, албан хаагч, ажилтнууд гардан явуулдаг. Захирлуудын зөвлөлийн гишүүдийг Зөвлөлийн Захирагч \Холбооны засгийн газар\ 5 жилийн хугацаагаар томилдог бөгөөд тэдгээр нь нөхөн сонгогдож болно. Ерөнхийлөгч, Зөвлөлийн дарга болон бусад бүх захирлууд сайн ажиллаж, аливаа ноцтой алдаа дутагдал гаргаагүй нөхцөлд тэдгээрийг ажлаас нь халах ёсгүй. Хувийн корпорациудын нэгэн адил захирлууд тус байгууллагад үнэнчээр зүтгэх, засгийн газрын эрх ашгийн төлөө бус харин КТРК болон түүний олон нийтэд үйлчлэх үүргийн хэрэгжүүлхийн төлөө ажиллах ёстой. Иймээс тэдгээр нь КТРК-ийн сонирхол, эрх ашигтай зөрчилдөхүйц телевиз радиогийн бусад байгууллагатай хамтран ажиллах буюу дотор нь ажиллаж болохгүй.

Байгууллагын бодлогын хүрээнд КТРК олон нийтэд үйлчлэх үүргийг ноцтойгоор зөрчсөн тухай иргэдээс гарч буй шийдвэрлэгдээгүй санал гомдлыг хянах үүрэг бүхий, Корпорацийн удирдлагаас хараат бус Омбудсмэн ажиллуулдаг. Тус Омбудсмэн Ерөнхийлөгчид шууд харъяалагдаг боловч тэрээр хууль эрх зүй буюу аливаа бусад эрх мэдэл байхгүй.

B. Зохицуулах механизм

Аж ахуйн байгууллагын хувьд КТРК үйл ажиллагаатай нь холбогдох хуулийн ерөнхий хүрээнд захирагддаг. Гэвч Парламент болон КРТХХЗ нь КТРК-ийн үйл ажиллагааг хянах онцгой эрх үүрэгтэй. Нэгэнт Парламент телевиз радиогийн тогтолцоог зохицуулах эрх зүйн эрх мэдэлтэй учир энэ салбарын

үйл ажиллагааны ерөнхий зарчмыг тодорхойлох эрхтэй. ТР Актын зүйл ёсоор КТРК нь Парламентад захирагдан, 71-р хэсэгт заасны дагуу жилийн тайлангаа Канадын Өв Уламжлал, Соёлын Сайдаар дамжуулан Парламентад өргөн барих үүрэгтэй хэдий ч тус байгууллагын сэтгүүл зүйн эрх чөлөөг мөн баталгаажуулсан байдаг.

ТР Актын хүрээнд засгийн газар КТРК-ийн үйл ажиллагааг хянах ихээхэн эрх мэдэлтэй, тус байгууллага нь олон нийтээс ихээхэн хэмжээний санхүүжилт авдаг боловч Корпораци бүрэн хэмжээний хараат бус, биеэ даасан байгууллага бөгөөд олонхийн саналаар Канадын хамгийн сайн мэдээллийн сувагт тооцогддог. КТРК-ийн сэтгүүлчид дотоодын улс төрийн асуудалд ихээхэн анхаарч засгийн газрын үйл ажиллагааны талаар эрэн сурвалжлаж шүүмжлэлтэй хандагдгаарай бусдыг тэргүүлдэг юм. Энэхүү хараат бус байдал нь тохиолдлын зүйл бус харин ТР Актад баталгаажуулсан статус мөн. Тус хуулийн 46(5)-р хэсэгт “өөрийн зорилтыг болон хуулиар олгосон эрх мэдлийг хэрэгжүүлэх үүднээс Корпораци нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүл зүй, нийтлэл ба нэвтрүүлгийн хараат бус бодлоготой байна” гэж заажээ.

КТРК нь Эдлэх Эрх ба Эрх Чөлөөний тухай Дүрмийг мөрдөх зорилго бүхий засгийн газрын салбар байгууллага болох эсэх талаар дүгнэлт гаргах үүднээс Хатан Хааны Алберта Шүүх Танхим телевиз радиогийн байгууллагын хараат бус байдалд дараах ажиглалт хийсэн билээ. Үүнд:

ТР Актын 53-70-р хэсэгт тусгасан санхүүжилтийн асуудлаар ч хүртэл Парламент КТРК нь олон нийтэд үйлчлэх үүргийнхаа хүрээнд тусгаар тогтносон байдлаар үйл ажиллагаагаа явуулах баталгааг гаргаж өгөхөд ихээхэн чармайсан. Парламент нь КТРК-ийн сэтгүүл зүй, нийтлэл ба нэвтрүүлгийн хараат бус байдлыг өөрийн мэргэн цэц ухаанаар 1991 оны хуулиар баталгаажуулсан бөгөөд ардчилсан нийгмийн тулгуур болох телевиз радио засгийн газрын нөлөөллөөс чөлөөтэй байх ёстой гэдэг зарчмыг хүлээн зөвшөөрсөн.

Дээр дурьдсанчлан, Парламент КТРК-ийн Захирлууд, зөвлөлийн гишүүдийг томилох эрхтэй. Захиралд нэр дэвшигчдийг сонгоход намын нөлөөлөл зохих нөлөө үзүүлж болзошгүй ч томилогдсон захирлууд улс төрийн нөлөө үзүүлэх оролдого гаргах тохиолдолд энэ нь ТК Акт болон Эдлэх Эрх ба Эрх Чөлөөний тухай Дүрмийн заалт ба мөн чанарыг бүдүүлгээр зөрчсөн явдал болно. КТРК-ийн үйл ажиллагаанд улс төрийн дарамт үзүүлэх явдал гарах юм бол энэ нь олон нийт, улс төрийн хүрээнийхний дунд маш их дургүйцэл үүсгэх нь гарцаагүй. Үүнтэй холбогдуулаад, Либерал нам хоёр дахь хугацаандаа засгийн эрх барьж байгаа хэдий ч Брайан Мулронэйгийн Консерватив намын засгийн газрын гишүүн асан Пэррин Бийти КТРК-ийн Ерөнхийлөгчөөр саяхныг хүртэл ажиллаж байсан нь сонирхолтой.

Канадын телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулагч КРТХХЗ нь захиргааны ба хязгаарагдмал хүрээнд эрх зүйн эрх мэдэл бүхий, засгийн газартай ойр хамтран ажиллаж Канадын Өв уламжлал, соёлын сайдаар дамжуулан Парламентад үйл ажиллагаагаа тайлагнадаг бие даасан байгууллага юм. Энэхүү агентлагийн гол зорилт нь “зохицуулалт, хяналт болон олон нийттэй харилцах холбоогоороо дамжуулан Канадын харилцаа холбооны тогтолцооны Канад улсын эдийн засаг, нийгэм ба соёлын цэцэглэлтэнд оруулах хувь нэмрийг нь баталгаажуулахад” оршино. Тус байгууллага Засгийн газраас 5 жилийн хугацаатай томилогддог 13 орон тооны, гэрээгээр ажилладаг 6 хянагчдаас бүрддэг бөгөөд тэдгээрийг нөхөн сонгож болно. КРТХХЗ-ийн зорилго нь “телевиз радиогийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх үүднээс Канадын радио телевизийн салбар дахь бүхий л асуудлыг зохицуулж хянахад” оршдог бөгөөд хянагчид жилд 6-гаас доошгүй удаа хуралдах үүрэгтэй.

ТР Актын 28-р хэсэгт заасны дагуу засгийн газар КРТХХЗ-ийн шийдвэрийг өөрчлөх эрхтэй хэдий ч энэ нь ховор үзэгдэл юм. Энэхүү хуульд зааснаар Засгийн газар нь дээрхи алхмыг Канадын телевиз

радиогийн тогтолцооны ТР Актад тусгасан бодлогын хүрэн дахь зорилтыг зөрчсөн гэж баталсан тохиолдолд л хийх эрхтэй. Нөгөөтэйгүүр, энэхүү заалт засгийн газарт шударга ёс зүйн тодорхой зарчим боловсруулж, түүнийг мөрдөх үүрэг ноогдуулж байгаа бөгөөд ингэснээр тус этгээдийн бүрэн эрхийг хязгаарлаж байгаа явдал юм. Одоо мөрдөж буй ТР Актын 28(5)-р хэсэгт засгийн газар КРТХХЗ-ийн хураамжийн талаарх гаргасан шийдвэрийг хүчингүй болгосон үндэслэлийг танилцуулах ёстой гэж заасан байдаг. Засгийн газар дээрхи эрх мэдлийг үндэслэлгүй ашиглаж КТРК-ийн үйл ажиллагаанд улс төрийн нөлөө үзүүлэхийг завдвас Канад улсын Эдлэх Эрх ба Эрх Чөлөөний Дүрмийн 2(б) хэсэгт тунхагласан үзэл бодлоо илэрхийлэх ба хэвлэлийн эрх чөлөөний баталгааг бүдүүлгээр зөрчсөн явдал болох болно.

КРТХХЗ нь КТРК болон бусад радио телевизийн байгууллагын нэвтрүүлгийг хянах эрх мэдэлгүй бөгөөд ТР Акт ба олон нийтийн ашиг сонирхолд үндэслэн радио телевизийн үйлчилгээний эрх олгож, эрхийг сунгаж, мөн эрхийг хүчингүй болгох эрх мэдлээрээ дамжуулан тус салбарын ерөнхий стандартыг тогтоодог. Гэвч эдгээр эрхээс хамгийн хатуу нь болох эрхийг хүчингүй болгох үйлдлийг дээрхи байгууллага одоо хүртэл хэзээ ч хэрэгжүүлж байгаагүй юм. Мөн КРТХХЗ телевиз радиогийн байгууллагуудад зөвлөмж болохуйц удирдамж ба мэдэгдэл гаргаж болно. Олон нийтэд үйлчилдэг байгууллагын хувьд КРТХХЗ радио телевиз эрхлэгчдийн өнгөрсөн болон хэтийн үйл ажиллагааны талаар иргэд, хувь хүмүүсээс санал хүсэлтийг тогтмол хүлээн авдаг. ТР Актын 18-р хэсэгт зааснаар КРТХХЗ үйл ажиллагааны эрх олгохыг хүссэн, түүнийг сунгахыг хүссэн өргөдөл хүлээж авсан тохиолдол бүрт олон нийтийн зөвлөлдөөн зохион байгуулж саналыг нь тусгах ёстой.

КРТХХЗ нь КТРК-ийг хувийн телевиз радио байгууллагуудтай адилтгаж үздэг ба Корпорци үйл ажиллагааны эрх олгох, эрхийг сунгах асуудлаар тус байгууллагад ханддаг хэдий ч, КРТХХЗ нь Корпорацийн аль нэгэн үйл ажиллагааны эрхийг нөхцөлтэйгөөр олгох тохиолдолд хоёр байгууллага энэ асуудлаар зөвшилцөхийг ТР Актад тусгасан байдаг. КТРК эдгээр нөхцөл байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байвал тус асуудлаар Харилцаа Холбооны сайдад хандаж энэ талаар зөвлөлдөж болно. Үүнтэй адил, КТРК-д олгосон аливаа эрхийг тус байгууллагатай зөвшилцөлгүйгээр түр буюу байнгын хугацаагаар хүчингүй болгох эрх КРТХХЗ-д байхгүй. Иймээс КТРК КРТХХЗ-д хандаж үйл ажиллагааныхаа эрхийг сунгуулах нь тогтмол хугацаанд явагддаг ёс төдий асуудал бөгөөд, нөгөөтэйгүүр, КТРК-ийн дээд удирдлагыг олон нийтийн хяналтад байлгаж, хариуцлага тооцох болон шүүмжлэх бололцоог олгож байгаа явдал мөн.

ТР Актын 25-р бүлэгт тусгасанчлан, КТРК нь үйл ажиллагааны эрх, үүрэг, дүрэм журмын аливаа нөхцлийг эс хангасан гэж үзвэл КРТХХЗ энэ тухай Харилцаа Холбооны Сайдад илтгэх ба тэрээр Парламентийн хоёр танхимд тус бүр энэхүү илтгэлийн нэг нэг хувийг танилцуулах үүрэгтэй. Энэ заалт КТРК-ийн КРТХХЗ-ийн хууль зүйн эрх мэдлээс үл хамаарах байдлыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байгаа юм. Мөн ТР Актын 26(1)(б)-д заасны дагуу Засгийн газар КТРК-д суваг, долгионыг хуваарилах талаар КРТХХЗ удирдамж өгдөг эрхтэй. Засгийн газар нь олон нийтэд онцгой чухал ач холбогдолтой гэж үзэх нэвтрүүлгийг цацах шийдвэр гаргаж түүнийг биелүүлэхийг КТРК болон бусад телевиз радиогийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудаас КРТХХЗ-өөр дамжуулан шаардах эрхтэй.

IV. Санхүүжилт

КТРК ихэвчлэн олон нийтээс санхүүждэг байгууллага юм. Тус байгууллага дараа жилийн нэгдсэн төлөвлөгөө болон түүнд нэг хэсэг болох санхүүгийн жилийн төсвөө Харилцаа Холбооны Сайдад жил бүр өргөн барьдаг. Тэрхүү төсвийг Канад улсын Сангийн Яам, түүнчлэн Парламент баталж, эсвэл үл

зөвшөөрдөг бөгөөд баталсан тохиолдолд КТРК олгосон санхүүжилтийн хэмжээний дагуу шинэчлэсэн нэгдсэн тайланг дахин өргөн барина.

1999 онд КТРК-ийн төсвийн 66 хувь буюу 935 сая Канад доллар холбооны улсын төсөв, 23 хувь нь зар сурталчилгааны арилжааны үйл ажиллагаа ба үйлдсэн 11 хувь нь “бусад” үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдсэн. Тус байгууллагын төсвийн бүрдэлтийн энэхүү хувийг албан ёсоор тогтоож заадаггүй бөгөөд 1990 оноос хойш засгийн газрын хүндрэл, хязгаарлалтын улмаас олон нийтээс авдаг санхүүжилтийн хувь ихээхэн багассан билээ. Тэр үеэс хойш Канадын телевиз радиог дэмжигч болох “Канадын аудио ба үзвэрийн тогтолцооны хүрээнд Канад нэвтрүүлгийн чанар болон хэмжээ”-тэй холбогдох олон нийтийн эрх ашгийг хамгаалагч, олон нийтийн сонирхлыг төлөөлсөн бүлэг нь засгийн газар олгож буй санхүүжилтээрээ дамжуулан КТРК-ийн олон нийтэд үйлчлэх үүргээ бүрэн дүүрэн биелүүлж чадахгүйд хүрсэн гэж шүүмжилж ирсэн юм. Үнэхээр, санхүүгийн эх үүсвэр хумигдсанаар КТРК-ийн ажилтан болон нэвтрүүлгийн хэмжээ үлэмж багассан нь эрх зүйн баримт бичигт санхүүжилтийн талаар зохистой дүрэм, заалт албан ёсоор тусгах нь Канадын олон нийтийн телевиз радиод тулгарч буй хамгийн гол асуудал болоод байна.

ФРАНЦ

Танилцуулга

Бусад хууль эрх зүйн тогтолцоотой адил бус Франц улсын хуулийн дагуу телевиз радиогийн олон нийтэд үйлчлэх үүргийг хэд хэдэн улсын компани гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагуудыг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа явуулах зэрэг асуудал 1986 батлагдсан *Харилцаа Холбооны Эрх Чөлөөний* тухай хуулиар зохицуулагддаг. Радио телевизийн нэвтрүүлгийн бодлого боловсруулах, нэвтрүүлэг цацах, бэлтгэх болон нэвтрүүлгийн архив санг баяжуулан хадгалах үйл ажиллагааг өөр өөр компаниуд тус тус хариуцдаг. Тус салбар дахь гол зохицуулагч байгууллага болох 1989 оны хуулиар үүсгэн байгуулагдсан Conseil Superior de l'Audiovisual (CSA) нэртэй байгууллага нь бие даасан хууль хяналтын байгууллага юм. Телевиз радиогийн салбарт үйлчилдэг хуулиуд бодол санаа ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа болсон 1789 оны Хүний Эрхийн Тунхагийн 11-р зүйлээр зохицуулагддаг юм. Conseil constitutionnel (Үндсэн хуулийн цэц) 11-р Зүйлийг тус салбарын эрх зүйн хэд хэдэн дүрэм журамд ашигласан бөгөөд ингэхдээ хуучирсан, тохирохгүй заалт зүйлийг өөрчлөн шинэчлэж, зарим тохиолдолд үл харгалзаж байсан билээ.

Телевиз радиогийн үйл ажиллагаанд хамааралтай хэд хэдэн ач холбогдол бүхий өөрчлөлт Франц улсад саяхан гарсан юм. 1945-аас 1982 он хүртэл Төр радио телевизийн салбарт ноёрхож байсан билээ. 1964 он хүртэл засгийн газар тус улсын телевиз радиог шууд хянадаг байсан бөгөөд зөвхөн 1982 онд бие даасан Дээд Захиргааг байгуулсанаар тус салбарын эрх зүйн хараат бус байдлыг хүлээн зөвшөөрсөн. 1986 онд Ширакийн засгийн газар Дээд Захиргааг халж, тус байгууллагын үүргийг ихээхэн өөрчлөн, түүний оронд өөр этгээд томилсон юм. Үүний дараа 1989 онд Рокардийн засгийн газар уг этгээдийг мөн халж CSA-г томилсон нь телевиз радиогийн эрх зүйн зохицуулалтыг улс төрийн хөл бөмбөгийн тоглоом болгон хувиргасан билээ. Үндсэн хуулийн Цэц 1986 болон 1989 Хуулийг тус тус хэлэлцэж байсан бөгөөд ингэхдээ олон тооны мэдээллийн эх сурвалжийн зарчмыг хүлээн зөвшөөрч дээрх хуулиудын тодорхой заалтыг энэ зарчмын дагуу дахин үнэлэн дүгнэх шийдвэр гаргаж байсан. Энэ шийдвэрийн хүрээнд хоёр хуулийн хоёулангийнх нь хувьд нэлээд хэдэн өөрчлөлт оруулах шаардлагатай байлаа.

I. Үйл ажиллагаа

1974 он хүртэл Францын олон нийтийн телевиз радиогийн үйл ажиллагааг засгийн газарт харьяалагддаг нэг байгууллагаа дангаараа явуулж байсан. Тухайн жил уг байгууллагыг “үндэсний нэвтрүүлэг эрхэлсэн” бие даасан долоон компаниудад хувааж тус бүрт тодорхой үйл ажиллагааг хариуцуулсан юм. Өнөөгийн байдлаар 1986 оны хуулийн хүрээнд үүсгэн байгуулагдаж үндэсний нэвтрүүлэг эрхэлсэн таван компани, 1994 оны хуулиар үүсгэн байгуулагдсан нэг компани, нийтдээ зургаан компани үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр компанийн гурван нь телевиз, үлдсэн гурав нь радиогийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд дор дурьдваас:

- Франц 2 компани тус улсын бүх томоохон хот, төв суурин газрын хэмжээнд телевизийн үйл ажиллагаа эрхэлдэг;
- Франц 3 компани томоохон хот, төв суурин газрын хэмжээнд үндэсний болон бүс нутгийн чанартай телевизийн үйл ажиллагаа эрхэлдэг;
- La cinquieme компани соёл урлаг болон танин мэдэхүйн чиглэлийн нэвтрүүлэг цацах онцгой үүрэгтэй телевизийн байгууллага;
- Радио Франц компани радиогийн нэвтрүүлэг цацах ерөнхий үүрэг бүхий байгууллага;
- Radio-France-Outre-Mer компани гадаад орнууд дахь салбар байгууллага ба тус улсын харьяалал бүхий газар нутгийн хэмжээнд радио телевизийн нэвтрүүлэг цацах үүрэгтэй байгууллага;
- Radio-France-Internationale компани олон улсын радио нэвтрүүлэг цацах үүрэг бүхий байгууллага.

Үүний дээр, соёл урлаг болон Европын нутаг дэвсгэрийн хэмжээнд нэвтрүүлэг цацдаг олон нийтээс санхүүждэг La Sept-ARTE сансрын суваг байдаг.

Мөн 1986 оны хуулиар радио телевизтэй холбогдох үйл ажиллагаа эрхэлсэн хэд хэдэн компаниуд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. Тус хуулийн 51-р зүйлд заасны дагуу хөрөнгийн дийлэнхи хувь нь олон нийтийн эзэмшилд байдаг нэвтрүүлэг дамжуулах үүрэг бүхий Teledifusion de France хамтарсан компани байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компанийн гол үүрэг нь олон нийтийн салбарын сувгуудыг дамжуулан нэвтрүүлэхэд оршдог боловч арилжааны компаниудад мөн үйлчилгээг үзүүлж болох юм. Хуулийн 49-р зүйл ёсоор нэвтрүүлгийн сан архивыг баяжуулан хадгалах бөгөөд эдгээр материалаар бусдад үйлчлэх үүргийг олон нийтийн байгууллага болох Istitute national de l'audiovisuel (INA) хэрэгжүүлдэг. Нэвтрүүлэг бэлтгэн гаргах үйл ажиллагааг Societe francise de production et de creation audiovisuelles нэртэй хамтарсан компани эрхэлдэг бөгөөд түүний үйл ажиллагаа нь үндсэндээ олон нийтийн сувгуудад зориулагдсан байдаг.

II. Олон нийтэд үйлчлэх үүрэг

Ижил тэгш зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг арилжааны телевиз радио олон нийтэд үйлчлэх хандлага Францад өнөөг хүртэл хүчтэй оршин тогтносоор иржээ. Олон нийтэд үйлчлэх үүргийн гол зарчмыг “Гол Зүйл” хэмээн нэрлэсэн 1986 оны хуулийн 1-р зүйлд тодорхойлсон байдаг. Энэхүү зүйлд CSA

нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хараат бус байдлыг баталгаажуулж, радио телевизийн бүхий л байгууллагууд чанартай болон өргөн хүрээний нэвтрүүлэг цацах явдлыг хянаж, үндэсний дүрс, дуу авианы нэвтрүүлэг бэлтгэх үйл ажиллагаа, Франц хэл болон соёл урлагийг хөхүүлэн дэмжихийг голлон анхаарах ёстой гэж заасан байдаг.

1986 оны хуульд тусгагдсан олон нийтэд үйлчлэх үүргийн ихэнх нь хувийн болон төрөөс санхүүждэг телевиз радио хоёуланд нь хамаардаг. Жишээлвэл, Conseil d'Etat (захиргааны дээд шүүх танхим)-тай зөвшилцөж, CSA-аас өгсөн зөвлөлгөөнд үндэслэж баталсан журмууд зар сурталчилгаа, оргил цагаар цацах Франц болон Европын телевиз радиогийн нэвтрүүлэгт хамааралтай байдаг бөгөөд үндэсний дүрс, дуу авианы нэвтрүүлэг бэлтгэх үйл ажиллагаанд зохих хувь нэмэр оруулдаг. Хуулийн 15-р зүйл зааснаар CSA нь хувийн болон олон нийтийн компанийн сугваар цацаж буй нэвтрүүлгүүд хүүхэд ба өсвөр насныханд сөрөг нөлөө үзүүлэхгүйг хянах үүрэгтэй. 14-р зүйл улс төрийн сурталчилгааг бүрэн хориглосон байдаг. 1986 оны хуулийн тусгай заалт, тус хуульд хамаарах тогтоол ба үйл ажиллагааны эрх олгох журмаар дамжуулан хувийн телевиз радиогийн байгууллагуудад нэмэлт үүрэг хариуцлага ноогдуулсан юм. 1986 онд хувьчлагдсан Television Francaise (TF1) олон нийтийн тэргүүлэх суваг нь олон нийтэд үйлчлэх бусад байгууллагуудаас илүү хатуу үүрэг хариуцлага хүлээдэг.

Олон нийтэд үйлчлэх хэд хэдэн үүрэг зөвхөн үндэсний хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг компаниудад хамаардаг болно. Үүнд: олон ургальч үзэл бодлыг хүндэтгэн дээдлэн, сонгуулийн сурталчилгаатай холбоотой тусгай үүрэг хүлээх; найрал дуу ба найрал хөгжим, боловсрол танин мэдэхүй, нийгмийн хөгжил болон соёл урлагийг хөхүүлэн дэмжих ерөнхий хариуцлага, үндэсний дүрс, дуу авианы үзвэрийн архив санг хадгалан ашиглах, парламентийн үйл ажиллагаа ба улс төрийн нам, холбоо эвсэл болон мэргэжлийн байгууллагуудын үзэл бодлыг олон нийтэд хүргэх, Ням гариг бүр шашны нэвтрүүлэг явуулах зэрэг орно. Хуулийн 20-р заалтын дагуу үндэсний нэвтрүүлгийн компаниуд үндэсний дүрс, дуу авианы үзвэрийн үйл ажиллагааны хөгжилд зохих хувь нэмрээ оруулах ёстой.

III. Удирдлагын тогтолцоо

A. Дотоод удирдлага

1986 оны хуулийн 44-р зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан дээр дурьсан үндэсний нэвтрүүлгийн таван компани бүгд ижил статустайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаа 1986 оны хуулийн заалттай зөрчилдөх тогтолцоо болон хөрөнгө оруулалтад тавих шаардлага зэрэг асуудлаас бусад асуудлаар арилжааны зохих хуулиар зохицуулагддаг. Тус байгууллагуудын хувьд зөвхөн нэг эзэмшигчтэй байдаг бөгөөд тэр нь төр юм. A *cahier des charges* буюу тус байгууллагуудын Дүрэм эдгээр компаниудийн нэвтрүүлэгт тавих үүрэг хариуцлагыг тодорхойлдог бөгөөд энэхүү үүрэг хариуцлага тэдгээрийн ялангуяа боловсрол, соёл, нийгмийн чиглэлийн үйл ажиллагаанд хамаардаг. Энэхүү Дүрэм нь CSA-ийн санал дээр үндэслэн гаргасан Ерөнхий сайд эсвэл Ерөнхийлөгчийн тогтоолоор батлагддаг туслах чанарын хууль юм. *Caheirs des charges* ба CSA-ийн саналыг Албаны Ёсны Сэтгүүлтэй дүйцэхүйц хэвлэл болох *Journal officiel de la Republic francaise*-д нийтэлсэн байх ёстой.

Үндэсний нэвтрүүлгийн компаниудын *caheirs des charges* буюу Дүрэм ерөнхийдөө төстэй бөгөөд тус компаниудын тус бүрийн үүрэг хариуцлагыг тусгаж, бүгд 1986 оны хуулиар батлагдсан үүрэг хариуцлагад үндэслэгдсэн байдаг. Жишээлвэл, France-2 болон France-3-ын Дүрэм 1994 оны 9 сарын 16-ны тогтоолоор батлагдаж, тус бүрийн хариуцлагын дагуу олон нийтийн бүх салбарыг хамаарсан

мэдээлэл, соёл урлаг ба цэнгээнт нэвтрүүлэг цацах үүргийг эдгээр сувгуудад ноогдуулсан байдаг. Тус Дүрэм дээрхи байгууллагуудын мөрдөх ёстой ерөнхий үүргийг тусгасан байдаг бөгөөд үүнд хүүхэд өсвөр үеийнхнийг хамгаалах; ялангуяа мэдээ болон улс төрийн нэвтрүүлгийн хувьд үнэнч шударга ёс, хараат бус байдал, олон ургальч үзэл бодлыг хөхүүлэн дэмжих; ижил тэгш эрх, хүний нэр хүнд ба CSA-ийн зөвлөмжийг хүндэтгэх зарчмыг баримтлах; Франц хэл болон соёл урлагийг хөхүүлэн дэмжихэд хувь нэмрээ оруулах зэрэг үүрэг багтдаг. Энэхүү баримт бичгүүд Засгийн газрын мэдэгдэл, сонгуулийн сурталчилгаа, Парламентийн үйл ажиллагаа, үйлдвэрчний эвлэлийн үзэл бодол, шашны нэвтрүүлэг, боловсрол танин мэдэхүй ба нийгмийн чанартай тусгай нэвтрүүлэг зэрэг 1986 оны хуульд тусгайлсан үүргийг мөн нарийвчлан тайлбарладаг.

1986 оны хуулийн дагуу 44-р зүйл ёсоор үүсгэн байгуулагдсан нэвтрүүлгийн компаниуд Захирлуудын зөвлөлтэй байх ёстой. Захирлуудын зөвлөл 3 жилийн хугацаатай сонгогдсон 12 гишүүнтэй бөгөөд бүрэлдэхүүнд нь Парламентийн танхим бүрийг төлөөлсөн нэг гишүүн, төрийн төлөөлөгч дөрвөн гишүүн, CSA-ээс нэр дэвшүүлсэн мэргэжлийн дөрвөн гишүүн ба компанийн ажилтан ажилчдыг төлөөлсөн хоёр хүн ордог. Ерөнхийлөгчдөд нэр дэвшигчдийг CSA сонгодог ба тэдгээрийг ажлаас чөлөөлөх эрхийг ч мөн эдэлдэг. France-2, France-3 хоёр байгууллага дундаа нэг Ерөнхийлөгчтэй. Үндэсний нэвтрүүлгийн байгууллагууд нийгмийн өргөн хүрээг төлөөлөх, тэдгээрийн үйл ажиллагааг аливаа нэгэн улс төрийн хүчний нөлөөнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дээрхи тогтолцоог бий болгосон ажээ.

TDF, INA, SFPCA болон 44-р зүйлийн дагуу үүсгэн байгуулагдаагүй үндэсний нэвтрүүлгийн хоёр компани зэрэг олон нийтэд үйлчилдэг бусад радио телевизийн компаниудын хувьцааны дийлэнх буюу 100 хувийг нь төр эзэмшдэг хэдий ч, үйл ажиллагаагаа нь аж ахуйн нэгжийн тухай ерөнхий хуулийн дагуу зохицуулагддаг. INA, TDF зэрэг зарим байгууллагууд *caheirs des charges* буюу байгууллагын Дүрэмд захирагддаг байхад SFPCA зэрэг нь хувийн хэвшлийн компанийн зарчмаар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулдаг. INA нь мөн Захирлуудын зөвлөлтэй бөгөөд түүнийг 44-р зүйлийн дагуу үүсгэн байгуулагдсан нэвтрүүлгийн компаниудын зөвлөлийг томилдог зарчимтай ижил төстөй зарчмаар томилдог.

Б. Зохицуулах механизм

Парламент, засгийн газар болон CSA гэсэн гурван хууль засаглалын байгууллага Францын олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудыг удирдан зохицуулдаг. Парламент радио телевизийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн хүрээг боловсруулах бүрэн эрхтэй бөгөөд шууд хянах эрх нь хязгаарагдмал. Парламент нь мөн санхүүгийн асуудлаар ихээхэн эрх мэдэлтэй байдаг ба парламентийн үйл ажиллагааг нэвтрүүлэх зарчмыг тодорхойлох эрхтэй.

Телевиз радиогийн салбарыг засгийн газрын зүгээс зохицуулах эрх мэдэл нь дээр дурьдсан *caheirs des charges* зэрэг баримт бичиг, тогтоол гаргахад оршдог. Урьд өгүүлсэн олон нийтэд үйлчлэх, тухайлбал зар сурталчилгаа болон оргил цагаар Франц нэвтрүүлэг цацах зэрэг үүргийн ихэнхийг нь засгийн газраас гаргасан тогтоолоор зохицуулдаг. 1986 оны хуулийн 54-р зүйлийн дагуу засгийн газар нь шаардлагатай гэж үзсэн аливаа мэдээлэл мэдээг нэвтрүүлхийг дээрхи байгууллагуудаас шаардах эрхтэй.

CSA нь хувийн болон олон нийтийн телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулах гол байгууллага юм. Дээр дурьдсанчлан, энэхүү байгууллагын тогтолцоо болон эрх мэдлийн хүрээ нь сүүлийн хэдэн жил анхаарлын төвд байсан бөгөөд одоогийн байгууллага нь 1989 онд 1986 оны хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу үүсгэн байгуулагдсан болно. Тус байгууллагын хараат бус байдлыг хуулийн Гол Зүйлд баталгаажуулж, энэхүү хараат бус байдлыг баталгаажуулан бэхжүүлэх тогтолцоог бий

болгоход чиглүүлсэн заалтууд ч энэхүү хуулинд тусгагдсан билээ. Тус байгууллага есөн гишүүнтэй ба тэдгээрийг ижил тэгш пропорцоор Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Үндэсний Ассамблей болон Сенатаас нэр дэвшүүлсэний үндсэн дээр Ерөнхийлөгч томилдог. Гишүүдийг зургаан жилийн хугацаагаар томилж, томилолтын хугацааг сунгаж буюу хүчингүй болгохыг хориглосон. CSA-ийн Ерөнхийлөгчийг Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч томилдог. Хуулийн 5 ба 8-р зүйл ёсоор CSA-ийн гишүүд сонирхлын зөрчил, мэргэжлийн нууцын хатуу зарчимд захирагддаг ба энэхүү зарчмын дагуу тэдгээрийн үүрэг хариуцлагад үл нийцэх үйл ажиллагаанд оролцох (жишээлвэл, сонгуульт ажил эрхлэх) болон CSA-ийн хэлэлцэж байсан буюу хэлэлцэж буй асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхгүй байдаг. CSA-ийн үйл ажиллагааг бүхэлд нь төрөөс санхүүжүүлдэг.

CSA олон нийтэд үйлчлэх үүрэг, үндэсний нэвтрүүлгийн компаниудын Дүрэм болон Захирлуулын зөвлөлийн Ерөнхийлөгчдийг томилох талаар өргөн хүрээний эрх мэдэлтэй байдаг. Зөвлөлийн Ерөнхийлөгчдийг томилох болон тэдгээрийн гишүүдэд нэр дэвшүүлэх эрхтэй боловч үндэсний нэвтрүүлгийн компаниудын удирдлагад хөндлөнгөөс оролцох эрх CSA-д байхгүй. Тус байгууллага дараахи гурван чиглэлээр дүрэм журам тогтоох шууд эрх мэдэлтэй. Үүнд: сонгуулийн үеийн радио телевизийн нэвтрүүлэг, санал гомдолд хариу өгөх, улс төрийн нам, үндэсний холбоо зөвлөл ба мэргэжлийн байгууллагуудын үзэл бодлыг олон нийтэд дамжуулах зэрэг орно. Мөн зар сурталчилгаа нэвтрүүлэх журам зэрэг олон нийтэд үйлчлэх үүрэгт хамаарагдах асуудлаар саналаа өгөх эрхтэй. CSA-д зар сурталчилгаа болон ивээн тэтгэх асуудлаар ихээхэн хэмжээний эрх мэдэл олгох оролдлого 1989 онд үндсэн хуультай зөрчилдөж буй гэсэн үндэслэлээр батлагдаагүй болно.

1986 оны хуулийн 18-р зүйлд зааснаар CSA жилийн тайлангаа Бүгд Найрамдах улсын Ерөнхийлөгч, Засгийн газар болон Парламентад өргөн барих ёстой. Тайланд уг байгууллагын үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт болон олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд энэ хугацаанд үүрэг хариуцлагаа хэрхэн биелүүлсэн талаар мэдээлэл орсон байна. Тус байгууллага нь хуулийн буюу эрх зүйн өөрчлөлт оруулах санал, үйл ажиллагаа явуулах эрхийн хураамж болон зар сурталчилгааны орлогыг олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хооронд хэрхэн хуваарилах талаарх ажиглалтаа энэхүү тайланд мөн оруулж болно.

Үндэсний нэвтрүүлгийн компаниуд хуулийг сахиулахтай холбогдох асуудлаар CSA нь тодорхой хэмжээний эрх мэдэлтэй. 1986 оны 20-р зүйлд зааснаар тус байгууллагын Ерөнхийлөгч нь нарийвчлан шалгаж дүгнэлт гаргасны үндсэн дээр үүрэг хариуцлагаа зөрчсөн аливаа хэргийг Төрийн нэрийн өмнөөс шүүхэд шилжүүлэх эрхтэй. Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд CSA олон нийтийн хяналтыг тогтоож, тус байгууллагын Захирлуудын зөвлөлд хандаж болно. Мөн *saheir des charges* тус байгууллагын Дүрмийн\ийг ноцтой зөрчсөн тохиолдол гарваас CSA нь тодорхой цаг хугацаанд хэрэгжүүлвэл зохих арга хэмжээ авахыг байгууллагын Ерөнхийлөгчид удирдамж болгох эрхтэй.

1986 оны хуульд 1994 онд оруулсан нэмэлт өөрчлөлт CSA-ийн үндсэний нэвтрүүлгийн компаниудын хууль хэрэгжүүлэх асуудалд тавих хяналтыг улам бэхжүүлсэн юм. Энэхүү нэмэлт өөрчлөлтийн дагуу тус байгууллага нь хуулиар заасан үүргээ сахихыг дээрхи компаниудаас шаардах, энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдол гарч үүний талаар сануулга өгсний дараа тухай байгууллагын нэвтрүүлгийн зарим хэсгийг нэг сар хүртэлх хугацаагаар зогсоох буюу торгууль тавих эрхийг эдэлдэг. Мөн үүргээ хариуцлага зөрчсөн гэдэг мэдэгдлийг өөрийн сувгаар дамжуулан нэвтрүүлэх шаардлага тавьж, үл тэгвээс торгууль ноогдуулна. Тухайн компани CSA-ийн уг шийдвэрийг Conseil d'Etat-д шийдвэр гарсанаас хоёр сарын дотор давж заалдаж болно.

IV. Санхүүжилт

Францын олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн санхүүгийн гол их үүсвэр нь телевиз эзэмшигч бүр жилд ойролцоогоор 150 америк доллар төлдөг хураамж бөгөөд энэ нь тус салбар дахь орлогын 70 орчим хувийг эзэлдэг. 1998 онд энэхүү хураамжаас олсон орлого 11 тэрбум франк болохоор төлөвлөгдсөн ба өнгөрсөн жилтэй харьцуулвал энэ нь 7%-иар нэмэгдэх юм. Үлдсэн орлогын зонхилох хэсэг зар сурталчилгааны үйл ажиллагаа болон ивээн тэтгэлэгээс бүрддэг. Мөн үндэсний нэвтрүүлгийн компаниуд эрхийг нь авсан тохиодолд аудио видео үзвэрийн уран бүтээлээ бусдад худалдаж болно.

Хураамжийн хэмжээг Парламент жил бүр тогтоодог бөгөөд хураамжаас олсон орлогыг үндэсний нэвтрүүлгийн компаниуд ба INA дунд хуваарилах зарчмыг баталдаг. Энэхүү хуваарилалтыг хийхдээ тухайн компанийн төсөвлөгдсөн төсөв, нөөц, телевиз радиогийн нэвтрүүлгийн үйлдвэрлэлийг дэмжих үйлсэд оруулсан хувь нэмэр, олон нийтэд үйлчлэх үүргээ хэрхэн хэрэгжүүлж ирсэн зэрэг үзүүлэлтийг харгалзана. Компани тус бүрийн нийт төсөвт эзлэх хураамжийн орлогын хувь янз бүр байдаг бөгөөд 1998 онд хамгийн доод тал нь France-2 хувьд 48 хувь, дээд тал нь Radio-France-Internationale ба La Sept-ARTE 99 хувьд хүрч байсан юм (доорхи хүснэгтийг үзнэ үү). Тус улсын хамгийн нөлөө бүхий олон нийтийн хоёр суваг орлогынхоо ихэнх хувийг зар сурталчилгааны үйл ажиллагаанаас олдогийг хүснэгтээс харж болно.

Олон нийтийн их сурвалжаас олсон төсвийн хувь

	1997	1998
INA	54.7	57.9
France 2	47.9	47.6
France 3	60.7	60.2
La Sept-Arte	98.4	98.8
La Cinquieme	95.4	96.1
Radio France	92.4	92.5
RFO	94.2	93.2
RFI	98.6	98.9
Нийт	69.1	69

Үндэсний нэвтрүүлгийн компаниудын зар сурталчилгааны үйл ажиллагаанаас олсон орлого хатуу хяналтан дор байдаг. Парламент зар сурталчилгааны орлогод 1987 онд хязгаар тогтоосон. 1986 оны хуулийн олон заалтад зар сурталчилгааны агуулгыг хязгаарлах эсвэл засгийн газрын хяналтан дор нэвтрүүлхийг тусгасан байдаг. 73-р зүйлийн дагуу киноны дундуур зар сурталчилгаа нэвтрүүлхийг хориглосон болно. 48-р зүйл зар сурталчилгааг хэрхэн нэвтрүүлэх, зар сурталчилгааны зөвшөөрөгдсөн дээд хэмжээг cahiers des charges–д тусгасан байхыг шаардлага болгодог. Жишээлвэл, France-2-ын хувьд зар сурталчилгааг цагт дунджаар зургаан минут, хамгийн дээд хязгаар нь цагт арван хоёр минут нэвтрүүлэх эрхтэй бол France–3–ын хувьд энэхүү хэмжээ нь тус тус тав болон арван минут байдаг юм. Ихэнхи cahiers des charges зар сурталчилгааг франц хэл дээр нэвтрүүлхийг заасан байдаг. Дээрхи хязгаарлалтыг олон нийтийн аюулгүй байдал ба хэв журам, үнэн зөв ёс, шударга ёс, хүнийг хүндэтгэх, хэрэглэгчдийн ба хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тавьдаг ажээ. 1992 оны 3 сарын 27-ны Тогтоол

нь зар сурталчилгааны талаархи ерөнхий зарчмыг нэвтрүүлж зарим бүтээгдэхүүний сурталчилгааг хориглох, сурталчилгаа ойлгомжтой тодорхой байх, тогтмол нэвтрүүлгийн дундуур сурталчилгаа явуулахгүй байх зэрэг нөхцлийг тусгасан юм.

Үндэсний нэвтрүүлгийн компаниуд тэдгээрийн зөвхөн боловсрол танин мэдэхүй, нийгэм соёл урлагийг дэмжих зорилгод нь нийцсэн мэдээллийн бус зарим нэвтрүүлгээ бусдаар ивээн тэтгүүлж болдог. 1992 оны Тогтоолд ивээн тэтгэлэг нь өөрийн брэнд, нэр, дүр төрх болон үйл ажиллагааг сурталчлуулах зорилгоор телевизийн программыг санхүүжүүлэх явдал гэж тодорхойлжээ. Ивээн тэтгэх үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн худалдан авах уриа, бүтээгдэхүүний борлуулалтыг урамшуулсан мэдээлэл агуулж болохгүй. Зарим төрлийн компаниуд ивээн тэтгэлэг хүлээж авах эрхгүй байдаг ба ивээн тэтгэлгээр санхүүжсэн нэвтрүүлгийг ил тодоор зарлах үүрэгтэй.

ЯПОН

Танилцуулга

Японы олон нийтэд үйлчилдэг Телевиз Радиогийн байгууллага болох Ниппон Хосо Кёкай буюу Эн-Эйч-Кей нь анх 1926 онд хотын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байсан гурван радио нэгдсэнээр үүсэн байгуулагдсан. Тэр үеэс хойш уг байгууллага хөгжин ахисаар дэлхийн хамгийн сайн санхүүжилтийн тогтолцоотой олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага болж чадсан гэж хэлж болно. 1999 оны нийт зардал нь л гэхэд 625 тэрбум иен буюу ойролцоогоор 6 тэрбум америк доллараас давж байв. Өнөөгийн байдлаар Эн-Эйч-Кей нь 1950 оны Телевиз Радиогийн Хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын сонгодог загвараар үйл ажиллагаагаа явуулж байна.

I. Үйл ажиллагаа

Эн-Эйч-Кей нь үндэсний 5 телевиз, 3 радиогоор нэвтрүүлэг бэлтгэн цацдаг. Мөн Эн-Эйч-Кей Уелд Ти Ви, Эн-Эйч-Кей Уелд Премиум болон Эн-Эйч-Кей Уелд Японы Радио зэргийг багтаасан дэлхийн хэмжээнд нэвтрүүлгийн сүлжээтэй. ЭН-ЭЙЧ-КЕЙ нь Ерөнхий Суваг, Боловсролын Телевиз гэсэн газрын дамжуулалттай хоёр телевизтэй юм. Ерөнхий суваг нь ЭН-ЭЙЧ-КЕЙ-ийн телевизийн гол суваг бөгөөд мэдээ мэдээлэл, боловсрол, соёлын болоод цэнгээнт нэвтрүүлгийг тэнцвэртэйгээр агуулсан сүлжээтэй юм. 1997 оны байдлаар сүлжээний 41%-г нь мэдээ, 19%-г боловсрол, 29%-г нь соёл, 11%-ийг цэнгээнт нэвтрүүлэг эзэлж байжээ.

Боловсролын суваг нь голдуу сургалт танин мэдэхүйн (77%) болон соёл урлагийн (20%) нэвтрүүлгийг явуулдаг. Бусад гурван телевизийн хувьд нэвтрүүлгээ хиймэл дагуулаар дамжуулан захиалсан хэрэглэгчдэд хүргэдэг бөгөөд нийтдээ 9 гаруй сая үзэгчтэй юм. Ди Би Эс-1 телевиз нь мэдээ, баримтат болон спортын нэвтрүүлэг цацдаг бол Ди Би Эс-2 ийн суваг нь цэнгээнт болон урлаг уран сайхны нэвтрүүлгийг голчилдог. Хай-Вижн буюу дүрс дууны өндөр технологийн дамжуулалт бүхий телевиз нь 1994 оноос нэвтрүүлгээ цацаж эхэлжээ.

Радио-1 нь мэдээ, шуурхай мэдээллийн суваг юм. Уг радио шуурхай мэдээ явуулахаас гадна байгалийн гамшиг болон бусад гамшиг, онцгой тохиолдлын үед цаг хоромтой өрсөн мэдээлэл хүргэх уян

хатан сүлжээтэйгээрээ бахархдаг. Радио-2 нь боловсрол танин мэдэхүйн чиглэлтэй байхын зэрэгцээ гадаад хэл дээр нэвтрүүлгээ явуулдаг. Эн-Эйч-Кей-гийн FM радио нь сонгодог хөгжмийн болон бүс нутгийн хөтөлбөр бэлтгэдэг хөгжмийн суваг юм.

II. Олон нийтэд үйлчлэх үүрэг

Эн-Эйч-Кей нь Японы бүх телевиз радиогийн байгууллагуудын хүлээх нийтлэг үүргээс гадна олон нийтийн нэвтрүүлэг явуулдаг байгууллагын хувьд тусгай үүргүүдийг бас хүлээдэг. Телевиз Радиогийн хуулийн 3.2-р зүйлд заасны дагуу, телевиз радиогийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдал, ёс суртахууны хэв ёсыг эвдэхгүй бөгөөд улс төрийн нөлөөнөөс ангид, үнэн зөв мэдээлэлтэй, аливаа асуудлыг тал бүрээс нь авч үзэх зарчмыг баримтлах үүрэгтэй. Телевиз радиогийн байгууллага сүлжээндээ соёл, боловсрол танин мэдэхүй, мэдээ болон цэнгээнт гэхчилэн төрөл бүрийн нэвтрүүлэг оруулж байх ёстой. Тэд хараагүй хүмүүст дуу авианы, харин сонсголтгүй хүмүүст дүрсээр дамжуулан телевизийн хөтөлбөрийг ойлгоход нь бололцооны хэрээр тус дэм болж байх үүрэгтэй. 3.3-р зүйлийн дагуу телевиз радиогийн байгууллага нь нэвтрүүлгийн төрөл бүрт тохирохуйц олон нийтийн нэвтрүүлгийн нийтлэг стандартыг тогтоон мөрдөх ёстой.

Дээр дурдсан хуулийн 7-р зүйлд зааснаар Эн-Эйч-Кей-ийн ерөнхий зорилтууд нь олон нийтийн сайн сайхны төлөө дотооддоо өндөр чанартай баялаг нэвтрүүлгийг Япон улсын нутаг даяар хүлээн авч болохуйцаар бэлтгэн цацах болон гадаадад нэвтрүүлгээ цацах явдал юм. 44-р зүйл нь 3.2-р зүйлд заасан телевиз радиогийн бүх байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий зарчим дээр нэмээд Эн-Эйч-Кей-ийн олон нийтийн нэвтрүүлгийн нэмэлт үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Эдгээр нэмэлт үүргийн дотор ард иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлсэн нэвтрүүлэг явуулах, соёл иргэншлийн түвшинг нэмэгдүүлэх, бүс нутгийн болон улс орны хэмжээний нэвтрүүлэг явуулах, орчин цагийн дэвшилтэт зүйлийг танилцуулах болон түүхийн сайн сайхныг хадгалан үлдээх зэрэг багтана. Гадаад нэвтрүүлэг нь гадаад орнуудад Япон улс, Японы соёлыг сурталчилан таниулах замаар олон улсын эв найрамдал, эдийн засгийн харилцааг хөгжүүлхийн зэрэгцээ хилийн чанадад амьдарч буй Япончуудын сонирхолд нийцсэн мэдээллээр хангах зорилготой байна.

III. Удирдлагын зохион байгуулалт

A. Дотоод удирдлага

Телевиз Радиогийн хуулийн 8-р зүйлд заасны дагуу Эн-Эйч-Кей нь Токио хотноо байрлах төв бүхий хуулийн этгээд юм. 11-р зүйлийн дагуу Корпорацийн Дүрэмд Эн-Эйч-Кей нь Захирагчдын Зөвлөл, Захирлуудын Зөвлөлтөй байх ба үүний дээр 24-р зүйлд зааснаар Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, ЭН-ЭЙЧ-КЕЙ-ийн ажилтанд тооцогдох гурван аудиторын орон тоотой байна. Телевиз радиогийн бүх байгууллагууд, тэр дундаа ЭН-ЭЙЧ-КЕЙ-ийн хараат бус байдлыг 3-р зүйлийн заалт хангаж өгдөг. Энэхүү заалт хуульд өөрөөр заагаагүй бол нэвтрүүлгийн хөтөлбөрт аливаа этгээд хөндлөнгөөс оролцох буюу зохицуулахыг хориглосон байдаг.

Захирагчдын Зөвлөлийн үүрэг удирдлага, бодлого болон ЭН-ЭЙЧ-КЕЙ-тэй холбоотой бусад чухал асуудлаар шийдвэр гаргахад оршино. 14-р зүйл ёсоор захирагчид төсөв болон санхүү төлөвлөлтийн

бусад асуудал, нэвтрүүлгийн станцуудын төлөвлөгөө, 3.3-р зүйлд заасан нэвтрүүлгийн стандарт болон ажилтнуудын цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй. Мөн захирагчид нийт 12 гишүүний 9-өөс доошгүй санал хураалтаар Ерөнхийлөгч болон аудиторруудыг томилохоос гадна Ерөнхийлөгчөөс Дэд ерөнхийлөгч болон захирлуудыг томилсныг баталдаг.

Нийт 12 захирагч байх бөгөөд тэд дотроосоо даргаа сонгоно. 16-р зүйлд заасны дагуу захирагч нарыг хоёр Танхимын хоёулангийг нь зөвшөөрөлтэйгөөр Ерөнхий сайд боловсрол, соёл, шинжлэх ухаан аж үйлдвэрийн мэдлэг туршлагатай, шудрага шийдвэр гаргах чадвартай хүмүүсээс сонгон томилно. Хавсралтын жагсаалтад орсон 8 дүүрэг бүрээс нэг захирагчийг сонгон томилсон байх ёстой. Ял эдэлж байсан, эс бөгөөс сүүлийн хоёр жил дотор зохисгүй үйлдлийн улмаас олон нийтийн салбарын, төрийн ажлаас халагдаж байсан, үндэсний төрийн ажилтан буюу улс төрийн аль нэг намын удирдлагын гишүүн, эсвэл телевиз радио болон түүнтэй холбогдолтой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын их хэмжээний эзэмшигч хэн ч болов захирагчаар томилогдож болохгүй. 20-р зүйлийн дагуу, дөрвөөс дээшгүй захирагч ямарваа нэг намын харъяалалтай байна.

Ерөнхий сайд нь томилсоны шалгуур нөхцөлд нийцэхгүй болсон, ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй гэж үзсэн, эсвэл албан үүрэгтээ харш үйлдэл хийсэн буюу хууль бус үйл ажиллагаа явуулж захирагчийн албан тушаалд тохирохгүй гэдгээ харуулсан тохиолдолд 20-р зүйлийн дагуу хоёр Танхимын хоёулангийг нь зөвшөөрөлтэйгөөр үүрэгт ажлаас чөлөөлж болно. Эдгээрээс бусад нөхцөлд 21-р зүйлд заасны дагуу захирагчийг өөрийн хүсэлтийг үл харгалзан ажлаас нь чөлөөлхийг хориглоно.

Захирлуудын зөвлөл нь Захирлууд, Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчөөс бүрдэх ба Эн-Эйч-КЕЙн үйл ажиллагааны гүйцэтгэлтэй холбогдсон асуудлыг хариуцна. 26-р зүйлийн дагуу Ерөнхийлөгч нь Эн-Эйч-Кей-г төлөөлөх ба зөвлөлийн даргаар ажиллана. 16-р зүйлийн дагуу захирагч байхыг хориглосон нөхцөл мөн Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Захирлууд болон аудиторруудад тус тус хамаарна.

29-р зүйлийн дагуу Захирагчдын зөвлөл албан тушаалдаа тэнцэхгүй гэдгээ харуулсан, эсвэл албан үүрэгтээ харш үйлдэл хийсэн, эсвэл хууль бус үйл ажиллагаа явуулж албан үүрэгтээ тэнцэхгүйгээ харуулсан Ерөнхийлөгч, эсвэл аудиторуыг үүрэгт ажлаас чөлөөлөх эрхтэй. Мөн энэ шалтгаанаар Ерөнхийлөгч захирагч нартай зөвшилцсөний үндсэн дээр Дэд Ерөнхийлөгч эсвэл Захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

Б. Зохицуулах механизм

3.4-р зүйлийн дагуу телевиз радиогийн аль ч байгууллага нэвтрүүлгийн чанар үйлчилгээг хянах зорилгоор Зөвлөх Нэгжийг байгуулах ёстой. 3.3-р зүйлд заасан нэвтрүүлгийн стандартыг сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулахдаа энэхүү Зөвлөх нэгжтэй зөвшилцөх үүрэгтэй бөгөөд байгууллага нь хуулийн дагуу уг нэгжийн санал зөвлөмжийг тусгах үүрэгтэй. Зөвлөх нэгжийн үйл ажиллагааг дэмжих үүднээс телевиз радиогийн байгууллага нь энэхүү нэгжийг бүх төрлийн мэдээллээр, тэр дундаа уг нэгжийн зөвлөмжийг хэрхэн тусгаж ажил хэрэг болгосон талаарх мэдээ сэлтээр хангах ёстой юм.

Эдгээр үүрэг шаардлагуудыг 44.2-р зүйлд нарийвчлан заасан бөгөөд Эн-Эйч-Кей-д тавигдах онцгой шаардлага нь дотоод, гадаад нэвтрүүлгийг хянах үүрэг бүхий зөвлөх төв нэгж болон бүс нутгийн зөвлөх нэгжүүдийг байгуулах явдал юм. Эдгээр нэгжийн гишүүдийг тухайн газар нутагт оршин суудаг шалгуур, мэдлэг туршлагынх нь дагуу Ерөнхийлөгч Захирагчдын зөвлөлтэй хэлэлцсэний үндсэн дээр нэр дэвшүүлнэ. Үүний зэрэгцээ, Эн-Эйч-Кей шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааг тогтмол явуулж, үр дүнг нь олон нийтэд зарлах үүрэгтэй байдаг. 9(6)-р зүйлд зааснаар Эн-Эйч-Кей нь телевиз радиод мэдлэг

туршлагатай буюу холбоотой хүмүүсийн байгууллагын цаашдын хөгжилд нь ахиц хувь нэмэр оруулах бүхий саналыг хүлээн авч тусгах үүрэгтэй.

4-р зүйлийн заалт ёсоор үнэн бус мэдээлэл нэвтрүүлгээр явснаас хохирсон хүн бүр тухайн мэдээлэл явуулсан байгууллагаас хариу авах эрхтэй бөгөөд байгууллага нь хөтөлбөртөө буруу ташаа мэдээлэл орсныг мэдмэгц залруулж байх үүрэгтэй. Энэхүү эрхийг нэвтрүүлэг цацагдсанаас хойш 3 сарын дотор эдлэх боломжтой бөгөөд энэ зорилгоор хүүлийн 5–р зүйлд нэвтрүүлгийн гарснаас хойш материалыг 3 сарын турш архивлан хадгалж байхаар заажээ.

33–р зүйлийн дагуу Шуудан Харилцаа Холбооны сайд Эн-Эйч-Кей-д гадаад нэвтрүүлэг явуулах үүрэг өгч болно. Мөн 34-р заалт ёсоор Сайд Эн-Эйч-Кей-д нэвтрүүлэг, үйл ажиллагааг сайжруулан хөгжүүлэх зорилгоор судалгаа хийх үүрэг өгөх эрхтэй. Дээр дурдсан хоёр үүрэгтэй холбоотой зардлыг төрөөс гаргах ёстой.

Эн-Эйч-Кей нь Сангийн сайдаас урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдолд бонд гаргах бөгөөд Шуудан Харилцаа Холбооны Сайдын зөвшөөрөлгүйгээр өөрийн тоног төхөөрөмжийг бусдад шилжүүлэх буюу түрээслүүлэх эрхгүй. Мөн үүний адилаар, Эн-Эйч-Кей Шуудан Харилцаа Холбооны сайдаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд өөрийн нэвтрүүлгийн аль ч станцын үйл ажиллагааг хаах буюу 12 цагаас дээш хугацаагаар түр зогсоон саатуулахыг хориглоно. 2-2–р зүйл ёсоор уг Сайд нэвтрүүлгийн станцуудтай холбоотой хэд хэдэн асуудлыг багтаан ерөнхий төлөвлөгөөг боловсруулах үүргийг хүлээнэ. Сонгуулийн сурталчилгааны үеэр Эн-Эйч-Кей нэр дэвшигчдэд үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нь олгож болох бөгөөд ингэхдээ бүх нэр дэвшигчдэд ижил бололцоог олгох ёстой. Эн-Эйч-Кей нь жил бүрийн орлого зарлагын тайлан болон жилийн ерөнхий тайланг боловсруулж Шуудан Харилцаа Холбооны сайдад өргөн барих үүрэгтэй. Сайд уг тайланг Засгийн газраар уламжлан өөрийн дүгнэлт болон аудиторчуудын үзэл бодлыг хамтатган Парламентад өргөн барина.

IV. Санхүүжилт

9 (4)–р заалт нь Эн-Эйч-Кей ашиг орлогын үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг. Мөн 46–р заалт ёсоор Эн-Эйч-Кей төлбөрт реклам зар сурталчилгаа явуулах ёсгүй. Харин 32–р заалтын дагуу Эн-Эйч-Кей–ийн нэвтрүүлгийг хүлээн авах төхөөрөмжтэй хүн бүр Эн-Эйч-Кей–д хураамж төлөх ёстой бөгөөд энэ нь уг байгууллагын орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг. Эн-Эйч-Кей–ийн 1999 оны тайланд тус байгууллагын 1999 оны 635 тэрбум иений нийт орлогынх нь 98 хувь тэрхүү хураамжаас бүрдсэн байв. 1998 онд 36 сая айл өрх Эн-Эйч-Кей–д хураамж төлж байсны дээр Эн-Эйч-Кей–ийн хиймэл дагуулын нэвтрүүлгийг 9 сая хэрэглэгч захиалж байжээ.

ӨМНӨД АФРИК

Танилцуулга

Өмнөд Африкийн Телевиз Радиогийн Корпораци (ӨАТРК) нь тус улсын төрийн болон олон нийтийн байгууллагуудын нэгэн адил сүүлийн хэдэн жилийн дотор томоохон өөрчлөлтүүдийг нэвтрүүлж шинэ цагийн ардчиллын хөгжилтэй хөл нийлүүлэн Өмнөд Африкийн бүх иргэдэд үйлчлэх зорилго тавьж ажиллаад байна. ӨАТРК-ийн үйл ажиллагааны гол мөрдлөг болсон Телевиз Радиогийн тухай шинэ хууль

1999 онд батлагдсан бөгөөд (цаашид 1999 оны Акт гэх) урьд мөрдөж байсан 1976 оны хуулийн заалтуудыг багагүй өөрчилж шинэчилж хэрэгжилт нь дөнгөж эхлээд байна.

1999 оны хуулийн дагуу ӨАТРК-ийн статусыг хувьцаат хөрөнгө бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж тодорхойлсон бөгөөд үүнтэй уялдан үйл ажиллагаа нь Аж Ахуйн Нэгжийн хуулиар зохицуулагдах учиртай хэдий ч Телевиз Радиогийн хуулийн 7-р бүлэгт ӨАТРК-г аж ахуйн нэгжийн хувьд өвөрмөц үйл ажиллагаатайг нь харгалзан аж ахуйн бусад нэгжүүдэд хамаарах журмыг өөрчлөн тус байгууллагад мөрдлөг болгоно гэж тусгаж өгсөн юм. Тухайлбал, дээрх хуулийн 19 (1)-р бүлэгт заасны дагуу төр ӨАТРК-ийн 100%-ийн хувьцааг эзэмшдэг нь 7 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй байна гэсэн аж ахуйн бусад нэгжийн зохицуулалтыг өөрчилж, тусгайлан авч үзсэн нь илт байна. Уг хуулийн 9-р бүлэгт заасны дагуу ӨАТРК дотроо олон нийтийн үйлчилгээ болон арилжааны үйл ажиллагаа гэсэн хоёр тусдаа хуваагддаг бөгөөд энэхүү салбарууд нь дээрээ нэг удирдлагатай. Арилжааны салбар бусад арилжааны телевиз радиогийн байгууллагуудтай адилтган үзнэ, харин олон нийтэд үйлчилдэг салбарын үйл ажиллагааг тусгайлсан хууль журмаар зохицуулна.

Телевиз Радиогийн Хараат Бус Захиргаа (ТРХБЗ)-г 1993 онд батлагдсан хуулийн (1993 Акт гэх) дагуу үүсгэн байгуулагдсан байгууллага юм. ТРХБЗ нь телевиз радиогийн байгууллагуудын үйл ажиллагааг, ялангуяа хураамжийн асуудлыг зохицуулах эрх бүхий байгууллага байхын зэрэгцээ 1993 оны хуулиар хувийн хэвшлийн телевиз радиогийн үйл ажиллагааны зохицуулалтыг үндсээр нь өөрчилсөн юм. ТРХБЗ нь ӨАТРК-ийн үйл ажиллагааг ч бас тодорхой хэмжээгээр зохицуулах эрхтэй байдаг. Дээр дурьдсан томоохон өөрчлөлт шинэчлэл гарсантай холбогдон ӨАТРК одоогоор ид шилжилтийн үедээ явж байгаа гэж хэлж болно. Эдгээр өөрчлөлт шинэчлэлтийн үр шим одоогоор бүрэн гарч амжаагүй байгаа юм. Үүний зэрэгцээ, ӨАТРК учирч буй санхүүгийн бэрхшээлийг даван туулахын тулд, энэхүү судалгаанд хамрагдсан олон нийтэд үйлчилдэг бусад байгууллагуудтай адил олон нийтээс авч буй хураамжийг хөрөнгийн эх үүсвэр болгох бус, харин ихэвчлэн зар сурталчилгааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлж байна. Цаашид тус байгууллагын урт хугацааны гол зорилт нь үйл ажиллагаагаа олон нийтийн болон арилжааны салбарыг тусгаарлан, арилжааны салбар нь нөгөөгөө санхүүжүүлэх системтэй болох явдал юм. Энэ өөрчлөлт шинэчлэл хэр үр дүнтэй болох хийгээд аль хэр явцтай байх нь одоогоор тодорхойгүй байна.

I. Үйл ажиллагаа

Дээр дурьдсанчлан, 1999 оны хуулиар ӨАТРК-ийн үйл ажиллагааг ерөнхийд нь олон нийтийн болон арилжааны чиглэлээр хуваана. Одоогийн байдлаар ӨАТРК-ийн чухам аль хэсгийг олон нийтийнх гэж үзэх, алиныг нь арилжааныхад тооцох эсэхийг тодорхой тогтоож товлоогүй байна. Ийм тодорхойгүй нөхцөл байдал үүссэн гол шалтгааны нэг бол 1999 оны хуулийн 1-р бүлгийн заалт юм. Учир нь уг заалтын дагуу “Олон нийтэд үзүүлэх телевиз радиогийн үйлчилгээ” гэдэг ойлголтод ӨАТРК-ийн бүхий л үйлчилгээ, түүний дотор арилжааны чиглэлийн үйл ажиллагааг ч багтаасан байтал, 9 (1) бүлгийн заалт нийт үйл ажиллагааг нь “олон нийтийн үйлчилгээ” болон “арилжааны үйл ажиллагаа” гэж хоёр зааглаж ялгасан байдаг. Лиценз буюу хураамжийн хувьд, ТРХБЗ нь үйлчилгээг “олон нийтийн”, “арилжааны” болон “community” гэж ангилж шаардлага тавьдаг.

Хэдийгээр телевизор, нэвтрүүлэг хүлээн авагчийн тоо ширхэг цөөнтэйн дээр хөдөө орон нутагт эрчим хүчний дутагдалтайн улмаас Өмнөд Африкийн хүн амын цөөн хувь телевизийн нэвтрүүлэг үзэх боломжтой боловч, одоогоор ӨАТРК нь Эс Эй Би Си-1, Эс Эй Би Си-2, Эс Эй Би Си-3 гэсэн телевизийн

гурван сувагтай бөгөөд улсын нийт нутаг дэвсгэрийн 80%-д нэвтрүүлгээ цацаж байна. 1998 онд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд нийт 40 гаруй сая хүн амаас 14 орчим сая нь өдөр бүр ӨАТРК-ийн телевизийн хөтөлбөрийг үзэж байв. Мөн судалгаагаар, Үзэгчдийн тоогоороо Эс Эй Би Си-1 хамгийн олон үзэгчтэй, удаад нь Эс Эй Би Си-2, хамгийн бага нь Эс Эй Би Си-3 телевизийн суваг орж байжээ. Цаашид Эс Эй Би Си-2 олон нийтэд үйлчилдэг суваг, харин Эс Эй Би Си-1, Эс Эй Би Си-3-ыг арилжааны зарчмаар ажиллуулах магадлал бий.

ӨАТРК нь үндэсний сүлжээнд багтах 19 радио станцтай. Эдгээрээс 11 станци нь тус улсын 11 албан ёсны хэлээр (9 Африк хэл, Англи хэл болон Африкан хэл) нэвтрүүлгээ явуулдаг гадна, 1 гадаад нэвтрүүлэг, бүс нутгийн цөөн хэдэн станцийн зэрэгцээ хөгжмийн нэвтрүүлэг голдуу явуулдаг Англи хэлний хэд хэдэн станци байдаг. ӨАТРК-ийн эдгээр станцууд нь нийлээд өдөрт 14 сая сонсогчдод үйлчилдэг ба тэдгээр сонсогчдын дийлэнх нь Африкийн хэлээр нэвтрүүлгээ цацдаг 9 станцийг сонсдог юм.

II. Олон нийтэд үйлчлэх үүрэг

1999 оны хуулийн 8-р бүлгийн заалт нь ӨАТРК-ийн ерөнхий үйл ажиллагаа, үүний дотор олон нийтийн үйлчилгээ болон арилжааны үйл ажиллагааг аль алиныг нь багтаасан ерөнхий зорилт, чиг шугамыг тодорхойлж өгсөн байдаг. Түүнчлэн 10, 11-р бүлгийн заалтууд нь олон нийтийн болон арилжааны үйл ажиллагааны зорилгыг тус тусд нь нарийвчлан тодорхойлдог.

8-р бүлэгт заасаар дагуу олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын үүрэг хариуцлагын зарчмын дагуу ӨАТРК нэвтрүүлгээ Өмнөд Африк улсын нутаг дэвсгэр даяар чөлөөтэй цацах бөгөөд мэдээлэл, сургалт танин мэдэхүй болон цэнгээнт хөтөлбөрийг нэвтрүүлгийн сүлжээндээ оруулж өгөх үүрэгтэй юм. Мөн хуулийн 8-р зүйлийн заалтад дурьдсанаар ӨАТРК нь өөрийн зорилго чиглэлдээ нийцсэн номын сан болон архивтай байх, мэдээ мэдээлэл цуглуулах, мэдээллийн агентлаг байгуулах буюу захиалгаар мэдээлэл авах, шинэ технологийн судалгаа хийж, Өмнөд Африкийн авъяастнуудыг хөхүүлэн дэмжих, хүн амын үйлдвэрлэлийн чадавхи чадварыг дээшлүүлэх сургалт явуулах үүргийг хүлээнэ.

10-р бүлэгт заасны дагуу, уг байгууллагын олон нийтэд үйлчлэх үүрэг бүхий нэвтрүүлгүүд албан ёсны бүх хэлээр явагдах ёстой бөгөөд байгууллага нь Өмнөд Африкийн нэгдмэл байдал, соёлын өв болон хэлний онцлогийг тусгасан, улс орныхоо уламжлалт болон орчин цагийн соёлын өвийг баяжуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой. Олон нийтэд үзүүлэх үйлчилгээ нь бүх хэлээр нэгэн адил чанарын өндөр түвшинд бэлтгэгдэж, ингэхдээ сэтгүүл зүйн өндөр түвшний шударга, нэгдмэл, тэнцвэртэй, Засгийн Газар, бизнес болон бусад ашиг сонирхлоос ангид нэвтрүүлэг, мэдээлэл хүргэхийг зорино. Үүний дээр, олон нийтийн нэвтрүүлгийн хүрээнд сургалт танин мэдэхүй болоод үндэсний ба цөөнх угсаатан, спортын хөтөлбөр, мөн хүүхдүүд, эмэгтэйчүүд, залуус болон тахир дутуу хүмүүст зориулж тусгайлан бэлтгэсэн нэвтрүүлгийг түлхүү оруулж байх учиртай. Эцэст нь, олон нийтийн нэвтрүүлгийн сүлжээндээ тус байгууллагын бэлтгэсэн нэвтрүүлгүүдээс гадна бие даасан бусад хэвлэл мэдээллийн байгууллагаас худалдан авсан нэвтрүүлгийг нийтийн хүртээл болгож байх үүрэгтэй.

III. Удирдлагын зохион байгуулалт

A. Дотоод удирдлага

Дээр дурьдсанчлан 1999 оны ӨАТРК нь хязгаарлагдмал хариуцлагатай корпорац бөгөөд үйл ажиллагааг нь байгууллагын онцлогт тохируулан Аж Ахуйн Нэгжийн хуулиар зохицуулна. Корпорацийг Зөвлөл болон Гүйцэтгэх Хороо удирдана. Гүйцэтгэх Хорооны гишүүд Зөвлөлийн зарим гишүүдээс бүрдэх бөгөөд энэхүү хоёр нэгж хоёулаа дээрх хуульд заасан зорилт, дүрэм журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна. 6(2)-р бүлэг нь ӨАТРК-ийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүл зүй, уран бүтээл, нэвтрүүлгийн бодлогын хараат бус байдлыг албан ёсоор хангаж өгсөн бөгөөд Зөвлөл тэрхүү эрх чөлөө, бие даасан байдлыг нь хамгаалах зорилготойг мөн заажээ.

12-р бүлэгт заасанчлан, Зөвлөл орон тооны бус 12 гишүүнтэй байхаас гадна Бүлгийн Гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны дарга, Санхүүгийн даргатай байна. Зөвлөлийн орон тооны бус 12 гишүүдэд нэр дэвшигчдийн жагсаалтыг хэвлэлд нийтэлснээс хойш Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейтэй зөвшилцсөний үндсэн дээр нээлттэй, ил тод байдлаар шалгаруулан тэдгээрийг томилно. 14-р бүлэгт заасны дагуу Зөвлөл нь Гүйцэтгэх Хороог томилох бөгөөд, Хорооны бүрэлдэхүүнд Гүйцэтгэх захирлаас гадна Зөвлөлийн 6 гишүүн багтана. Хороо нь Зөвлөлд ажлаа тайлагнах бөгөөд Зөвлөлөөс тодорхойлж өгсөн ажил үүргийг гүйцэтгэнэ.

Нийтэд нь аваад үзвэл, 13-р бүлэгт заасны дагуу Зөвлөлийн гишүүд нь зохих мэргэжил, мэргэшил эзэмшсэн, телевиз радиогийн салбарт ажилласан туршлагатай байхын дээр шударга ёс, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ӨАТРК-ийн зорилгыг дээдлэн сахих хариуцлагатай хүмүүс байх бөгөөд хүн амын өргөн хүрээ давхаргыг төлөөлж байх ёстой. Хүн тус бүрт авч үзвэл, Зөвлөлийн гишүүн нь Өмнөд Африкийн иргэн эсвэл байнгын оршин суугч байх ба, шүүхээр сэтгэл мэдрэлийн эмгэггүйг нь баталгаажуулсан байх ёстой. Мөн хуулийн ямарваа гэмт үйлдэл, залилан болон өөр бусад ноцтой гэмт хэрэг үйлдэж байгаагүй хүн байх шаардлагатай гэж 16-р бүлэгт заажээ. 15-р бүлэгт зааснаар томилогч нэгж нь Зөвлөлийн гишүүнийг зохисгүй үйлдэл хийсэн, эсвэл үүрэг хариуцлагаа биелүүлэх чадаргүй гэж үзвэл урьдчилсан шалгалт хийж үүнийг нотлон Зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр үрэгт ажлаас нь чөлөөлөх эрхтэй юм. Тус хууль сонирхлын зөрчилийн тухай асуудлыг хатуу зохицуулдаг бөгөөд 17-р бүлэгт аливаа сонирхлын зөрчил гарсан тохиолдолд үүнд холбогдох гишүүн нь уг хэлэлцүүлгийг орхин гарч, бусад гишүүд энэ асуудлаар шийдвэр гаргана гэж заасан байдаг.

1999 оны хууль Зөвлөл нь ӨАТРК-ийн үйл ажиллагааг хянах бөгөөд Гүйцэтгэх Хороо Зөвлөлд ажлаа тайлагнана гэж заасан байна. Үүнээс үзэхэд, Зөвлөл болон түүний удирдлага доорхи Гүйцэтгэх Хороо нь ӨАТРК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь удирдан хянаж байгаа нь тодорхой. Гэтэл энэ байдал нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон сэтгүүл зүй, уран бүтээл, нэвтрүүлгийн сүлжээний бие даасан байдлыг хангах, мөн Зөвлөл энэ эрх чөлөө, бие даасан байдлыг хамгаална гэсэн зарчимтай хэрхэн уялдаж байгаа нь тодорхой бус байгаа юм. Тэгэхлээр, ӨАТРК нь Зөвлөлийг түүний өдөр тутмын ажилд ялангуяа нэвтрүүлгийн сүлжээ, мэдээний сонголтонд хөндлөнгөөс оролцохоос урьдчилан сэргийлж ӨАТРК-ийн зорилго, чиглэл, гол бодлого төлөвлөлтийг Зөвлөлөөр тодорхойлуулан ажиллах нь зүйтэй болов уу.

Б. Зохицуулах механизм

ӨАТРК-ийн үйл ажиллагаа нь Парламентаас гаргасан шийдвэрээр зохицуулагдах нь тодорхой бөгөөд Парламент хууль эрхийн холбогдох баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах, тэр ч бүү хэл хүчин төгөлдөр болгосон хуулиа хүчингүй болгох бүрэн эрхтэй. ӨАТРК-д нөлөөлж чадахуйц бусад бие хүн, хуулийн этгээдийн тоонд уг 1999 оны Актыг хариуцах сайд, өөрөөр хэлбэл Харилцаа Холбооны сайд, болон ТРХБЗ зүй ёсоор орно. Холбогдох бусад байгууллагын тоонд 1999 оны хуулиар байгуулагдсан Давтамж Зохицуулалтын Алба болон Өмнөд Африкийн Телевиз Радиогийн Зөвлөл Захиргаа орох юм.

1999 оны хуулийн 3(2) бүлэгт заасны дагуу Сайд нь телевиз радиогийн бодлого хөгжүүлэх чиглэлийг тодорхойлхоос гадна, ӨАТР-тай холбогдох хэд хэдэн үүргийг хүлээдэг. Сайд арилжааны тус корпорацийн салбараас олон нийтийн үйлчилгээний салбарт олгох татаасын хэмжээг Зөвлөлөөс санал болгосны үндсэн батлах эрхтэйн зэрэгцээ Сангийн сайдтай зөвлөлдөн ӨАТРК-ийн санхүүгийн аливаа зохицуулалт, журам болон нэмэлт хөрөнгө оруулалтыг батлах эрхтэй. Харилцаа холбооны сайд Сангийн сайдтай зөвшилцсөний ӨАТРК-ийн нийт үнэлгээ болон хувьцааны тоо ширхэгийг тодорхойлхоос гадна, мөн Сангийн сайдтай хамтран ӨАТРК-ийн аливаа зээлийг батлах ёстой аж. Харилцаа Холбооны Сайд ӨАТРК-ийн жилийн тайлан, санхүүгийн дүгнэлтийг хэрхэн гаргах талаар мөн зааварчилгаа өгөх эрхтэй.

ТРХБЗ нь ӨАТРК-ийн хувьд багагүй нөлөөтэй байгууллага юм. 6(2) бүлэгт зааснаар ТРХБЗ нь 1999 оны хуулийн гол заалтуудыг тусгасан Дүрмийг ӨАТРК чанд сахин биелүүлж байгаа эсэхийг хянан баталгаажуулах үүрэгтэй. 1999 оны хуулийн 3 (5)(ф) бүлэгт зааснаар, телевиз радиогийн бүх байгууллагууд, тэр дундаа ӨАТРК нь ТРХБЗ-аас хэрэгжүүлдэг ТРХБЗ-ын хуулийн 1-р заалтад тусгагдсан Үйл Ажиллагааны Журмыг баримтлах үүрэгтэй. Уг Журам мэдээ, нэвтрүүлгийн ёс зүй болон үнэн бодит байдал, нэгдмэл байдал зэргийг зохицуулдаг юм. 21-р бүлэгт зааснаар ӨАТРК нь ТРХБЗ-аас тусгай зөвшөөрөл \лизенз\ авах шаардлагатай боловч ТРХБЗ нь уг зөвшөөрлийг төлбөр хийдмэгц саадгүй олгох үүрэгтэй юм.

1999 оны Хуулийн 37-р бүлгийн заалт нь Харилцаа Холбооны Департаментийн дотор Давтамж Зохицуулалтын алба (ДЗА) байгуулах хууль эрх зүйн үндэс суурь болдог. ДЗА нь радио давтамжийн спектр хэмжээтэй холбогдолтой бодлого чиглэлийг боловсруулахын зэрэгцээ давтамжуудыг бүх хэрэглэгчийн эрэлт шаардлагад нийцүүлж зохистой ашиглах явдлыг хянан баталгаажуулах үүрэгтэй. Иймээс ӨАТРК олон тооны сонсогчидтай байгууллага учраас ДЗА нь үйл ажиллагаанд нөлөөлдөг гэсэн үг. Үүний зэрэгцээ ДЗА нь үйл ажиллагаагаа явуулахдаа ӨАТРК болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажилладаг байх ёстой. 1999 оны Хуулийн 38-р бүлгийн заалтын дагуу, Харилцаа Холбооны Сайд нь орон нутгийн телевиз, радиог хэрхэн хөгжүүлэх талаар зөвлөгөө авах үүднээс Өмнөд Африкийн Нэвтрүүлгийн Зөвлөх Захиргааг байгуулах ёстой юм. Энэ нь ӨАТРК-ийн орон нутгийн авъяастнуудыг дэмжих, албан ёсны бүх хэлээр нэвтрүүлэг явуулах үүрэгтэй илт давхардаж байгаа юм.

ӨАТРК нь Сайдад жилийн санхүүгийн тайлан тооцоо, ажлын тайлангаа тавих үүрэгтэй. Тухайн жилийн ажлын тайланд уг Корпорацийн өмнөх жилийн үйл ажиллагааны тайлан болон корпорацийн эзэмшилд багтах бүх өмчийн үнэлгээ зэргийг багтаасан санхүүгийн зарим нэг тодорхой мэдээллүүд орсон байх ёстой юм. Сайд эдгээр жилийн тайлангуудыг долоо хоногийн дотор Парламентад танилцуулж хэлэлцүүлэх үүрэгтэй.

IV. Санхүүжилт

1999 оны хуулийн 8-р бүлэгт зааснаар, ӨАТРК нь зар сурталчилгаа, захиалга, ивээн тэтгэлэг, хураамж авах болон бусад арга замаар өөрийнхөө үйл ажиллагааг санхүүжүүлж болно. Хэдийгээр уг хуулинд олон нийтийн чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийн жагсаалтыг хязгаарлах эсэхийг тодорхой тусгаагүй хэдий ч, ӨАТРК нь нэвтрүүлгийн нийт сүлжээндээ үнэ төлбөргүй нэвтрүүлгийн цагийг оруулж өгнө гэж заажээ. Үүний зэрэгцээ дээрх хуулийн 11(д) бүлэгт тус байгууллагын арилжааны салбар нь олон нийтийн үйлчилдэг салбартаа татаас тэтгэмж олгохоор заажээ. Одоогоор дээрхи хоёр салбарыг тодорхой зааглаагүй байгаа тул дээрх зарчим яг хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй байна.

1999 оны хуулийн 27-р бүлэгт заасны дагуу хувьдаа телевизор, нэвтрүүлэг хүлээн авагч эзэмшигч бүр, мөн тодорхой бүлэглэлийн бизнес аж ахуйн нэгжүүд хураамж төлөхөөр заасан байгаа. Бодит байдал дээр, 1999 оны байдлаар л гэхэд энэ хураамж ӨАТРК-ийн үйл ажиллагааны нийт зардлын дөнгөж 13,5%-тай тэнцэж байсны учир шалтгаан нь хулгайгаар нэвтрүүлэг үзэх хүмүүсийн тоо их байсны дээр хураамжийн хэмжээ бага байсантай холбоотой байжээ. Нийт орлогын 10% болох 206 сая рандийг Засгийн Газрын санхүүжилтээр, харин үлдсэн 76,5%-ийг зар сурталчилгаа болон арилжааны бусад үйл ажиллагаагаар олсон байна. Ингэхлээр, ӨАТРК нь олон нийтээс маш бага хэмжээгээр санхүүжиж байна.

НЭГДСЭН ВАНТ УЛС

Танилцуулга

Британий Телевиз Радиогийн Корпораци \Би Би Си\ нь Хааны Зарлигийн дагуу 1926 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өдгөөг хүртэл энэ статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ байгууллага нь 1926 онд байгуулагдсанаасаа хойш 1954 он хүртэл телевиз радиогийн салбарт дан ганцаараа ноёрхож байлаа. 1954 оноос хойш ч гэсэн радио нэвтрүүлгийн салбарт \тус салбар нь энэ байгууллагын уламжлалт салбар, зах зээл гэж тооцогддог\ ноёрхож байсан ба харин телевизийн хувьд хараат бус байгууллагад нэвтрүүлэг явуулах эрхийг олгосон билээ. 1981 он хүртэл энэ бие даасан телевиз Би Би Си-гийн нэгэн адил "сургалт, мэдээлэл, цэнгээнт нэвтрүүлэг явуулах олон нийтийн" үүрэг гүйцэтгэж байв. 1973 оноос орон нутгийн чанартай арилжааны радио байгуулагдсан билээ.

Хааны Зарлигийг нилээд хэдэн жилийн хугацаатайгаар батлан гаргадаг ба хамгийн сүүлчийн зарлигийг 1996 оны 5 сард 10 жилийн хугацаатайгаар баталжээ. Хааны Зарлигийг ялангуяа онцгой эрх бүхий үйл ажиллагаа явуулах зорилготойгоор эрх баригчаас гаргадаг бөгөөд Хааны Зарлигаар дүрэм баталж, түүнийг хэрэгжүүлэх явдал байдаг. Би Би Си-гийн Дүрмийн төслийг Үндэсний Сангийн төрийн нарийн бичгийн дарга боловсруулдаг. Зарчмын хувьд энэхүү Дүрэм нь туслах чанарын хуульд тооцогддог учир түүнийг заавал Парламентаар хэлэлцэн батлах шаардлагагүй бөгөөд Дүрмийн дагуу байгуулагдсан албадаас гаргасан шийдвэрүүдийг хуулийн хүрээнд дахин нягтлан үзэх шаардлагагүй юм. Дүрмийг тодорхой хугацааны дараа шинэчилж өөрчлөлт оруулдаг ба тэгээд ч энэ нь туслах чанарын хууль зүйн баримт бичиг учраас Би Би Си-гийн үйл ажиллагааны баталгаа нь бусад хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг олон нийтийн телевиз радиогийн бусад байгууллагуудтай харьцуулахад тийм ч тогтвортой биш байдаг.

Үндэсний Сангийн төрийн нарийн бичгийн дарга, Би Би Си-гийн Захирагчдийн зөвлөлийн хоорондын байгуулдаг Лизензийн Гэрээнд \Гэрээ\ Би Би Си-гийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар нарийвчлан тодорхойлсон байдаг. Энэхүү Гэрээ нь Сайд болон Захирагчид хоорондын тохиролцоо бөгөөд хамгийн сүүлчийн гэрээг 1996 онд байгуулсан байна. Иймд энэхүү Гэрээг аль нэгэн тал нь зөрчиж хууль эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсон тохиолдолд Гэрээний тухай хуулиар зохицуулагдана. Одоо хүчин төгөлдөр буй Гэрээний 18-р зүйл зааснаар тус Гэрээ нь Төлөөлөгчдийн танхимын тогтоолоор батлагдсаны дараа хүчин төгөлдөр болно.

Дээр дурьдсанчлан хамгийн сүүлчийн Дүрэм ба Гэрээг 1996 онд баталсан юм. Хэдийгээр эдгээр хоёр баримт бичгийг хүчин төгөлдөр болгоход тусгай үе шаттай процедур шаардлагагүй боловч дээрхи хоёр баримтыг батлахад Засгийн газрын оролцоо их байв. Тухайлбал, Засгийн газар нь Төлөөлөгчдийн танхим, Үндэсний Сангийн сонгон шалгаруулах хороо, Засгийн газрын хэлэлцүүлэг зохион байгуулж

дүгнэлт гарган 1996 оны Дүрэм болон Гэрээг баталсан билээ. Засгийн газар Би Би Си-гийн хариуцлагыг өндөржүүлэх үүднээс энэхүү баримт бичгүүдэд хэд хэдэн өөрчлөлт оруулсан юм. Тухайлбал, нэвтрүүлгийн стандартад тавих шаардлагуудыг Гэрээнд шууд тусгаж, мөн Би Би Си-гийн жилийн тайланг маш тодорхой гаргаж байхыг шаардсан зүйлийг тусгасан байна. Үүний зэрэгцээ Захирагч, Үндэсний зөвлөлүүд болон Гадаад ба Хамтын Нөхөрлөлийн Хэргийн Яамны үүргийг тодруулах гэх мэт удирдлагын зарим асуудлаар өөрчлөлт оруулсан юм.

I. Үйл ажиллагаа

Гэрээний дагуу Би Би Си газраар дамжуулах телевизийн хоёр суваг, радиогийн таван станцаар дамжуулан Их Британи даяар нэвтрүүлэг цацаж өргөн хүрээний телевиз радиогийн үйлчилгээ үзүүлэхээс гадна Шотланд, Умард Ирландад тус тусд нь зориулсан нэг, Уэйлст зориулсан хоёр нэмэлт радио, орон нутгийн хэд хэдэн радио станцуудыг ажиллуулдаг. Дээрхи үйлчилгээг Дотоод нэвтрүүлэг гэж нэрлэдэг. Мөн Би Би Си гадаад орнууд дахь сонсогчдод зориулан нэвтрүүлгүүдийг хэд хэдэн хэлээр телевиз радиогоор дамжуулан хүргэдэг бөгөөд түүнийг Гадаад нэвтрүүлэг гэж нэрлэдэг. Эдгээр бүх нэвтрүүлгийг Би Би Си гэсэн нэгдмэл нэрийн дор явуулдаг.

II. Олон нийтэд үйлчлэх үүрэг

Би Би Си-гийн олон нийтэд үйлчлэх үүргийг Дүрэм болон Гэрээний хэд хэдэн заалтаар тодорхойлсон байдаг. Дүрмийн 3-р зүйл нь Би Би Си олон нийтэд үйлчилдэг байгууллагын хувьд мэдээлэл, боловсрол танин мэдэхүй, цэнгээнт нэвтрүүлгийг радио, телевизээр дамжуулан явуулах үүрэгтэй гэж заасан юм. Би Би Си-гийн үйл ажиллагааг уулзалт, семинар гэх мэт аргаар дамжуулан олон нийтийн зүгээс тогтмол хянадаг. Нэвтрүүлэгт аливаа нэгэн бодит өөрчлөлт оруулахаас өмнө олон нийтээр урьдчилан хэлэлцүүлсэн байх шаардлагатай.

Нэвтрүүлэг, түүний агуулгын талаархи нарийвчилсан заалтыг Гэрээнд тусгасан байдаг. Гэрээний 3-р зүйлд заасны дагуу Дотоод Нэвтрүүлэг нь чанарын өндөр шаардлагыг хангасан байх бөгөөд энэ нь ялангуяа нэвтрүүлгийн агуулга, чанар, үнэ зөв байдал зэрэгт хамаарах ба өргөн хүрээний сэдвээр бэлтгэгдэнэ. 5-р зүйл эдгээр стандартыг тодорхой тусгаж, тухайлбал Би Би Си Дотоод Нэвтрүүлгийн тэнцвэрийг хангаж, сонсогчдын төрөл бүрийн сонирхол, шаардлагад нийцүүлэн, улмаар үзэгчдийн сэтгэл хөдлөлийн байдлыг буруугаар ашиглаж байгаа эсэх, шашны төрөл бүрийн үзэл бодлыг шамшигдуулж байгаа эсэх, ёс зүйн шалгуурт нийцэж байгаа эсэх, олон нийтийн сэтгэл санаанд буруугаар нөлөөлж байгаа эсэх, гэмт хэрэг, нийгмийн амгалан тайван байдлыг алдагдуулхад хүргэсэн зүйл нэвтрүүлэгт орж байгаа эсэх тал дээр хяналттай ажиллах ёстой. Үүний зэрэгцээгээр, маргаантай асуудлуудад нягт нарийн хандаж аль нэг талын байр суурийг баримтлахаас татгалзаж хандахаас гадна цаг үеийн шуурхай мэдээ эсвэл олон нийтийн бодлогын чанартай асуудлуудаар Би Би Си-гийн байр суурийг зарим нэгэн онцгой тохиолдлоос бусад тохиолдолд илэрхийлж болохгүй гэж заасан байдаг. Би Би Си эдгээр зарчим, ялангуяа шударга ёс, аливаа асуудлыг тал бүрээс нь авч үзэх тухай зарчмыг ханган үйл ажиллагаагаа явуулж нэвтрүүлгээ хэрхэн бэлтгэх талаар өөрийн дотоод журам гаргах ёстой.

Мөн Би Би Си нь Телевиз Радиогийн Стандартын Коммис (TRC) өмнө эрх зүйн хувьд хариуцлага хүлээдэг. TRC хууль бус шударга бус явдал, хувийн эрх чөлөөнд халдах, ёс зүй гоо зүйн стандарт, хүчирхийлэл, садар самууныг нэвтрүүлгээр сурталчлахгүй байх зэрэг асуудлаар журам гаргах

үүрэгтэй байгууллага юм. Тус байгууллага нэвтрүүлэгт хяналт тавьж зөрчил гарсан тохиолдолд олон нийтэд энэ талаар мэдээлэх эрхтэй. Зөрчил гарсан тохиолдолд ТРСК энэ асуудлаар гаргасан шийдвэрээ Би Би Си-д мэдэгдэж хэрэгжүүлүүлэх эрхтэй. Жишээлвэл, 1996 онд ТРСК-ийн өмнөх байгууллага болон Нэвтрүүлгийн Талаар Санал Гомдол Хүлээн Авах Хороо ба ТР Стандартын Зөвлөлөөс Би Би Си-гийн талаар нийт 685 санал гомдол ирснийг мэдэгдсэн. Дурьдсан хугацаанд 78 санал гомдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь шийдвэрлэсэн байна.

Дотоод Нэвтрүүлгийн албанд хамааралтай хэд хэдэн тусгай заалтууд байдаг. Тухайлбал, урлаг болон олон талт соёлын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, өргөн хүрээтэй баталгаатай олон талт мэдээ болон шуурхай мэлээлэл, спортын болон бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа, боловсрол сургалт танин мэдэхүйн, хүүхдийн гэсэн чанарын өндөр түвшинд бэлтгэгдсэн нэвтрүүлэг цацахдаа сонсогч үзэгчдийн амьдрал ахуй болон тэдгээрийн санаа сэтгэлийг түгшээж байгаа асуудлыг нэвтрүүлэгтээ тусгах нь Дотоод Нэвтрүүлгийн үүрэг мөн. Түүнчлэн Умард Ирланд, Шотланд, Уэйлсийн болон Лондонгийн гаднах Англи дүүргүүд ба Өрнөд, Дорнодын сонсогч үзэгчдэд зориулсан орон нутгийн чанартай нэвтрүүлгийг тодорхой хэмжээгээр нэвтрүүлгийн сүлжээндээ оруулах үүрэгтэй гэсэн байдаг. Үүнээс нэмэхэд, Би Би Си Парламентын хоёр танхимын хуралдаанаас өдөр бүр нэг талыг баримталсан бус шуурхай сурвалжлага нэвтрүүлэх үүрэгтэй.

Гадаад Нэвтрүүлэг агуулга чанарын хувьд өндөр түвшний, үнэн зөв байдлыг тусгасан нэвтрүүлэг цацах Би Би Си-гийн ерөнхий зарчмыг баримтлан үйл ажиллагаа явуулна гэж Гэрээнд заасан юм. 9.4-р зүйлд Би Би Си нь Гадаад болон Хамтын Нөхөрлөлийн Хэргийн яамтай тохиролцсоны дагуу үнэн зөв, баттай хараат бус мэдээ цацаж, “эдгээр үйл явдлын талаар Британийн тэнцвэрт байр суурийг илэрхийлж, Британийн ард түмний амьдрал, тогтолцоо, байгууллага, амжилтыг үр өгөөжтэй үнэ зөвөөр” мэдээлнэ гэж тусгасан байдаг.

Би Би Си нэвтрүүлгийн архив байгуулж түүнийг хөгжүүлэн төлбөртэй ба төлбөргүй үйлчилгээг олон нийтэд үзүүлэх ёстой. Эцэст нь Гэрээний 12 зүйлд зааснаар тус Корпораци өөрийн ерөнхий зорилгод нийцүүлэн судалгаа хөгжлийн хөтөлбөр боловсруулхад чиглүүлсэн үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээдэг.

III. Удирдлагын зохион байгуулалт

Дүрэмд заасны дагуу Би Би Си нь Захирагчдын зөвлөлөөр удирдуулсан нэгдсэн байгууллага мөн. Би Би Си-гийн бие даасан хараат бус байдлыг Дүрмийн Оршилд тодорхойлсон байдаг бөгөөд Гэрээний 2.1-р зүйлд дараахи байдлаар баталгаажуулсан юм. Үүнд:

Корпораци нь нэвтрүүлгийн агуулга, нэвтрүүлэг дамжуулах цаг болон дотоод хэргийн удирдлагатай холбоотой бүх асуудлаар бие даан үйл ажиллагаагаа явуулна.

Үндэсний гурав ба хэд хэдэн тооны Англи Орон Нутгийн зөвлөлүүд өөрийн орон нутгийн хэмжээнд Корпорацийн үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлж зөвлөгөө өгдөг. Үүний зэрэгцээ Төрийн нарийн бичгийн дарга, Гадаад Нэвтрүүлгийн хувьд Гадаад болон Хамтын Нөхөрлөлийн Хэргийн Яам тус байгууллагын үйл ажиллагааны талаар онцгой эрх мэдэлтэй юм. Тодорхой мэдээлэл, түүний дотор Парламентаар хэлэлцүүлэх Жилийн тайланд орох мэдээллийг хэвлүүлэх Би Би Си-гийн үүрэг нь энэхүү байгууллагын удирдлагын тогтолцооны нэгэн хэсэг юм.

Удирдлагын тогтолцоо нь үнэн хэрэгтээ Би Би Си-гийн бие даасан хараат бус байдлыг хүндэтгэх асуудалтай нийцдэггүй зөвхөн ёс төдий баталгаа болдог нь үнэн. Засгийн газарт тус байгууллагыг хянах хэтэрхий их эрх мэдэл төвлөрсөн нь Захирагч нарыг шууд болон шууд бусаар томилдогоор илэрч байгаа юм. Засгийн газар Би Би Си-гийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс бүдүүлгээр оролцсон ил тод баримт байхгүй хэдий ч тодорхой хэмжээний дарамт үзүүлдэг нь илэрхий бөгөөд энэ асуудал маргаан үүсгэж ирсэн билээ. Гэвч 1994 онд Засгийн газрын тайланг хэлэлцэх үед Засгийн газрын хяналтыг багасгах үүднээс хараат бус телевиз радиогийн зөвлөл байгуулан түүнд одоогийн Засгийн газрын хэрэгжүүлж байгаа эрх үүргийг шилжүүлж эсвэл Би Би Си-г хараат бус телевиз радиогийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль эрх зүйн хүрээнд шилжүүлэх тухай асуудал олны дэмжлэг аваагүй билээ.

А. Дотоод удирдлага

Захирагчдын зөвлөл байгуулах тухай асуудлыг Би Би Си-гийн Дүрэмд заасан байдаг. Тус Дүрмийн 7-р зүйлд зааснаар Зөвлөл нь байгууллагын тодорхой зорилтыг батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, шударга ёс зүй, эд хөрөнгө захиран зарцуулах талаар стандартын өндөр шаардлага тавьж тэдгээрийн хэрхэн хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих бөгөөд Дотоод, Гадаад Нэвтрүүлэг болон Арилжааны үйл ажиллагааны стратегийг боловсруулах гэсэн үндсэн үүргийг хүлээдэг. Дотоод Нэвтрүүлгийн хувьд энэхүү стратегийг боловсруулахдаа Корпорацийн үндсэн болон бусад үйл ажиллагаа, нэвтрүүлэг нь олон нийтийн эрх ашиг, сонирхлыг тусгасан байна. Захирагчид төрөл бүрийн Зөвлөлүүдтэй зохих ёсоор хамтран ажиллаж, сонсогчдын санал бодлыг үйл ажиллагаандаа тусгах, эрх зүй болон гэрээний дагуу хүлээсэн хариуцлагын биелэлтэд хяналт тавих болон Ерөнхий захирал, дээд удирдлагын бусад гишүүдийг томилох зэрэг үүрэгтэй. Хэдийгээр Захирагчид болон Би Би Си-гийн ажилтнуудын хоорондын зохих харилцааг Дүрэм ба Гэрээ аль нэгэнд нарийн тусгаагүй ч тэдгээрийн үүрэг хариуцлага сүүлийн жилүүдэд илүү тодорхой болсон юм. Дээрхи баримт бичгүүдэд Ерөнхий захирлын албан тушаалын томилолтын хугацааг заагаагүй бөгөөд үүний улмаас Ерөнхий захирал асан Аласдаир Милнэг 1987 онд гэнэт албан тушаалаас нь халсан тохиолдол гарсан. Хэдийгээр Захирагчид тус байгууллагын нэвтрүүлэгт хяналт тавих эрхийг эрх зүйн зохицуулалтын дагуу эдэлдэг ч үнэн хэрэгтээ тэд энэ эрхээ зөвхөн онцгой тохиолдолд л хэрэгжүүлдэг.

Захирагчдыг Хааны онцгой эрх мэдлийн хүрээнд (үнэн хэрэгтээ Ерөнхий Сайдын томилолтоор) таван жил хүртэлх хугацаагаар томилдог ба тэд нөхөн томилогдох эрхтэй байдаг. Дор дурьдсанчлан Үндэсний захирагчдыг томилохоос бусад тохиолдолд энэхүү эрх мэдэлд аливаа албан ёсны нөхцөл байдаггүй. Захирагчдын зөвлөлийн дарга ба орлогч даргыг томилох эрх мөн л Хааны онцгой эрх мэдэлд хамаардаг. Захирагч нь тэдгээрийн үүрэгт харшлах сонирхлын зөрчилтэй болсон, дампуурсан, сэтгэцийн өвчтэй болсон буюу Корпорацийн зөвшөөрөлгүйгээр 3-аас дээш сарын хугацаагаар хуралд оролцоогүй эсвэл өөрийн хүсэлтээр огцорсон тохиолдолд түүнийг Хааны онцгой эрх мэдлийн хүрээнд үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

“Тухайн орон нутагт болж буй үйл явдал, хүмүүс, тэдгээрийн зан чанар, соёлын талаарх мэдлэгээ, тус орон нутгийн хүн амын үзэл бодолтой хэрхэн холбоо харилцаатай байдаг эсэхээрээ” шалгарсан нэг хүнийг Умард Ирланд, Шотланд, Уэйлсийн Үндэсний захирагчаар тодорхойлдог. Зөвлөлийн хурлыг дээрхи орон нутаг тус бүр болон Англид хуралдуулдаг. Төрийн нарийн бичгийн дарга хурал хүчин төгөлдөрт тооцох ирцийг тодорхойлдог бөгөөд шийдвэрийг энгийн олонхийн саналаар баталдаг.

Дүрмийн 14 ба 15-р зүйл зааснаар ажилтнуудыг томилох, шагнал урамшууллын хэмжээг тогтоох, ажиллах нөхцөлийг тодорхойлох эрхийг ажилтнуудын эрх ашгийг хөндсөн асуудлаар тэдгээрийн санал бодлыг тусгах ерөнхий зарчмыг баримталсаны үндсэн дээр Корпораци өөрөө эдэлдэг.

Би Би Си-гийн радио нэвтрүүлгийн дийлэнхи хувь, телевизийн нэвтрүүлгийн 75 орчим хувийг Их Британийн сонсогч, үзэгчдэд зориулсан үндсэн \өөрийн бэлгэсэн\ нэвтрүүлэг эзэлдэг. 1990 онд баталсан Телевиз Радиогийн Акт нь Би Би Си телевизийн нэвтрүүлгийнхээ сүлжээний 25 хүртэлх хувийг бие даасан студээс бүрдүүлхээр заасан байдаг ба 1997 оны байдлаар энэ үзүүлэлт 4 орчим хувиар давсан байна.

Б. Зохицуулах механизм

Дээр дурдсан Дүрэмд Би Би Си нь олон нийтийн хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаа явуулж, олон нийтийн өмнө тайлагнах зарчмыг баталгаажуулах хэд хэдэн механизмыг тодорхойлж өгсөн байдаг. Энэ нь дараах үндсэн 3 хэсэгт багтана. Үүнд: Хяналтын Зөвлөлүүдийн үүрэг, Төрийн нарийн бичгийн дарга болон засгийн газрын бусад сайд нарын эрх мэдэл, Би Би Си-гийн үзэгч олон болон Парламентын мэдээллээр хангах үүрэг.

Дүрмийн 12-р зүйлийн дагуу Өмнөд Ирланд, Шотланд, Уэйлс тус бүрт нэг, нийтдээ 3 Үндэсний Телевиз Радиогийн Зөвлөлтэй байхаар заасан бол, 13-р зүйл Англи дахь бүс нутгийн телевизийн нэвтрүүлгийг хариуцах Бүс нутгийн зөвлөлтэй байхаар заажээ. Би Би Си эдгээр Зөвлөлүүдийн зардлыг даадаг. Эл Зөвлөлүүд нийт Би Би Си-гийн үйл ажиллагааг захирах албан ёсны эрх мэдэл байхгүй бөгөөд гол нь Би Би Си-д орон нутгийн шинж чанартай асуудлаар зөвлөлгөө өгөх үүрэгтэй.

Үндэсний Зөвлөлийн дарга нар харьяа нутгийн Үндэсний Захирагч \Захирагчдын зөвлөлийн гишүүн\ байх ба тэд Зөвлөлийн үлдсэн гишүүдийг төлөөллийн байгууллагуудтай зөвшилцөн томилдог. Эдгээр Зөвлөлүүд үйл ажиллагаа болон боловсон хүчнийг ажилд авах зэрэг дотоод асуудлаа өөрсдөө зохицуулдаг. Ноцтой нөхцөл үүссэн буюу олон нийтийн ашиг сонирхол хөндөгдөж буй тохиолдолд Төрийн нарийн бичгийн дарга албан бичгээр Үндэсний нэг буюу түүнээс дээш зөвлөлийн үйл ажиллагааг зогсоож болно. Үндэсний зөвлөлүүд тухай орон нутгийн онцлогийг харгалзан дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд: олон нийтийн санал бодолд мониторинг хийх, уг санал бодлыг нэвтрүүлгийн сүлжээнд тусгаж байгаа эсэхийг баталгаажуулах, үндэсний хэрэглэгчдийн сонирхлыг тусгах талаар Би Би Си-д зөвлөгөө өгөх, үндэсний нийт сонсогч үзэгчдэд зориулсан нэвтрүүлгүүдийн зорилго чиглэлийг тодорхойлоход нь Би-Би-Сид тус дөхөм болох, бүс нутгийн нэвтрүүлэг бэлтгэдэг байгууллагуудын талаар тус байгууллагад зөвлөгөө өгөх зэрэг багтана. Үндэсний зөвлөл бүр Би Би Си-д жил бүр тайлан гаргаж өгөхөөс гадна Би Би Си шаардсан тохиолдолд нарийвчилсан тайланг тусгайлан гаргаж өгөх үүрэгтэй.

Бүс нутгийн зөвлөлийн дарга нарыг Би Би Си томилох бөгөөд гишүүдийг олон нийтийн өргөн хүрээний төлөөлөлийг харгалзан Корпораци томилно. Бүс нутгийн зөвлөлүүд орон нутагтаа хүлээн авч буй нэвтрүүлгүүдийн зорилгын талаар зөвлөлгөө өгөх, тус зорилго хэрхэн хэрэгжиж буйг хянах, бүс нутгийн хүмүүсийн ашиг сонирхолтой холбоотой бусад асуудлаар Би Би Си-д зөвлөх эрхтэй.

Дүрэм болон Гэрээний дагуу засгийн газрын сайд нар, ялангуяа Төрийн нарийн бичгийн дарга, Би Би Си-гийн зарим үйл ажиллагааг зохицуулах эсвэл тодорхой арга хэмжээ авахыг шаардах эрхтэй байдаг. Дүрмийн 5-р заалтын дагуу Би Би Си Худалдаа аж үйлдвэрийн төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр эсвэл Гадаад болон Хамтын Нөхөрлөлийн Хэргийн төрийн нарийн бичгийн даргатай байгуулсан гэрээний дагуу нэвтрүүлгээ цацах ёстой.

20(2)-р зүйлийн заалт ёсоор Төрийн нарийн бичгийн дарга Би Би Си-гээс Дүрмийн заалтуудыг ханган биелүүлсэн байхыг шаардах бөгөөд эс тэгвээс уг Дүрмийг хүчингүй болгох эрхтэй. 15-р заалтын

дагуу Төрийн нарийн бичгийн дарга Би Би Си-г нэвтрүүлгээ үр дүнтэй цацах үүргээ сахин биелүүлээгүй, заалтыг зөрчиж тодорхой хугацаанд энэ алдаа дутагдлаа засах арга хэмжээ аваагүй гэж үзвэл гэрээг цуцалж болно.

Төрийн нарийн бичгийн дарга нэвтрүүлэг явуулах хугацааны дээд болон доод хэмжээг тогтооходтой холбогдсон зааварчлагаа өгөх, Би Би Си-гээс нэмэлт станц байгуулахыг шаардах, аливаа нэг хууль бус мэдээллийг нэвтрүүлэхгүй байхыг шаардах эрх эдэлнэ. Энэхүү хамгийн сүүлийн заалтыг телевиз радиогийн бүх байгууллага, тэр дундаа Би Би Си-г албан ёсоор хориглосон Шин Фейн байгууллагатай холбогдсон дүрс болон үг хэллэгийг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1988 онд хэрэгжүүлсэн билээ. Энэхүү хоригыг Хүний Эрхийн Европын Комисст давж заалдсан нь амжилтгүй болсон юм. Гэрээний 8.3-р зүйлийн дагуу Төрийн нарийн бичгийн дарга олон нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн онцгой нөхцөл үүссэн гэж үзвэл Эрхэм Дээдсийн нэрийн өмнөөс Би Би Си-гийн станцуудыг удирдах эрхтэй гэдэг нь дээр дурдсан заалтаас ч илүү хатуу заалт юм.

Аливаа нэг асуудлаар онцгой нөхцөл үүссэн гэж үзвэл аливаа сайд нь үүнтэй холбоотой зар мэдээг нэвтрүүлэх эсвэл аливаа өөрийн даалгаврыг биелүүлхийг Би Би Си-гээс шаардаж болно. Ийм тохиолдлуудад дээрхтэй холбогдсон бүх зардлыг Би Би Си гаргана. Гэрээний 9-р зүйл ёсоор Гадаад болон Хамтын Нөхөрлөлийн хэргийн яам Би Би Си-гийн Гадаад Нэвтрүүлэгт нилээд хэмжээний нөлөөтэй байдаг. Би Би Си нь Гадаад болон Хамтын Нөхөрлөлийн Хэргийн Яамтай тодорхой хугацаанд зөвшилцэн тогтсон үндсэн зорилго чиглэлд нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй. Мөн яамтай зөвшилцсөний дагуу нэвтрүүлгийн дамжуулалтын хяналт эсвэл бичлэг гэх мэт нэмэлт материалыг уг яаманд өгөх үүргийг Би Би Си хүлээнэ. Би Би Си урт хугацааны ерөнхий зорилтыг тус яамтай зөвшилцөн баталж олон түмний хүртээлд нийтлэх үүрэгтэй. Эцэст нь “үндэсний ашиг сонирхолд” нийцсэн олон улсын үйл явдал, засгийн газрын бодлогын талаар нэвтрүүлэг бэлтгэхдээ Би Би Си дээрх яамтай зөвлөлдөж хамтран ажиллах үүргийг давхар хүлээнэ.

Би Би Си-гээс хэвлэн гаргадаг гол тайлан бол Жилийн тайлан бөгөөд үүнд аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан мөн санхүү, захиргаа, нэвтрүүлгийн стандарт, энэ стандартад нийцүүлэхээр авсан арга хэмжээ, хэрэгжүүлсэн судалгаа зөвлөгөөн, сонсогч үзэгчдээс ирсэн санал гомдол болон нэвтрүүлгийн сүлжээний дүн шинжилгээг багтаасан байх учиртай. Урьд өмнө мөрдөж буй Дүрэм болон Гэрээтэй харьцуулахад одоо мөрдөж буй Дүрэм, Гэрээнд ийнхүү үүргийг илүү нарийвчилж тодорхойлсон байгаа. Жилийн ерөнхий тайлан болон Үндэсний зөвлөлүүдийн гаргасан тайланг Төрийн нарийн бичгийн даргад өргөн барих бөгөөд тэрээр энэхүү баримт бичгүүдийг Парламентад өргөн барьж танилцуулна. Мөн Би Би Си үйлчилгээ, үйл ажиллагаа, стандарт, зорилго чиглэлээ тусгасан тайланг үзэгч сонсогчдынхоо өмнө авсан Амлалт гэсэн хэлбэрээр бүх хураамж төлөөлөгчдөдөө хүргэх үүрэгтэй.

IV. Санхүүжилт

Дотоод Нэвтрүүлэг ба түүний дэлхий дэхь арилжааны үйл ажиллагааг багтаасан Дотоод Нэвтрүүлгийн Групп болон Гадаад Нэвтрүүлгийн санхүүжилт тус тусдаа байдаг. Дотоод болон Гадаад Нэвтрүүлгийн хоёулангийнх нь санхүүжилтийн гол эх үүсвэр олон нийтээс авдаг хураамж байдаг. Дүрмийн 16-р зүйлд заасны дагуу Дотоод Нэвтрүүлэг дангаараа хураамжын орлогыг авах эрхтэй байдаг ба 1999 оны байдлаар энэ сан нь 2,2 тэрбум фунт буюу Дотоод Нэвтрүүлгийн Группын нийт төсвийн 82 хувьтай тэнцэж байжээ. Үүн дээр нэмээд 17 хувь нь арилжааны үйл ажиллагаанаас олсон орлого, харин орлогын 1хувь нь бусад эх сурвалжаас орж ирсэн байв. Гэрээний 10.1(б) зүйлийн дагуу Төрийн нарийн бичгийн

даргаас урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд хураамжын орлогыг бусад эх сурвалжаас олсон санхүүжилттэй холилдуулхыг хоригложээ. Ингэснээр Би Би Си-г нэвтрүүлгийн үеэр зар сурталчилгаа явуулхыг хориглож байгаа юм. Гадаад Нэвтрүүлгийн 89 хувийг Парламентын сангаас гаргадаг.

Хураамжын орлогын 62 гаруй хувийг телевизэд зарцуулдаг. Үүнд: 35 хувийг Би Би Си-1-д, 19 хувийг Би Би Си-2-д, 8 хувийг бүс нутгийн телевизүүдэд зарцуулдаг. Үлдсэн хэсгээс 21хувь нь төрөл бүрийн радио станцуудад хуваарилагддаг ба үлдэгдэл 17хувийг хураамж бүрдүүлэх болон бусад зардалд зарцуулдаг.

Сүүлийн үед Би Би Си-гийн санхүүжилтийн асуудлаар нэлээд их маргаан гарч байгаа бөгөөд Засгийн газрын хамгийн сүүлийн албан ёсны тайланд уг асуудлыг тусгайлан авч хяналтанд байлгах нь зүйтэй гэж дүгнэжээ. Үг шийдвэрийн үр дүнгийн нэг жишээ бол Гэрээний 10.2 зүйл ёсоор 2002 оны 4-р сарын 1-нээс хойш Төрийн нарийн бичгийн дарга Би Би Си-гийн Дотоод Нэвтрүүлгийн санхүүжилтийн аргачлалыг дахин авч үзэж шинэчлэх эрхтэй болсон. Гэсэн хэдий ч 18-р зүйл ёсоор санхүүжилтийн аргачлалд оруулах аливаа өөрчлөлтийг эхлээд Парламентаар хэлэлцүүлэн баталсан байх ёстой. Түүнчлэн, арилжааны үйл ажиллагаа, түүнээс олсон орлогыг нэмэгдүүлэх санаа сүүлийн үед голчлох болсон юм. Жишээлбэл, энэ асуудал 1990 оны Телевиз Радиогийн Актад нэмэлт болж орсон, 1996 оноос мөрдөж буй заалтын дагуу Би Би Си нь дангаараа буюу хамтран Бие Даасан Телевизийн Комиссийн зөвшөөрөл бүхий хувийн телевиз радиогийн байгууллагуудтай хамтран бие даасан арилжааны чиглэлийн телевиз радиогийн үйл ажиллагаа явуулах боломжтой болжээ. Үүнийг Дүрмийн 3(у) зүйлд баталгаажуулсан бөгөөд энэ заалт ёсоор Төрийн нарийн бичгийн даргаас урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр Би Би Си нь Корпорацийн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс бусад компаниутай хамтран ажиллаж хамтарсан аж ахуйн нэгж байгуулах эрхтэй.

ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Телевиз, радиогийн ардчилсан бодлогыг хөгжүүлэх үндсэн зарчим нь нэвтрүүлгийн долгион ард түмний эзэмшилд байж тэдний ашиг сонирхол, тусын тулд ашиглагдахад оршино. Урьд өмнө төсөөлөшгүй асар их нөөц боломжийг технологийн дэвшил бидэнд нээж байгаа өнөө үед олон нийтийн болон хувийн телевиз, радиогийн байгууллагуудын нөөц баялаг, ур чадвар, өвөрмөц онцлогыг нэгтгэсэн телевиз, радиогийн нэгдсэн бодлого нэвтрүүлснээр олон нийтийн эрх ашгийг дээд түвшинд ханган үйлчлэх болно гэдэг нь олон түмэнд илэрхий болсон билээ. Германы Үндсэн Хуулийн Цэцийн онцолсноор хэвлэл мэдээлэл нь “төр, засгийн газар эсвэл нийгмийн аливаа бүлгийн аль альнийх нь ч эрхшээлд байж болохгүй”. Түүнтэй нэгэн адил Хүний Эрхийн Европын Шүүх нь Австрийн төр засаг тус улсын телевиз радиог монополчилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүдүүлгээр зөрчиж байгаа явдал бөгөөд хэвлэл мэдээлэл нь олон нийтийг мэдээллээр хангах зайлшгүй чухал үүргээ “зөвхөн төр засгийн зүгээс баталгаажуулж чадах олон ургальч үзэл бодолд тулгуурлах зарчим” зөрчигдсөн нөхцөлд биелүүлж чадахгүй гэдгийг цохон тэмдэглэсэн юм.

Олон нийтэд үйлчилдэг телевиз, радиогийн оршин тогтнох бодит үндэслэл

Хэдийгээр телевиз радиогийн хөгжлийн явцын эхэнд оршин тогтнож байсан энэхүү салбар дахь олон нийтийн монополь ялангуяа ардчилал хөгжсөн орнуудад их хэмжээгээр устаж үгүй болсон ч мэдээлэл ба санаа бодлын чөлөөт урсгалыг бий болгоход олон нийтэд үйлчлэх телевиз радиогийн

байгууллагуудын гүйцэтгэж чадах ба гүйцэтгэх ёстой чухал үүргийг олон нийт өнөөг хүртэл хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Технологийн дэвшил эрчимтэй хөгжиж, хувийн хэвшлийн телевиз радиогийн хүчин чадал олон нийтийн үүрд өсөж буй өргөн хүрээний хүсэл хэрэгцээ, сонирхлыг хангаж байгаа хэдийч, энэхүү үйлчилгээг олон нийтийн телевиз радио давхар гүйцэтгэх шаардлагатай зарим чухал салбарууд өнөө хүртэл хэвээр байна.

Үндсэндээ, зах зээл ба бусад хувийн хэвшлийн байгууллагууд олон нийтийн мэдээллийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа учир олон нийтэд үйлчилдэг телевиз радио үйл ажиллагаагаа давхар явуулах шаардлага үүсдэг юм. Нэг талаас, энэ үзэгдэл нь эдийн засгийн хүчин зүйлтэй хамааралтай бөгөөд зарим нэвтрүүлэг бэлтгэн явуулахад хэт өндөр өртөгтэй эсвэл сонсогч үзэгчдийн тоо цөөн учир орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй байдал үүсдэг. Нөгөө талаас, энэ нь үндэсний үзэл бодлыг төлөвшүүлэх, ардчилсан болон нийгмийн бусад үнэт зүйлийг хөхүүлэн дэмжих замаар өндөр чанарын мэдээ, мэдээллийн цөм болж бусдыг манлайлан тэргүүлдэг олон нийтийн телевиз радиогийн үүрэгтэй холбоотой байдаг.

Хувийн телевиз радиогийн нэвтрүүлгийн сүлжээг нөхөн, нэмэлт үйлчилгээ үзүүлэх олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн үйл ажиллагааг дэмжих арга Төр засагт хэд хэд байдаг. Үүнд нэвтрүүлгийнх нь сүлжээний сонгосон хэдэн салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хувийн телевиз радиод олон нийтэд үйлчлэх үүрэг ноогдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх болон комьюнити телевиз радиог дэмжих арга замууд орно. Ингэснээр мэдээ, мэдээлэл болон санаа бодлын чөлөөт урсгал олон нийтийн дунд бий болгон хөгжүүлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулах нь эргэлзээгүй. Гэвч зөвхөн олон нийтэд үйлчлэх үндэсний хэмжээний телевиз радио энэхүү үйлсийг удирдан манлайлж, үндэстнийг хөгжүүлэх үүргийг гүйцэтгэж чадах бөгөөд энэ нь олон нийтийн телевиз радио дэлхий дахинд оршин тогтнож үйл ажиллагаагаа явуулж буйн шалтгаан юм.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын ерөнхий зорилго нь олон талын үзэл бодлыг тусгасан, өргөн хүрээний, тэнцвэртэй болон чанарын өндөр түвшинд бэлтгэгдсэн телевиз радиогийн нэвтрүүлгийн сүлжээг бүх хүмүүсийн хүртээлд зориулан цацахад оршино. Энэхүү ерөнхий зорилго дотор олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хэд хэдэн онцлог үүргүүд багтсан байдаг. Үүнд: мэдээ мэдээллийн тогтмол үйлчилгээ, боловсрол танин мэдэхүйтэй холбогдох үндсэн үүрэг, үндэсний соёл урлаг болон үндэсний үзэл бодлыг хөхүүлэн дэмжих үүрэг, цэнгээнт нэвтрүүлгийн үүрэг, нийгмийн цөөнхи ба сонирхлын бусад бүлгүүдийн хэрэгцээ шаардлагыг хангах үүргүүд орно.

Магадгүй хамгийн чухал шаардлага нь олон нийтийн итгэл хүлээхүйц үнэн зөв, аль нэг талын үзэл бодлыг үл баримталсан, олон талын асуудлыг тусгасан олон нийтэд ач холбогдол бүхий мэдээ мэдээлэл, шуурхай үйл явдлыг сонсогч үзэгчиддээ хүргэх үүрэг юм. Иргэн тус бүр ба нэр хүндтэй амьдралын асуудалд ач холбогдол бүхий нийгмийн мэдээлэл болох аль нэр дэвшигчдэд саналаа өгөх улс төрийн мэдээллээс эхлэн гэр бүлээрээ нэг өдрийн зугаалгаар явах эсэх талаар хамгийн энгийн өдөр тумын шийдвэр гаргахад дөхөм болох найдвартай бодит мэдээллээр хангах нь тус байгууллагуудын бас нэг чухал үүрэг мөн. Ийм ч учраас мэдээллийн үйлчилгээ үзүүлэх үүрэг нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хувьд маш чухал үүрэг юм.

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд нь боловсрол танин мэдэхүй болон үндэсний хөгжилд зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус байгууллагуудын нэвтрүүлгийн сүлжээ телевиз радиогийн технологи ба орчин үеийн соёл урлагийн баялаг нөөцийг ашиглах замаар үндэсний үзэл бодлыг өөдрөг сэтгэл мөн шүүмжлэх байр сууринаас хоёулангийг нь хөхүүлэн дэмжих ёстой. Ингэснээр ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэх, бусдыг хүндлэх, нийт иргэдийн нэгдмэл байдлыг бий болгодог.

Ерөнхий асуудлын хүрээнд, олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд нийгэм, байгаль орчин, эдийн засаг гэх мэтчилэн өргөн хүрээний үндэсний болон олон улсын чухал асуудлын талаар мэдээлэл, мэдлэг бий болгохоос гадна үндэсний соёл урлагийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах ёстой.

Хэдийгээр мэдээллийн нэвтрүүлгийн сүлжээ чухал ач холбогдолтой боловч ихэнхи орнуудад хөгжим, драмт нэвтрүүлэг эсвэл бусад төрлийн цэнгээнт нэвтрүүлгүүд нэвтрүүлгийн сүлжээний дийлэнх хувийг эзэлдэг. Гэвч нэвтрүүлгийн дээрх төрлийг тусд нь ангилан бусдаас салган авч үзэх нь буруу юм. Учир нь цэнгээнт нэвтрүүлгүүд сурган хүмүүжил болон үндэсний соёл нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлэн, үндэсний түүх ба түүний хөгжлийн тухай ойлголтыг өргөжүүлж, үндэсний соёлыг орчныг эрчимтэй хөгжлийг хөхүүлэн дэмждэг.

Соёл нийгмийн олон төрлийн урсгалууд хөгжиж буй өнөөгийн цаг үед уугуул ба шинээр үүссэн цөөнх нийгмийн бүлгүүдийн хэрэгцээ шаардлагыг хангах, зах зээлд чиглэсэн арилжааны телевиз радио зохих ёсоор хангаж чадахгүй байгаа бусад бүлэг хэсгүүдийн ашиг сонирхолд үйлчлэхийн тулд ажиллах зайлшгүй шаардлага олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын өмнө тавигдаад байна. Дээрх хэрэгцээ шаардлагыг хангах арга зам түүний агууллагаас шалтгаалан олон нийтийн телевиз радио тус бүрийн хувьд өөр өөр байх бөгөөд цөөнх үндэстэнд зориулсан тэдгээрийн хэлээр нэвтрүүлэг цацах, орон нутгийн чанартай нэвтрүүлгийн сүлжээг хөгжүүлэх зэрэг хэлбэрээр хэрэгжиж болно.

Үйл ажиллагааны зохицуулалтад учирах саад бэрхшээл

Олон нийтийн мэдээллийн хэрэгцээг хангахдаа олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага нь нэн түрүүнд олон нийтэд үйлчлэх үүргээ голлон үйл ажиллагаагаа явуулах бөгөөд засгийн газар буюу эсвэл зах зээлийн шаардлагыг үл харгалзана. Гэвч олон нийтийн нэвтрүүлгийн үйл ажиллагаа нь ашиг олох өөрийн чадавхаас илүү хэмжээний нөөц шаарддаг, өндөр өртөгтэй байдаг. Тиймээс, олон нийтэд үйлчилдэг өндөр чанартай телевиз радио олон нийтийн санхүүжилтээс хамааралтай юм. Олон нийтээс санхүүжиж байгаагийн хувьд, мөн агаарын долгионоор дамжуулан олон нийтийн эрх ашгийг хамгаалж буй итгэмжлэгдсэн этгээдийн хувьд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага нь өөрт хуваарилагдсан санхүүжилтийн ашиглалт, үйл ажиллагааныхаа талаар хариуцлага хүлээх ёстой. Үүний зэрэгцээ, санхүүжилт ба хариуцлага тооцох механизм нь төрийн зохисгүй хяналт үүсгэж эсвэл нийтлэл, нэвтрүүлгийн хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй. Эдгээр нь зохистой, эрх чөлөөг хөхүүлэн дэмжсэн олон нийтэд үйлчлэх телевиз радиогийн бодлогын хувьд шийдвэрлэхэд зүйтэй тулгуур зөрчлүүд мөн. Хараат бус байдал, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх ба зохих санхүүжилт хүлээж авах гэсэн энэхүү гурван зүйл олон нийтийн телевиз радиог зохицуулах үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болно.

Энэ судалгаанд хамрагдсан хууль эрх зүйн тогтолцооны хүрээнд нэвтрүүлгийн ба нийтлэлийн харьцангуй өндөр түвшний хараат бус байдалтай, хэт өндөр биш ч гэсэн хангалттай хэмжээний санхүүжилттэй, олон нийтийн өмнө хүлээсэн хариуцлагыг зохих түвшинд тооцдог олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр байгууллагуудыг давуу сайн талыг нэгтгэх юм бол энэ нь олон нийтэд үйлчилдэг телевиз радио өөрийн тогтолцоо бий болгож буй ардчиллыг шинээр үүсгэн байгуулж эсвэл шилжилтийн үеийг туулж буй орнуудад туршлага, санал бодлын үр ашигтай суурь үндэс болж болох юм.

Дээр дурьдсан жишээг судлахдаа уншигч бүр нэг зүйлийг анхааралдаа авах ёстой. Энэ судлагаа нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн хууль зүйн орчинг судалхыг голлосон юм. Судалгаанд хамрагдсан ихэнх орнууд (бүгдээрээ гэж хэлэхэд хэлсдэхгүй) олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн

маш хүчтэй уламжлалтай бөгөөд энэ нь үндэсний улс төрийн тогтолцооны салшгүй хэсэг болсон билээ. Ингэснээр дээрх орнуудын засгийн газрын хувьд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөгөөс оролцоход хүндрэлтэй байдаг бөгөөд улмаар олон нийтийн өмнө хүлээсэн хариуцлагын хэрэгжүүлэлтийг хянах төрөл бүрийн механизм тогтолцоо байдаг. Жишээ нь, Нэгдсэн Вант улсын Би Би Си-ийн хараат бус байдлыг хуулиар хүчтэй баталгаажуулаагүй боловч дээрх дурьдсан зарчмууд адил үйлчилдэг бөгөөд үүний шалтгаан нь ардчилсан нийгэмд гүнзгий суурьшсан уламжлалтай холбоотой юм. Ардчилалыг шинээр үүсгэн байгуулж эсвэл шилжилтийн үеийг туулж буй орнуудын хувьд энэ уламжлал, практик бий болоогүй байна. Иймээс эдгээр орнуудад олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын хараат бус байдал, санхүүжилтийн найдвартай тогтолцоо, олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага тооцох зэрэг хамгаас чухал зарчмыг хууль эрх зүйн талаас баталгаажуулан бэхжүүлж энэ нь олон нийтийн телевиз радиог дэмжих үндэсний сэтгэлгээ бий болгоно гэдэгт найдах хэрэгтэй.

Хараат бус байдал

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллага нь хариуцлагатай ажиллах ёстой бол нөгөө талаас үйл ажиллагаагаа хараат бус байдлаар явуулах эрх чөлөөтэй байх нь зүйтэй. Эдгээр байгууллагууд засгийн газар, улс төрийн нам, засгийн газар буюу төрийн харьяа байгууллага, хувийн хүчтэй сонирхлоос хараат бус байж мэдээ мэдээлэл, цэнгээт болон бусад нэвтрүүлгийг олон нийтэд хүргэх үүргээ нэвтрүүлгийн бүрэн эрх чөлөөгөөрөө дамжуулан зохистой байдлаар хүргэнэ.

Зарим талаар хараат бус байдал гэдэг нь ардчилал ба хүний эрхийг дээдлэгч тогтолцооны салшгүй үндэс суурь болсон, үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөний гол хэсэг болох хэвлэлийн мэдээллийн эрх чөлөөний асуудалтай холбоотой юм. Европын Шүүх Танхим “үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгмийн чухал үндэс суурь бөгөөд үүнийг хэвлэл мэдээлэл дамжуулан баталгаажуулах нь онцгой ач холбогдолтой юм” гэдгийг олон удаа цохон тэмдэглэжээ. Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд энэхүү баталгаанд хамрагдах нь гарцаагүй.

Хараат бус байдал нь тус байгууллагуудын олон нийтэд үйлчлэх үүргээ хэрэгжүүлэхэд мөн чухал ач холбогдолтой болно. Олон нийтийн байгууллагын хувьд тэдгээр байгууллагууд нь сонгогдмол хэсэг бүлэг хүмүүсийн сонирхол бус харин нийт ард түмэнд үйлчилж хариуцлага хүлээнэ. 19-р ЗҮЙЛ гэдэг нэртэй хүний эрхийн төлөө төрийн бус байгууллага төрөөс санхүүжиж буй телевиз радиогийн тухай тэмдэглэхдээ “засгийн газар нь дээрх хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтийн эрх ашигт хамааралтай асуудлаар олон нийтэд мэдээлэл хүргэх ба засгийн газрын “хоточ нохой” болон ажиллах ихэр хоёр үүргийг хоёулангийг нь биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих” онцгой хариуцлага хүлээнэ” гэсэн билээ.

Хараат бус байдлыг баталгаажуулах нэгэн эерэг хандлага нь Канад, Өмнөд Африк, Нэгдсэн Вант Улс дахь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын үйл ажиллагааны хууль эрх зүйн баримт бичигт хараат бус байдал ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан зүйл ангийг холбогдох хууль тогтоомжинд оруулсан явдал юм. Дээрх зүйл анги нь тус байгууллагуудын дээд удирдлагын шийдвэр ба тусгай нэвтрүүлгийн сонголт, агуулгыг төрийн байгууллага ба тэдгээрийн төлөөлөгчдийн хөндлөнгийн оролцоо болон хяналтаас хамгаалдаг болно.

Үүнээс гадна, хэвлэл мэдээлэл ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ихэнхи үндсэн хуулинд баталгаажуулсан юм. Ингэсний үр дүнд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд хуулинд

баталгаажуулсан хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үр ашгийг бүрэн ашиглаж, энэ эрх чөлөөг боогдуулж заналхийлсэн Төр засгийн аливаа үйл ажиллагааны эсрэг хуулийн хүрээнд арга хэмжээ авах бүрэн эрхтэй болсон билээ. Канадын Телевиз Радиогийн Корпораци нь Үндсэн хуулиар баталгаажуулсан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах тэргүүлэгч байгууллага бөгөөд жишээ нь нэвтрүүлгийн хориг, гэмт хэрэг болон Парламентийн үйл ажиллагааг сурвалжлахыг хязгаарлахын эсрэг байнга тэмцдэг. Өөрийг нь санхүүжүүлэгч ба эзэмшигч Төр засгийн эсрэг олон нийтийн телевиз радиогийн байгууллагын энэхүү тэмцэл нь тус байгууллагын олон нийтийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлж байгаагийн илрэл мөн.

Хэдийгээр албан ёсны болон үндсэн хуулийн хүрээн дэхь баталгаа чухал боловч практик дээр олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын хараат бус байдлыг дэмжин баталгаажуулах гол тогтолцоо нь Захирлуудын буюу Захирагчдын зөвлөлийн үйл ажиллагаа байдаг. Энэ судалгаанд хамрагдсан олон нийтийн телевиз радиогийн байгууллагууд бүгд хуулийн, бодлогын ба бусад хариуцлага хүлээдэг зөвлөлөөр удирдуулдаг. Дээрх зөвлөлүүдийн гол үүргийн нэг нь олон нийтийн өмнө хүлээсэн хариуцлагыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ засгийн газрын хөндлөнгийн оролцооноос тус байгууллагыг хамгаалхад оршино. Үнэндээ, Австрали, Өмнөд Африк зэрэг орнуудад тус зөвлөл нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын хараат бус байдлыг хөхүүлэн дэмжих ба хадгалах хууль эрх зүйн үүрэг хүлээдэг.

Түүнчлэн, зөвлөл нь өөрөө аливаа улс төрийн хүчнээс хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлтэй байж телевиз радиогийн байгууллагын хараат бус байдлыг хамгаалж чадна. Энэ нь хэнд ч ил тод бөгөөд уг нөхцлийг Европын Зөвлөл нь

“Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагыг удирдаж буй зөвлөлийн статус, ялангуяа түүний гишүүнчлэлтэй холбоотой асуудлыг зохицуулах дүрэм нь аливаа улс төрийн буюу бусад хүчний хөндлөнгийн оролцооны эрсдлийг урьдчилан сэргийлэх зарчмаар боловсруулагдсан байх ёстой” гэж зөвлөмждөө маш тодорхой илэрхийлсэн юм.

Улс орон тус бүрт зөвлөлийн бие даасан хараат бус байдлыг баталгаажуулахын тулд олон төрлийн аргыг нэвтрүүлж ашиглдагаас хамгийн чухал нь зөвлөлийн гишүүнээр томилогдож буй хувь хүмүүсийг сонгох зарчмыг тодорхойлох нийтлэг арга юм. Үүнд зөвхөн ерөнхийлөгч эсвэл ерөнхий сайдын үзэл бодол бус харин нөлөө бүхий улс төрийн бүх хүчний өргөн хүрээний байр суурийг төлөөлсөн хүмүүсийг гишүүдийг томилох үйл явцад оролцуулах нь маш чухал. Мөн энэхүү үйл явцад үйл ажиллагаанд оролцох хүрээг улам өргөсөх болон нууцаар нэр дэвшүүлэхийг урьдчилан сэргийлэх үүднээс иргэний нийгмийн төлөөлөгчдийн оролцоог хангасан байх ёстой. Үүнээс гадна, бас нэг анхаарах чухал зүйл нь зөвлөлийн гишүүдэд нийтэд нь болон гишүүн тус бүрт тавих шаардлагыг тодорхойлох явдал юм. Үүнд мэргэжлийн тусгай шаардлага хангасан, улс төрч бус эсвэл ноцтой гэмт хэрэг үйлдэж байгаагүй хүмүүсийг томилох ба сонирхлын зөрчлийн тухай журам болоод зөвлөлийн гишүүд нийтээрээ нийгмийг бүхэлд нь төлөөлөх зарчмын шаардлага орно. Засгийн газрын зүгээс зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх, дарамтлахыг урьдчилан сэргийлхийн тулд тэдгээрийг томилох хугацааг баталгаажуулах нь зүйтэй. Эцэст нь зөвлөлийн гишүүдийн шагнал урамшуулалын хэмжээг ч мөн улс төрийн нөлөөнөөс хамааралгүй байлгах шаардлагатай.

Зөвлөлийн хараат бус байдлыг нь зарим талаараа телевиз, радиогийн байгууллагын жинхэнэ зорилго болох нэвтрүүлгийн эрх чөлөө, хараат бус байдлаас ялгах нь зүйтэй. Нэвтрүүлгийн эрх чөлөө, хараат бус байдлыг хангах үүднээс ихэнхи орнуудад зөвлөлийн үйл ажиллагааг ерөнхий хяналтын үүргээр хязгаарладаг бөгөөд зөвлөл байгууллагын нэвтрүүлгийн асуудалтай холбоотой өдөр тутмын шийдвэрт хөндлөгөөс оролцох эрхгүй байдаг. Ингэснээр зөвлөл телевиз радиогийн байгууллага болон төр

засгийн газрын хооронд холбогч болон ажиллаж нэвтрүүлгийн эрх чөлөө, хараат бус байдлыг хадгалах бололцоог бүрдүүлдэг. Иймд засгийн газар өөрийн эсрэг мэдээ явуулсан талаархи гомдлыг Мэдээний Редакторт тавибал энэ нь зохисгүй явдал бөгөөд энэхүү гомдлыг харин зөвлөлд гаргавал илүү тохиромжтой болно.

Хариуцлага хүлээх

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд засгийн газрын хөндлөнгийн оролцооноос хараат бус байх ёстой ч нөгөө талаас тэдгээр нь олон нийтийн өмнө хариуцлага хүлээж, олон нийтэд үйлчлэх үүрэг болон олон нийтийн эрх ашгийг дээдлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэхийг хянах механизмууд мөн байх ёстой. Эс тэгвээс зөвлөл, удирдах ажилтнууд эсвэл тэдгээр байгууллагуудын ажилтнуудын эрх ашиг олон нийтийн эрх ашгаас дээгүүр тавигдан шамшигдуулахад хүргэнэ. Үүрэг хариуцлагыг тооцох, биелэлтийг нь хянах хэд хэдэн механизм байдгийг доор дурьдая.

Ерөнхий түвшинд ихэнх олон нийтийн телевиз радио нийгэм дэхь хувь хүмүүс, байгууллага, компаниудын харилцаа холбоо, үйл ажиллагааг нийтэд нь зохицуулах хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд гэрээ хэлэлцээр ба бусдын эрх ашгийг шамшигдуулсан \худал хуурамч мэдээлэл үүнд мөн хамаарагдана\ тохиолдолд хүлээх үүрэг хариуцлагын тухай ерөнхий хууль болон бусад холбогдох хуулиудаас цөөнхийг нэрлэхэд садар самуун, үзэн ядах үг хэлэхийн эсрэг хууль, хөдөлмөрийн харилцааны тухай болоод байгаль орчны стандартын тухай хуулиуд багтана. Товчоор хэлэхэд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд энгийн иргэдийн нэгэн адил ерөнхий үүрэг, хариуцлага хүлээнэ.

Энэхүү судалгаанд хамрагдсан олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын зөвлөл нь үүрэг хариуцлагын хэрэгжүүлэлтэд хяналт тавихад гол үүрэг гүйцэтгэдэг нь хамгаас илүү ач холбогдолтой зүйл мөн. Дээрх зөвлөлүүд телевиз радиогийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцдоггүй нь тус байгууллагуудын үйл ажиллагааг бодитоор үнэлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Үүнээс гадна эдгээр зөвлөлүүд нэвтрүүлгийн эрх чөлөө, хараат бус байдлыг зөрчихгүйгээр засгийн газрын дэмжлэг авах боломжтой. Олон төрлийн аргаар дамжуулан олон нийтийн үзэл бодлыг үйл ажиллагаандаа үргэлж тусгаж ажиллах нь тэдгээрийн үүрэг мөн. Жишээлбэл, дээр дурьдсан зөвлөх байгууллагуудаас гадна судалгаа, санал асуулга, семинар, олон нийтийн уулзалт тогтмол зохион байгуулах нь зөвлөлийн үүрэг болно.

Ихэнхи орнуудад олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын зөвлөл албан ёсоор, эсвэл хууль тогтоогч дээд байгууллага, эсвэл Парламентад үйл ажиллагаагаа тайлагнадаг. Зөвлөл жилийн тайлангаа Парламент эсвэл олон этгээдээс бүрдсэн бусад байгууллагад өргөн барьдаг. Жилийн тайлан нь аудитын хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, өөрийн зорилго зорилтын хэрхэн биелүүлсэн, олон нийтээс ирсэн санал гомдлыг хэрхэн барагдуулсан талаар нарийвчилсан мэдээллийг багтаасан байх шаардлагатай. Парламент зөвлөлийн гишүүд эсвэл даргыг дуудаж гарсан асуудлаар хариу болон тайлбар өгөхийг шаардах эрхтэй. Энэ нь хууль тогтоогчид, төрийн эрх баригчдад зөвлөлийн үйл ажиллагааны талаар өөрийн санал бодлоо илэрхийлэх боломжийг олгодог.

Ач холбогдол бүхий зарим сонсогч үзэгчдийн хэсэг бүлгийн хэрэгцээ шаардлагын талаар олон нийтийн телевиз радиогийн байгууллагад зөвөлгөө өгөх байгууллагууд үүсгэн байгуулах хандлага ихэсч байгаа нь ажиглагдаж байна. Зөвөлгөө өгөх байгууллагууд нь цөөнх эсвэл тухайн орон нутгийг төлөөлсөн байдлаар байгуулагдаж болохоос гадна олон нийтийн телевиз радиогийн зарим онцгой асуудал болон

олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар хэлэлцэх зорилготойгоор түр байгуулагдаж болно. Нэгдсэн Вант Улс, Япон, Өмнөд Африк, Австрали зэрэг орнуудын хуулинд зөвөлгөө өгөх байгууллагууд байнгын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна гэж заасан байдаг. Сонсогч үзэгчдийн өргөн хүрээг бүхэлд нь төлөөлсөн, улс төрийн болон аливаа бусад талуудын аливаа нөлөөлөөс хамгаалагдсан бүтэц ба гишүүдийг томилох журамтай байж чадвал эдгээр байгууллагууд нь үр бүтээлтэй, албадлагын бус шинж чанартай үүрэг хариуцлагыг тооцох механизмыг бүрдүүлдэг.

Энэ судалгаанд хамрагдсан олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд үйл ажиллагаа явуулах эрх ба долгион давтамж хуваарилах эрх бүхий холбогдох зохицуулагч байгууллагуудтай тус бүр өөрийн харилцаа холбоотой байдаг. Ихэнхи олон нийтийн телевиз радиогийн байгууллагуудын хувьд хувийн хэвшлийн телевиз радиотай харьцуулхад үйл ажиллагааны эрх авах эсвэл долгион давтамж хуваарилхын тулд өрсөлдөх шаардлага байдаггүй. Зарим олон нийтийн телевиз радио нь эрх олгох\ шинэчлэхтэй холбоотой ёс төдий үйл процессд оролцох шаардлагатай байдаг нь зохицуулагч байгууллагууд ба олон нийтэд эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг хэлэлцэж шүүмжлэх боломжийг олгодог. Зарим тохиолдолд, жишээлбэл Өмнөд Африкт, эрх олгох\ шинэчлэх нь зөвхөн ёс төдий бус харин албан ёсны өндөр түвшинд тавигддаг шаардлага юм. Энэхүү процесс нь нэг талаас телевиз радиогийн үүрэг хариуцлагыг тооцох үр ашигтай үйл ажиллагаа боловч нөгөө талаас эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох боломжийг засгийн газарт олгодог. Цогц, хатуу зохицуулалтын систем нь “техникийн” шалтгаан дээр үндэслэсэн телевиз радиогийн үйл ажиллагааг зохисгүй байдлаар хянах боломж олгодог. Хэдийгээр энэ нь боломжтой боловч олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг тусгай болоод нээлттэй үйл ажиллагаагаар дамжуулан илүү сайн тооцож болох бөгөөд олон нийтийн телевиз радиогийн байгууллагад олгох үйл ажиллагааны эрх ба давтамж долгионы хуваарилалтыг хуулиар баталгаажуулдаг.

Санал гомдол хүлээж авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар олон нийтийн өмнө шууд хариуцлага хүлээх хэлбэр нь түгээмэл болоод байна. Тодорхой шалтгааны улмаас тухайн телевиз, радиогийн байгууллагад ноцтой гомдол иргэд, нийгмийн төлөөлөгчид асуудлыг тус байгууллага эсвэл гуравдагч тал болох ихэнхи тохиолдолд үндэсний телевиз радиогийн стандарт тогтоох агентлаг эсвэл хоёуланд нь тавин шийдвэрлүүлэх боломжтой. Австралийн жишээг авж үзэхэд АТРК нь гомдол саналыг хангалттай түвшинд барагдуулж чадаагүй тохиолдолд л Австралийн Телевиз Радиогийн Удирдах Газар хэмээх хараат бус байгууллага уучлал хүлцэл хүсэх, алдааг засах талаар шийдвэр гарган түүнийг хэрэгжүүлхийг шаардах эрхтэй байдаг. Гэхдээ нэвтрүүлгийн байр суурь буюу улс төрийн үзэл бодлын талаархи маргааны шинжтэй санал гомдлыг авч хэлэлцэхгүй байх үүднээс хүлээж авах санал гомдлын хүрээг маш нарийн тодорхойлох нь зүйтэй. Жишээ нь, Австрали улсад телевиз радиогийн байгууллага өөрийн зорилго, үүргийг биелүүлж чадаагүйтэй холбоотой санал гомдлыг л зөвхөн хүлээн авч хэлэлцдэг болно.

Үүрэг хариуцлагыг тооцох албан бус механизмын ач холбогдлыг үл ойшоож болохгүй. Хэвлэл мэдээллийн бусад байгууллагууд, хэрэглэгчдийн бүлэг, боловсрол сургалтын болон төрийн бус байууллагууд зэрэг иргэний нийгмийн төлөөлөгчид нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад мөн хяналт тавьдаг. Үүнтэй холбогдуулаад ил тод байдал ба олон нийтэд хүргэж буй байгууллагын сурталчилгаа олон нийтийн телевиз радио бүрийн хувьд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг нь тус байгууллагуудын цаашдын оршин тогтнол ба санхүүжилт эцсийн эцэст олон нийтээс олгож буй дэмжлэгээс хамааралтай холбоотой.

Санхүүжилт

Ардчилал хөгжсөн орнуудад олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын засгийн газрын хөндлөнгийн оролцооноос хараат бус байх эрх чөлөө нь хууль эрх зүйн хувьд ч, албан ёсны практик үйл ажиллагаанд ч харьцангуй баталгаажсан байдаг. Өнөөдрийн хувьд олон нийтийн телевиз радиогийн байгууллагуудын өөрийн үүргийг хэрэгжүүлэх үйл явцад учирч буй гол аюул нь тэдгээрт үзүүлж буй санхүүгийн шахалт дарамт юм. Засгийн газрын тусламжийг багасгах санал бодол ерөнхийдөө ноёрхож буй ийм цаг үед олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн олон байгууллагуудад нэг талаас үйлчилгээний чанар болон түвшинг урьдынхтай адил хэвээр нь баримтлах шаардлага тавьж байгаагийн зэрэгцээ, нөгөө талаас төрийн санхүүжилтийн хэмжээ нь багасч байна.

Уламжлал ёсоор, судалгаанд хамрагдсан Өмнөд Африкаас бусад орнуудад олон нийтийн телевиз радиогийн үйл ажиллагааг нэг бол засгийн газрын нэгдсэн нөөцөөс эсвэл телевиз радиогийн хураамжаар голчлон санхүүжүүлдэг. Олон нийтээс олгож буй санхүүжилтийн энэ хоёр төрөл нь тус бүр өөрийн давуу ба сул талтай. Хэрэглэгчдэд ноогдуулах телевиз радиогийн хураамж засгийн газрын хөндлөнгийн оролцооноос харьцангуй хамгаалагдсан бөгөөд санхүүжилтийн түвшинг яваандаа хангалттай хэмжээнд барьж чаддаг. Хураамж хураах зардал гардаг боловч цахилгаан хэрэглэгчдээс хураадаг төлбөрийн сүлжээ зэрэг төлбөр төлөх одоогийн тогтолцоог давхар ашиглаж зардлыг хэмнэх боломжтой. Үүнээс илүү ноцтой асуудал нь телевиз радиогийн хураамжийн урьдын уламжлалгүй орнуудад хураамж нэвтрүүлж эхлэх явдал нь улс төрийн шалтгааны улмаас хэцүү шийдвэр гэдэг нь батлагдсан билээ. Нөгөөтэйгүүр, энэхүү хураамж нь телевиз радиогийн байгууллагуудад сонсогч, үзэгчдийн тоог ихэсгэж өөртөө татах шахалт үзүүлж, улмаар олон нийтийн өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд нь сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Судалгаанд хамрагдсан орнуудын дунд олон нийтэд үйлчилдэг байгууллагууд нь олон нийтийн өмнө хүлээсэн үүрэгтэй үнэнч, харьцангуй сайн хэрэгжүүлдэг боловч зөвхөн Япон улсад л олон нийтийн телевиз радиогийн санхүүжилтын дийлэнх ихэнхийг нь олон нийтийн сангаас гаргадаг юм. Засгийн газрын бүрэн санхүүжилтийг тодорхой хэмжээгээр орлох зорилгоор олон нийтэд үйлчилдэг олон тооны телевиз радио арилжааны үйл ажиллагаа болох зар сурталчилгаа хийхээс гадна дүрс бичлэг, ном зэрэг салбарт хөл тавьж орлого олох боллоо. Өнөөгийн байдлаар зар сурталчилгааны үйл ажиллагаа нь зөвхөн телевизийн салбарт хөгжиж тархаад байгаа нь нэг талаасаа радиогийн салбартай харьцуулахад телевизийн зардал маш өндөртэй холбоотой юм.

Хэдийгээр олон нийтийн долгионоор зар сурталчилгаа явуулахад буруу байхгүй боловч үүнд хэд хэдэн эрсдэл байдаг. Телевиз радиогийн байгууллага өдөрт тодорхой хэмжээний нэвтрүүлэг явуулах хязгаартай бөгөөд чанартай нэвтрүүлэг олон байх тусмаа сайн. Арилжааны үйл ажиллагаа нь олон нийтийн телевиз радиогийн хувийн байгууллагуудыг дууриахад хүргэдэг бөгөөд нэвтрүүлгийн сонголтыг хийхдээ чанарыг дээдлэх бус харин тухайн нэвтрүүлэг хэр олон тооны үзэгчид цуглуулдаг дээр тулгуурлан шийдвэрээ гаргах томоохон эрсдэл бий. Ингэснээр нэвтрүүлгийн чанар буурч, нэвтрүүлгийн төрөл багасч юуны түрүүнд олон нийтийн телевиз радио оршин тогтнох бодит үндэслэлийг үгүй болгоно. Нөгөөтэйгүүр, олон орнуудын жишээнээс харахад санхүүгийн бэрхшээл болон төрийн санхүүжилт буурч буй нь нэмэлт орлогын эх үүсвэрийг нээхээс нааш олон нийтийн телевиз радиогийн байгууллага өөрийн нэвтрүүлгийн сүлжээг чанарын өндөр түвшинд болон шаардлагатай хэмжээнд хадгалж чадахгүйд хүргэж байна. Үүнийг тэнцвэржүүлэхийн тулд арилжааны чанартай зар сурталчилгаанд хязгаарлагдмал цаг олгохын зэрэгцээ нөгөө талаас санхүүгийн эх үүсвэрийн дийлэнхи хувийг төрөөс гаргах шийдэл юм.

Бидний бодлоор, олон нийтэд үйлчилдэг телевиз радио олон нийтээс голлон санхүүжих ёстой бөгөөд бид энэ байр сууриндаа үнэнч хэвээр байна. Хэрэв олон нийтийн телевиз радиогийн байгууллагууд зах зээлд өрсөлдөхөд хүрвэл тэд өөрсдийн өрсөлдөгч болох хувийн телевиз радиог дууриаж нэгэн адил болохоос өөр аргагүй байдалд хүргэж, улмаар олон нийтэд үйлчлэх үүрэг болон оршин тогтнох зорилгоо үгүйсгэн мартаж хэрэгтэй болно.

ДҮГНЭЛТ

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд хувийн телевиз радиогийн нэвтрүүлгийн сүлжээг нөхөж, улмаар тэдгээрийг тэргүүлснээр өргөн хүрээний мэдээ мэдээлэл, үзэл санааг хүлээн авах олон нийтийн эрхийг баталгаажуулхад зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон нийтэд үйлчилдэг шилдэг байгууллагууд мэдээ болон шуурхай нэвтрүүлгийг чанарын өндөр түвшинд бэлтгэн цацаж, үндэсний үзэл бодол, ардчилал ба нийгмийн бусад үнэт зүйлсийг хөхүүлэн дэмжиж, боловсрол танин мэдэхүй ба мэдээллийн чанартай нэвтрүүлгийн сүлжээг хөгжүүлж, нийгэм дэх цөөнх болон бусад өвөрмөц бүлгүүдийн хэрэгцээг хангах үүргийг хүлээн гүйцэтгэдэг.

Олон нийтэд үйлчлэх телевиз радиогийн үүргийн хэрэгжүүлэлтийн чанар нь дараах гурван нөхцлөөс бүрддэг. Үүнд: мэдээ мэдээлэл, боловсрол танин мэдэхүй ба цэнгээнт нэвтрүүлгийн чанартай сүлжээ бүхий олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг болон олон нийтийн санхүүжилтийн зарцуулалтын талаар олон нийтийн өмнө хариуцлага хүлээх чөлөөтэй ба хараат бус телевиз радиогийн байгууллагууд багтана. Хууль эрх зүйн хүрээнд тусгасан баталгаа болон хараат бус удирдах байгууллагууд нь олон нийтийн телевиз радиогийн байгууллагуудын хараат бус статусыг дэмжих хамгийн баталгаатай арга зам болно. Эдгээр удирдах байгууллагууд хариуцлага хүлээх болон тооцох гол механизм болж ажилладаг бөгөөд үйл ажиллагаагаа тайлагнах арга зам, санал гомдол хүлээн авах зохион байгуулалт, зөвлөх байгууллагууд ба судалгаа явуулах зэрэг аргаар олон нийтийг татан оролцуулж, зохицуулагч хараат бус байгууллагаар дамжуулан тус олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг хянах нь тэдгээрийн үүргийн хэрэгжүүлэлтийн нөхцлийг хангахад чиглүүлсэн үйл ажиллагаа мөн. Санхүүжүүлтийн асуудал нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын өмнө тулгараад байгаа хамгийн хэцүү асуудал. Хэдийгээр төрийн санхүүжилт зарим давуу талтай боловч бодит амьдралд энэхүү санхүүжүүлтийн эх үүсвэрийн хэмжээ багассаар байгаа бөгөөд ихэнх олон нийтэд үйлчилдэг телевиз радио нь санхүүгийн нэмэлт эх үүсвэр хайх шаардлагад хүрээд байна. Төрийн санхүүжилтийг голлон түүний зэрэгцээ арилжааны үйл ажиллагаанаас орлого олох санхүүжилтийн арга зам нь олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагуудын дунд түгээмэл хэлбэр болжээ.

Дээрхи нөхцөл бүрдсэн тохиодолд олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагууд олон нийтийн аливаа зүйлийг мэдэх, өргөн хүрээний, олон талт ба олон ургальч телевиз радиогийн нэвтрүүлэг хүлээж авах эрхийг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний хувь нэмэр оруулдаг. Эдгээр байгууллагууд олон нийтийн ашиг сонирхлыг хангах, мэдээ мэдээлэл, үзэл санааны чөлөөт урсгалыг бий болгоход чухал болоод онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд засгийн газар болон бусад олон нийтэд үйлчилдэг аливаа байгууллага, этгээд нь олон нийтэд үйлчлэх зорилго бүхий энэхүү тогтолцоог тогтвортой санхүүжилтээр хангах ёстой.

Хавсралт А

Олон нийтэд үйлчилдэг телевиз радиогийн байгууллагын үйл ажиллагааны нэг хүн амд ноогдох орлого \фунт стерлинг, 1996 оны байдлаар

Орон	Хураамж	Засгийн газрын санхүүжилт	Зар сурталчилгаа	Бусад
Япон \NHK\	100	0	0	0
Норвеги \NRK\	99	0	1	0
Швед \SVT\	98	0	1	1
Австрали \ABC\	98	0	2	0
Нэгдсэн Вант Улс \BBC\	97	0	3	0
Дани \DR\	91	0	1	8
Герман \ARD\	82	0	9	9
Турк \TRT\	59	21	5	15
Бельги \VRT\	77	0	22	1
Канад \CBC\	0	75	22	3
Герман \ZDF\	73	0	17	10
Бельги \RTBF\	72	0	20	8
Нидерланд \NOS\	69	0	23	8
Франц \F3\	66	2	32	0
Чех \CT\	61	0	24	15
Итали \RAI\	59	0	37	4
Франц \F2\	50	0	50	0
Португали \RTP\	0	48	48	4
Польш \TVP\	32	0	37	31
Дани \TV2\	25	0	72	3
Испани \RTVE\	0	25	64	11
Өмнөд Африк \SABC\	18	0	78	4
Шинэ Зеланд \TVNZ\	0	0	100	0

үйлчлэхгүй байх нь зүйтэй. Гишүүд нь өөрсдийгөө аливаа нэг хувийн ашиг сонирхолд үйлчилдэггүй бие даасан, итгэмжлэгдсэн хүмүүс гэж үзвэл зохино. Гишүүдийг тодорхой хугацаагаар, улс төр, ёс заншил, нийгмийн болон мэргэжлийн зэрэг олон талын судалгааг үндэслэн олон нийт хүлээж авах, нэр хүндтэй хүмүүсээр бүрдүүлэх нь зүйтэй. Сонгууль явуулахдаа Засгийн газар, улс төрийн аль ч нам хожим нь нөлөө дарамт учруулахгүй байх тийм хамгааллыг бодолцох хэрэгтэй.

Удирдлагын зөвлөл нь түүнд ажлаа тайлагнах үүрэг бүхий ОНРТВ-ийн захирлуудыг томилох бөгөөд ингэснээр яваандаа тэд үйл ажиллагаагаа Засгийн газраас хараат бусаар явуулах боломж бүрдэнэ. Радио, телевизийн захирлууд мэргэжлийн байх шаардлагатай бөгөөд улс төрийн аль нэг намын төлөөлөгч удирдах бүрэлдэхүүнд орж болохгүй.

Зөвлөмж 2

Редакцийн хараат бус байдлыг хангах зарчмуудыг хуульчлах

ОНРТВ-ийн редакцийн бодлого болон бүх шийдвэр Засгийн газрын нөлөөнөөс чөлөөтэй, хараат бус байвал зохино. Олон нийтээс санхүүждэг радио, телевизийн редакцийн бодлого нь улс төрийн үнэн зөв, шударга зарчмуудын хэм хэмжээг мөрдлөг болговол зохино. Гэхдээ редакцийн хараат бус, бие даасан байдалд нөлөө үзүүлж болзошгүй аливаа жижиг зүйлийг ч бодолцон тэдгээр зарчимд тусгасан байх ёстой.

Зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх үйлсэд Засгийн газрын давуу эрхийг үзүүлж харуулхыг сэтгүүлчдээс шаардсан заалт, зарчим байх ёсгүй. Редакцийн хараат бус байдал гэдэг нь олон нийтийн аливааг олж мэдэх гэсэн эрмэлзлийг хүндэтгэж, үйл явдлын тухай мэдээллийн үнэ цэнэ гэх мэт сэтгүүлч, редакторууд мэргэжлийн үүднээс олон улсын хэм хэмжээнд нийцхүйц шийдвэр гаргах эрх гэсэн үг юм.

Зөвлөмж 3

ОНРТВ-ийг шаардлагатай санхүүжилтээр хангах, төсөвт хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх хүчин зүйлүүдийг хамгаалж, баталгаажуулах

Ардчилсан нийгмийн шилжилтийн үед гагцхүү улс, олон нийтийн радио, телевизийг санхүүжүүлж дийлэхүйц хөрөнгийн эх үүсвэртэй байдаг. Эдгээр улс оронд ОНРТВ улсын төсвөөс санхүүжих, үгүйдээ, тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг туслалцаа болон цаашдын үйл ажиллагаанд нь шаардагдах хөрөнгийг улсаас авч байвал зохино. Гэхдээ Засгийн газар болон Парламентад өөрийнх нь байр суурьтай үл нийцэх нэвтрүүлгийн төсвийг багасгах, зохицуулах оролдлого хийх бололцоо олгохгүй тийм аргыг эрэлхийлж, сэргийлэх ёстой. Энэ бол үзэгч, сонсогчдоос төлөх хураамжийн систем юм. Ингэлээ гээд нэвтрүүлэг хүлээн авагчдын тоо, түвшинг буруулах ёсгүй.

ХУВИЙН РАДИО, ТЕЛЕВИЗ

Зөвлөмж 4

***Нэвтрүүлгийн зөвшөөрөл олгохдоо ялгаварлахгүй,
хараат бус байх зарчмыг баталгаажуулах***

Нэвтрүүлгийн зөвшөөрөл олгох механизм ихэнх тохиолдолд хувийн радио, телевизийг хязгаарлахад хүргэдэг. Зөвшөөрөл олгох нууц, шударга бус механизм нь зөвшөөрөл олгох хугацааг саатуулах, тодорхой бус үндэслэлээр татгалзах, эсвэл гагцхүү Засгийн газрыг дэмжигчид л зөвшөөрлийг баталгаатай олж авах зэрэг үр дагаварт хүргэж болзошгүй. Хувийн радио, телевизийг дэмжих хандлагатай тийм зөвшөөрөл олгох механизм боловсруулах нь зүйтэй.

Зөвлөмж 5

***Нэвтрүүлгийн зөвшөөрлийг засгийн газраас хараат
бус байгууллага олговол зохино.***

Нэвтрүүлгийн зөвшөөрөл олгох байгууллага нь засгийн газраас хараат бус байх ёстой. Энэ хараат бус байгууллага нь Олон нийтийн радио, телевизийн удирдах байгууллагатай хамт байж ч болно. Эсвэл тусдаа ч байж болно. Гэхдээ олон нийтийн болон хувийн радио, телевизийн хувьд хуулийн эрх мэдэл бүхий нэг байгууллага байх нь радио, телевизийн бүхий л хүрээнд олон ургальч үзэл бодлыг хангах талаарх зохицуулалт бүхий стратегийг тусгасан нэвтрүүлгийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх боломж олгодог болохыг харгалзах нь зүйтэй юм.

Тэрхүү хараат бус байгууллага нь бас долгионы хуваарилалт, нэвтрүүлэг цацах, дамжуулах талын техникийн бусад асуудлыг хариуцдаг байвал зохино.

Зөвлөмж 6

Зөвшөөрлийг гагцхүү онцгой ноцтой нөхцөл байдалд л хурааж болно.

Нэвтрүүлэг эрхлэгчид нь шууд байдлаар арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, эсвэл яс угсаагаар дайрч доромжлох / Зөвлөмж 10- ыг үзнэ үү / зэргээр эрх мэдлээ бүдүүлгээр хэтрүүлэн ашигласан тохиолдолд л нэвтрүүлгийн зөвшөөрлийг хураавал зохино. Нэвтрүүлгийн зөвшөөрлийг гагцхүү түүнийг олгосон байгууллага л хурааж болно. Гэсэн хэдий ч нэвтрүүлгийн зөвшөөрөл нь байнга шинэчлэгдэж, сунгагдаж байвал зохих зүйл юм. Нэвтрүүлэг эрхлэгч нь зөвшөөрлийг авахдаа тохиролцсон нөхцөл, заалтаа зөрчсөн бол зөвшөөрөл олгох байгууллага нь түүнийг шинэчлэх, сунгахаас татгалзаж болно.

Зөвлөмж 7

***Хязгаарлагдмал бөөгнөрөл, солбисон- өмчлөлийн талаарх арга хэмжээг
мэдээллийн эх сурвалжийн олон ургалч үзлийг хангахын тулд л авч байвал зохино.***

Мэдээллийн эх сурвалжийн олон ургальч үзэл бодлыг хөхүүлэн дэмжих ашиг сонирхлын үүднээс зөвшөөрөл олгогч байгууллага нь электрон болон хэвлэмэл хэвлэлийн хэвшлийн хоорондох ХМХ-ийн солбилцсон өмчлөлийг оролцуулан хэвлэл мэдээллийн байгууллагын өмчид тодорхой хязгаарлалт тавих замаар улсын ч бай, хувийн ч бай, аливаа монополиос сэргийлэх ёстойг бодолцвол зохино.

РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ХҮРЭЭНД ОЛОН УРГАЛЬЧ ҮЗЛИЙГ ХАНГАХ ТАЛААРХ ЗАСГИЙН ГАЗРЫН БУСАД ҮҮРЭГ

Зөвлөмж 8

Засгийн газар үзэл бодлын эрх чөлөөнд нөлөө үзүүлэхүйц хууль, эрх зүйн орчинг бий болговол зохино.

Ерөнхий хууль, эрх зүйн болон улс төрийн байдал тааламжтай бол радио, телевиз цензурээс чөлөөт байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний утга учир хэрэгжих боломжтой. Үзэл бодлын, мэдээллийн болон хэвлэл мэдээллийн эрх чөлөө Үндсэн хуулиар хамгаалагдсан байх ёстой. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлахуйц Нууцын хууль, аливаа хор, хохирол үзүүлж, хагалан бутаргаж болзошгүй заалтууд, гэмт хэргийн болон гүтгэлгийн талаарх хууль зэрэг хууль, тогтоомжийн заалтуудыг өөрчлөх нь зүйтэй.

Нэвтрүүлэг эрхлэгчдийн редакцийн хараат бус байдал болон сэтгүүлчдийн мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хамгаалах асуудлыг хуулиар баталгаажуулсан байх ёстой. Олон нийтийн мэдээлэл хүртэх эрх нь Мэдээллийн эрх чөлөөний хуулиар хамгаалагдсан байвал зохино. Төр, засгийн газрын тухай мэдээллийн эх сурвалжийг хүртэх явдал үл ялгаварлах зарчмын дагуу баталгаажсан байвал зохих бөгөөд хувийн радио, телевизийнхэн ОНРТВ-ийнхний нэг адил Засгийн газрын албан тушаалтнуудаас ярилцлага авах, хэвлэлийн бага хуралд оролцох зэргээр албан ёсны мэдээллийн эх сурвалжийг хүртэх ижил эрхтэй байх нь зүйтэй.

Зөвлөмж 9

Засгийн газар нь радио, телевиз эрхлэгчдэд эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлж өгвөл зохино.

Олон ургальч радио, телевизийн хувьд эдийн засгийн хязгаарлалттай тулгарах нь олонтай.

Нэвтрүүлгийн зөвшөөрөл олгох хараат бус байгууллага нь засгийн газрын зар сурталчилгааг хуваарилахдаа давуу байдал гаргуулахгүй байх үүднээс зарчим боловсруулбал зохино. Улсын мэдлийн ХМХ-ийг дэмжиж, хувийн хэвшлийнхэнд саад тотгор болохуйц ялгавартай татвар, гаалийн үйлчилгээ байдаг бол тэдгээрийг эцэс болгох нь зүйтэй.

Хувийн радио, телевизэд боломжийн, үл ялгаварлах үнэ тарифын үндсэн дээр улсын өмчийн дамжуулах цамхагийг ашиглах, сансрын сувгийг түрээслэхийг зөвшөөрөх нь зүйтэй. Мэдээллийн чөлөөт урсгалаас болгоомжилсон, эсвэл хориглосон тийм хуулийн заалтууд болон засгийн газрын агентлагуудаас тогтоосон техникийн болон үнэ тарифын журмыг хоригловол зохино.

Гадаад нэвтрүүлгийн асуудал хариуцсан байгууллагуудад хүрэлцэхүйц санхүүжилт олгох асуудлыг засгийн газар шийдвэрлэж өгөх нь зүйтэй бөгөөд энэ санхүүжилтийг тэдгээр байгууллагын хараат бус байдлыг зохицуулах, хөндлөнгөөс оролцох зэрэг явдалд ашиглаж болохгүй.

Зөвлөмж 10

Засгийн газар нь эфирт хамгийн олон янзын үзэл бодлыг тусгах боломжийг хангах үүднээс ямар ч " дайсагнасан яриа " гарч болзошгүйг хүлээн зөвшөөрвөл зохино.

Янз бүрийн үзэл бодлын асуудалд хүлцэлтэй хандах нь тэдгээрээс эх сурвалжтай " Дайсагнасан яриа"-ны эсрэг үйлчлэх хамгийн сайн арга юм. Ийм маягийн үзэл бодлыг тараах, түгээх хамгийн үр ашигтай зам бол тэдгээрийг хамгийн олон үзэгч, сонсогчид хүртээх боломж бүхий хараат бус олон нийтийн радио, телевизүүд байдаг. Нэмж хэлэхэд, эфирт олон янзын үзэл бодлыг цацах боломжийг олгох эрх бүхий нэвтрүүлгийн зөвшөөрөл олгох хараат бус байгууллага байгуулах нь тулгамдсан зорилт юм. Үндэстэн ястан, арьс өнгө, яс угсаа, шашин шүтгэлээр гадуурхах явдал гарсан тохиолдолд эрх бүхий байгууллага Олон улсын Иргэний болон Улс төрийн эрхийн пактын 20-р зүйлийн дагуу тэр радио, телевизийн үйл ажиллагааг даруй зогсоох талаар арга хэмжээ авбал зохино.

Радио, телевиз эрхлэгчид нь эфирт дамжуулсан тэр үзэл бодлыг үл сайшааж буй, үл хуваалцаж буй, санал үл нийлж буй тухайгаа олон нийтэд илэрхийлсэн бол тэдэнд шийтгэл оногдуулах учиргүй.

Зөвлөмж 11

Сонгуульд үр дүнтэй оролцож, саналаа өгөх эрхтэй холбоотой бүх асуудлаар олон нийт хангалттай сайн мэдээлэл авах боломжийг Засгийн газар бүрдүүлсэн байх учиртай. ОНРТВ нь сонгуулийн үеэр улс төрийн бүх намд адил тэгш үйлчлэх, үнэн бодитой шударга мэдээ, сурвалжлага нэвтрүүлэх боломж олгохуйц хараат бус механизмыг бүрдүүлэх нь зүйтэй.

ОНРТВ нь сонгуулийн кампанийн үеэр сонгогчдод тэдний сонгуульд үр дүнтэй оролцож, саналаа өгөх эрхтэй холбоотой бүх талын асуудлаар хангалттай, үнэн зөв мэдээлэл дамжуулах асуудлыг хуульчлах нь зүйтэй. Улс төрийн нам, түүнээс нэр дэвшигчид сонгуулийн кампанийн үйл явц, санал өгөх журам зэрэг наад захын мэдээллийг өгөх шаардлагатай. ОНРТВ нь түүнчлэн улс төрийн намууд, нэр дэвшигчдэд шударга, үл ялгаварлах зарчмын үндсэн дээр эфирийн цаг олгох асуудлыг хуулиар баталгаажуулах хэрэгтэй. Нэвтрүүлгийн хараат бус байгууллага байгуулагдсан цагаасаа Сонгуулийн нэвтрүүлгийн хуулинд " сонгуулийн сурталчилгааны нарийвчилсан журам батлах, аливаа гомдол саналыг хянаж шалгах арга хэмжээ, шийдвэр гаргах эрхийг тэрхүү эрх мэдэл бүхий байгууллагад өгөх нь зүйтэй. Дээрхи журмыг олон улсын хэм хэмжээтэй уялдуулан боловсруулах нь зүйтэй " гэдгийг тусгавал зохино. Тийм хараат бус байгууллага байхгүй тохиолдолд чөлөөт, шударга сонгуульд зайлшгүй хэрэгцээтэй мэдээ, сурвалжлагын наад захын шаардлагуудыг хуульд тусгаж өгвөл зохино. Сонгуулийн кампанийн явцад гарсан санал гомдол, шүүмжлэл нь цөөн хоногоор ч болов шийдвэрлэгдэхгүй саатвал сонгуулийн шударга зарчимд нөлөөлж болзошгүй тул маш түргэн хугацаанд тэдгээрийг барагдуулах тийм механизм байвал зохино.

Зөвлөмж 12

Нэвтрүүлэгтэй холбоотой санал гомдлыг барагдуулах хараат бус механизмыг бүрдүүлбэл зохино.

Нэвтрүүлгийн эрх чөлөөг зөрчсөн талаарх санал гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх механизмыг бүрдүүлбэл зохино. Нэвтрүүлгийн асуудал эрхэлсэн хараат бус байгууллага нь байгуулагдсан цагаасаа санал гомдлыг хянаж, шалгах, барагдуулах нь зүйтэй бөгөөд шийдвэрийг шүүхээр хянуулах нь зүйтэй. Ийм эрх мэдэл бүхий байгууллага үгүй бол чухамхүү энэ л зорилгоор түүнийг байгуулах шаардлагатай.



Х.НАРАНЖАРГАЛ / Сэтгүүлч/

“МОНГОЛД ОЛОН НИЙТИН РАДИО, ТЕЛЕВИЗ БАЙГУУЛАХ НӨХЦӨЛ, БОЛОМЖ”

Хуучин дэглэмийн үед Польшид нууц сонины эрхлэгч байсан нэг хүн, “Ардчилсан нийгэмд ажиллахад туйлын хэцүү” гэж ярьжээ. Тэгэхэд нь “юу нь хэцүү гэж, харин чөлөөтэй, хэвлэн нийтлэх эрхтэй болсон юм биш үү? гэхэд нь “Тэр ч тийм, гэхдээ аль нь худал, аль нь үнэн болохын учрыг бид өөрсдөө эхлээд олж мэдэх болоод байна” гэсэн юм гэнэ лээ.

Үнэхээр сэтгүүлч бидэнд шинэ нөхцөлд амьдарч дадах төдий бус зохих түвшинд ажиллаж сурах, дадлага туршлага хуримтлуулж хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон мэдээллийн эрх чөлөөг хангаж үнэний төлөө тэмцэгч 4 дэхь засаглалын үүргээ биелүүлэх гарцаагүй шаардлага тулгараад байна.

Ардчиллын эртний уламжлалтай улс оронд ч гэсэн олон нийтийн мэдээллийн хүрээнд янз бүрийн зөрчил, тэмцэл байсаар байна. Гэтэл ардчилал дөнгөж хөгжиж байгаа манайх шиг улс оронд үйл явц гүнзгийрэхийн хэрээр мэдээж хэрэг элдэв бэрхшээлтэй тулгарах нь гарцаагүй. Тийм ч учраас сэтгүүлчдийн голч цэх нуруу, улс төрийн соёл, аливаад ул суурьтай дүгнэлт хийж, уншигч үзэгч сонсогчиддоо бодитой мэдээллийг шуурхай хүргэх чадвар юу юунаас эрхэм болж байна.

Хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн бие даасан байдлын түвшин гэдэг үндсэндээ 3 хүчин зүйлээс шалтгаалах болов уу.

1–рт, тухайн үед хууль эрхийн ямар акт үйлчилж байна.

2–рт, мэдээж хэрэг зах зээлд амьдрах нөхцөлийг бүрдүүлж чадахуйц чадварлаг удирдлага шаардагдана.

З–рт, сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадвар, чөлөөт байдлын өмнө хүлээх хариуцлага.

Аливаа хэвлэл, телевиз, радио чөлөөтэй, нийтлэл нэвтрүүлгийн бодлогын хувьд хараат бус байна гэдэг бол эдийн засаг, санхүүгийн хувьд хараат бус байх ёстой нь мэдээж. Энэ бол зах зээл дөнгөж хөгжиж байгаа, эдийн засаг нь сул дорой манай орны хувьд хамгийн эмзэг, халуун цэгийн нэг юм. Ийм ч учраас олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийн өнөөгийн шилжилтийн үеийн тогтолцоо ямар байх вэ? Тэдгээрийг яаж зохицуулах вэ, удирдах, вэ? Мэргэжилтэй боловсон хүчнээр хангах вэ? Хэрхэн санхүүжүүлэх вэ ? гээд олон асуулт тулгарна. Энэ бүхнийг иж бүрэн ул суурьтай боловсруулж, хуульчлан бататгах хэрэгтэй.

XX зуун кино хэмээх гайхамшгаар эхлээд, телевиз хэмээх ид шидтэнээр өндөрлөнө” гэсэн яриа байдаг. Үнэхээр ч хэвлэл, мэдээллийн дотроос үй олон үзэгчдийг өөртөө татдаг телевиз хэмээгч нь дэлхийн аль ч оронд хамгийн хүчирхэг нөлөөтэй хэрэгсэл хэвээрээ XXI зуунтай золгох гэж байна. Монгол улс ямар телевизтэй XXI зуунд орох вэ? Магадгүй бид хэвлэлийн хуулийн тухай өнөө хэрнээ маргаж буй шигээ шинэ зуунд олон нийтийн телевизийнхээ тухай яриад сууж байж мэдэх юм. Гэхдээ өөдрөг сэтгэлтэн байа, үйлс маань ямар ч байсан тэгшрэх байх аа.

Олон нийтийн телевиз гэж юу вэ? Олон нийтийн телевиз гэдэг засгийн газар, аливаа нам, хүчин тодорхой ашиг сонирхол бүхий хэсэг бүлэг хүмүүст бус, гагцхүү олон түмэн үзэгчдийнхээ эрх ашигт үйлчилж, тэдний дунд явуулсан судалгааны үндсэн дээр программынхаа бодлогыг тодорхойлдог телевизийн тогтолцоо юм. Олон нийтийн телевизийн эрх ашиг гэдэг бол ердөө л олон түмний өөрсдийнх нь эрх ашиг байдаг. Зөвхөн өнөөдөр бид Монголд бие даасан, хараат бус телевизийн тухай ярьж байгаа хэрэг биш. Хамгийн анх 1991 онд сэтгүүлч З. Алтай, Монголын Радио, Телевизийн захирал байхдаа “Монгол улсын Засгийн Газрын дэргэдэх радио, телевизийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэн өөрчлөх тухай” гэдэг санал боловсруулж, радио, телевизийн бааз дээр Монголын үндэсний радио, телевиз, төр засгийн радио телевиз гэж байгуулах тухай санал дэвшүүлж, тухайн үедээ дэмжлэг хүлээсэнгүй өнгөрсөн. Үүнээс хойш 3 жилийн дараа 1994 оны 6-р сард Монгол Телевизийн уран бүтээлч 9 хүн хамтран “Монгол телевизийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн, шинэчлэх хөтөлбөр боловсруулсан. Түүндээ, энэ хөтөлбөр нь цаг үе нийгмийн тогтолцоо, ардчилсан нийгмийн ард иргэдийн ашиг сонирхлоос үүдэн Монгол Телевизийн өнөөгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй хэлбэрээр өөрчлөн, шинэчилж, олон нийтийн мэдээллийн программын бодлого, санжүүжилтийн бие даасан үйл ажиллагаатай Монголын Үндэсний Төв Телевиз болгон, цаашид дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын олон нийтийн телевизийн корпорациудын жишигт дөхүүлэн хөгжүүлэх зорилготой” гэж зорилгоо тодорхойлсон.

Өнөөдөр радио хамгийн хүртээмжтэй зэвсгийн хувьд, телевиз хамгийн нөлөөтэй, хүчирхэг зэвсгийн хувьд энэ хоёр байгууллага тус тусдаа биеэ даасан үйл ажиллагаа явуулж болох юм гэдэг хувийн бодолтой байдаг.

Дээрхи хөтөлбөрийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгжүүлэх санал, Монголын үндэсний төв, телевизийн дүрмийн төсөл, дотоод бүтэц зохион байгуулалт үйл ажиллагааны ерөнхий зарчим, энэ телевизийг удирдах ерөнхий зөвлөлийн дүрэм зэргийг боловсруулах хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, МАХН–ын Ерөнхий нарийн бичгийн дарга Даш–Ёндон нарт танилцуулсан. Монгол телевизийн хамт олон бидний хөтөлбөрийг дэмжиж, нийт уран бүтээлчдийн дунд судалгаа явуулах ажлын хэсэг томилсон бөгөөд, санал асуулгын дүнд тэдний 90 гаруй хувь нь бие даасан Монгол телевиз байхын төлөө саналаа өгсөн. Харамсалтай нь тухайн үеийн удирдлага үүнийг маш эмзэглэн хүлээн авсан билээ.

Өнөөдөр Монголд яагаад олон нийтийн телевиз байгуулах шаардлага гарч байна вэ?

Монгол орон ардчиллын замаар тууштай замнаж буй нь үнэн бол, түүний тулгуур зарчмын нэг чөлөөт хэвлэлийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэе гэвэл өнөөдөр манайд хамгийн хүртээмжтэй, хамгийн

нөлөөтэй зэвсэг болох радио, телевизийг хараат бусаар статустай болгох нь зүй ёсны шаардлага мөн. Ийм ч учраас 1–рт, ардчилсан нийгмийн үйл явц гүнзгийрэх явцад телевиз нь бүх ард түмний нийтлэг эрх ашгийн үүднээс засгийн газар болон аливаа нам, улс төрийн хүчнээс хараат бусаар үнэн бодит мэдээлэл олж түгээх, олон нийтэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж бүхий ардчиллын жинхэнэ индэр байх асуудал хурцаар тавигдаж байна.

2–рт, улс орны эдийн засаг хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд улсын төсвийн ачаа хөнгөлөх, зах зээлд өөрийн хүчээр амьдрах эх үүсвэр, арга ухаан сүвэгчилж, санхүүгийн бие даасан байдлыг хангах нь тулгамдсан зорилтын нэг болж байна.

3–рт, ард түмний байнга, түргэн хурдацтай өсөн нэмэгдэж байгаа оюуны хэрэгцээг хангахын тулд телевизийн үндсэн үүргийг зөв тодорхойлж, мэдээлэл, нэвтрүүлгийн уран сайхны түвшинг шинэ шатанд гарган, үзэгчдийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх шаардлага эн тэргүүний асуудал болж байна.

4–рт, өнөөгийн Радио, Телевизийн Хэрэг Эрхлэх Газрын бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн механизм, цаг үеийн шаардлагатай зөрчилдөж, хоцрогдон, улмаар боловсон хүчин, техникийн бодлого, ажиллагсадын нийгмийн асуудал үндсэндээ орхигдон мухардмал байдал бий болжээ.

Монгол телевизийн дотоод бүтцийг өөрчлөх гэсэн оролдлого урьд өмнө бишгүйдээ гарч байлаа. Харамсалтай нь тэр болгон зөвхөн өнгөц, хэлбэр төдий байснаас ул суурьтай өөрчлөлт болж чадаагүй тул амжилт олж байсангүй.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслэлийн тогтолцоонд телевизийн чөлөөт хараат бус байдлыг хангах, монопол эрхийг хязгаарлах асуудал эн тэргүүний чухал төдийгүй хамгийн ярвигтай нь юм. Тиймээс ч хараат бус телевизийн жилийн төсөвт шаардлагатай тэрбум нэлээд хол давах хөрөнгийн эх үүсвэрийг хаанаас гаргах, хэрхэн шийдэх нь туйлын түвэгтэй, нарийн асуудал. Ардчилал дөнгөж хөгжиж байгаа манайхны хувьд өндөр хөгжилтэй орнуудын туршлага яах аргагүй хэрэгтэй боловч шууд хуулбарлана гэхэд мэдээж хэрэг ахдана. Харин үйл ажиллагааных нь зарчим, санхүүжих эх үүсвэрийг нь судалж, өөрийн нөхцөлд тохируулан үндэсний хувилбарыг боловсруулах боломж бол бий. Бид ч бас хөтөлбөрөө боловсруулах явцдаа Германы ЦДФ, Өмнөд Солонгосын Кей–Би–Си, Английн “Би–Би–Си”, Японы “Эн–Эйч–Кей” зэрэг гадаадын хэд хэдэн орны бүтэц, зохион байгуулалтыг судалсан. Аль ч олон нийтийн телевиз нийтлэг, зарчмууд байдаг. 1–рт, олон нийтийн телевизийн оршин тогтнох статусыг баталгаажуулсан хууль, эрхийн акт байдаг байна. 2–рт, олон нийтийн телевизийн санхүүжилтийн асуудал, 3–рт олон нийтийн телевизийн өмчийн статус тухай, 4–рт, удирдлагын хараат бус байдал, зохион байгуулалт, 5–рт программын бодлогын бие даасан хараат бус байдлыг хангах.

Ингээд, Японы олон нийтийн телевизийн “Эн–Эйч–Кей” корпораци, Их Британий олон нийтийн “Би–Би–Си”–ээс жишээ авъя.

1.Хууль эрхийн акт

“Би–Би–Си” олон нийтийн корпораци нь анх 1922 онд “Би–Би–Си” компани нэртэй байгуулагдаж, 1927 онд Эзэн хааны Харти гэдэг, хуультай дүйцэхүйц баримт бичгээр байгуулагдсан юм. “Би–Би–Си”–ийн үйл ажиллагааг баталгаажуулсан 2 үндсэн хууль байдаг юм байна. 1–рт Эзэн хааны Харти, Одоогийн мөрдөж байгаа Харти–г 1981 онд 15 жилийн хугацаатай баталж, “Би–Би–Си”–г хуулийн этгээд болохыг нь баталгаажуулж, үндсэн эрх, үүрэг зорилтыг нь тодорхойлж өгчээ.

2 дахь баримт бичиг нь корпораци, Их Британий Харилцаа холбооны яам хоёрын хооронд байгуулсан “Зөвшөөрөл ба гэрээ” гэдэг баримт бичиг байдаг байна. Үүнд “Би–Би–Си”–гийн радио, телевизийн нэвтрүүлгээ цацах хүрээ, нөхцөл, сонсогч, үзэгчдээс төлбөр хураамж авах эрх болон программтай холбоотой чухал заалтуудыг оруулжээ.

“Эн-Эйч-Кей” 1950 онд хүчин төгөлдөр болсон “Нэвтрүүлгийн хууль” гэдэг баримт бичигтэй байдаг юм байна. Хууль эрхийн энэ актаар “Эн-Эйч-Кей” бол Япон улсад цорын ганц олон нийтийн телевизийн корпораци” гэж заасан байна. Нэвтрүүлгийн хуулинд арилжааны болоод хувийн бусад хэлбэрийн телевизүүд байж болохыг ч зааж, хуулийн олон нийтийн корпораци тодорхойлсон. “Эн-Эйч-Кей” хараат бус үйл ажиллагааг хангах, бүтэц, зохион байгуулалтыг батлах, олон нийтийн ашиг сонирхлыг өндөр түвшинд хангах, программын хараат бус бие даасан байдлыг хангах” гэсэн байна.

2-рт, санхүүжилтийн асуудал.

Английн “Зөвшөөрөл болон Гэрээ” гэдэг баримт бичигт “Би-Би-Си” нь орлогын хоёр эх үүсвэртэй” гэж заасан байна. 1-рт, үзэгч сонсогчдын зөвшөөрлийн хураамж юм, 2-рт, гадаадын сонсогчдод зориулсан нэвтрүүлгийн төсвийг төрийн хуримтлалын татвар төлөгчдийн сангаас олгоно.

Эзэн хааны Хартийн 16-р зүйлд “Их Британий парламентаас хөрөнгө хуваарилсан нөхцөлд энэхүү Хартид заасан зорилтыг хэрэгжүүлэх үүднээс олон нийтийн корпораци нь түүнийг хүлээн авч, захиран зарцуулах эрхтэй” гэжээ. Мөн олон нийтэд үйлчилснээс төлбөр буюу бусад орлогыг “Би-Би-Си” өөрөө олж болно, түүнийгээ захиран зарцуулж болно” гэж заажээ.

Англид 1992 оны байдлаар нийтдээ 19,6 сая телевизор байсан нь одоо нэмэгдсэн биз. Сардаа дунджаар нэг үзэгч радио, телевизийн 77 фунт стерлинг хураамжинд төлдөг байна. Тэгэхдээ хар цагаан, өнгөт телевизийн хураамж ялгаатай. 1990-1991 онд “Би-Би-Си”-гийн нийт ашиг нь 1 миллиард 375,8 сая фунт стерлингтэй тэнцсэн байж.

“Эн-Эйч-Кей”-н хувьд санхүүжилтийн нь үндсэн эх үүсвэр нь бас сонсогч, үзэгчдийн төлбөр байдаг байна. Тэгэхдээ “Би-Би-Си” үүнийг “Зөвшөөрлийн хураамж” гэдэг бол “Эн-Эйч-Кей” нэвтрүүлэг хүлээн авах хураамж” гэж нэрлэдэг ажээ. 1993 оны байдлаар “Эн-Эйч-Кей” –н орлого 15 миллиард иен байсан ба гагцхүү далайн чанад дахь богино долгионы радио станцуудын зардалд зориулан улсаас дотаци авдаг. Энэ нь “Эн-Эйч-Кей”-ийн жилийн төсвийн 0,3 хувьтай тэнцдэг байна. Телевизийн хувьд “бусад” орлого гэдэг нь программ худалдаа төрөл бүрийн үйлчилгээнээс орох орлого юм. “Үйлчилгээ” гэдэг нь нэвтрүүлгийнхээ хөтөлбөрийг худалдахаас эхлээд зах зээлийн үед боломжтой бүх төрлийн хөрөнгө олох арга ажээ. Өмчийн хувьд энэ хоёр хоёулаа өөрийн өмчтэй, түүнээ захиран зарцуулах эрхтэй. Олон сая үзэгчтэй телевизор эзэмшигчтэй орнуудын олон нийтийн телевизийн орлого нь мэдээж өөрийгөө санхүүжүүлэх, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжөө худалдан авах шинэчлэх хүмүүсээ цалинжуулах гээд бүх зардлаа нөхөхөд хангалттай.

Дараагийн гол зарчим удирдлага, зохион байгуулалтын асуудал юм. “Би-Би-Си” –г 12 гишүүнтэй удирдлагын зөвлөл нь удирдана. Хатан хааны Консулын газар, засгийн газартайгаа зөвлөлдөж гишүүдийг томилдог юм байна. Ерөнхий захирал, бусад захирлыг 5 жилийн хугацаатай зөвлөлөөс томилно. “Би-Би-Си”-ийн өдөр тутмын дотоод үйл ажиллагаа программ, редакцийн болон удирдлагын хараат бус бие даасан байдлыг энэ Хартидаа баталгаажуулсан байна. Удирдлагын зөвлөлийн гишүүд гэдэг нь телевизийн программыг улс төрийн дарамт нөлөөнөөс ангид, бие даасан бодлого хэрэгжүүлэх үүрэгтэй ажээ. Дээр нь “олон нийтийн сонирхол, эрх ашгийг хамгаалах үндсэн үүрэгтэй” гэж заажээ.

“Эн-Эйч-Кей” ч мөн 12 гишүүнтэй удирдлагын зөвлөлтэй. Харин гишүүдийг нь Ерөнхий сайд, парламентын 2 танхимаас нэр дэвшүүлж томилдог юм байна. Удирдлага дэргэдээ зөвлөхүүдийг ажиллуулна. Үүнийг “Би-Би-Си”-д төв “Зөвлөх төв консул ба хороо” гэнэ. Харин “Эн-Эйч-Кей”-д “нэвтрүүлгийн программын зөвлөх төв хороо” гэдэг ажээ. Эдний хувьд 123 гишүүнтэй, бүрэлдхүүнд нь мэргэжлийн хүмүүсээс гадна спорт, боловсрол, хэрэглэгчдийн нийгэмлэг гээд олон салбарыг хамарсан төлөөлөгчид ордог байна.

Олон нийтийн телевиз нь үзэгчдийн хэрэгцээ, сонирхлыг хангахын тулд нэвтрүүлгээ чанарын өндөр түвшинд бэлтгэх үүрэгтэй. Үүнд нь зөвлөлийн гишүүд тусалдаг,

Тав дахь гол зарчим бол программын хараат бус байдал.

Дээрхи хоёр корпораци аль аль нь программынхаа бодлогыг өөрсдөө биеэ дааж боловсруулдаг. Программд тавигдах гол шаардлага нь уран бүтээлийн чанар, үзэгчдийн эрх ашиг хэмээх хоёр зүйл байдаг. Дээр дурьдсан Харти болон Нэвтрүүлгийн хуульд нэвтрүүлэгт тавигдах шаардлагуудыг тодорхой тусгажээ. Японы “Нэвтрүүлгийн хуулийн 3-р зүйлд: “хуулиар олгогдсон эрх бүхий этгээдээс өөр хэн ч нэвтрүүлгийн хэрэгт оролцох, зохицуулах эрхгүй” гэж заасан. Мөн “Программыг төлөвлөхдөө, олон нийтийн аюулгүй байдал, өндөр ёс суртахуун, нийтэд түгшүүр төрүүлэхгүй байх зарчмыг баримтлахыг чухалчилжээ. Тэгээд улс төрийн талаар алагчлахгүй, тал тохой татахгүй байх, мэдээг дамжуулахдаа баримтыг гуйвуулахгүй байх, маргаантай асуудлын хувьд аль болох янз бүрийн үзэл бодлыг илэрхийлж байх ёстой” гэжээ.

Мөн соёл, боловсролын болон мэдээ, цэнгээнт нэвтрүүлгийн хэм хэмжээг тохируулах, сургалт танин мэдэхүйн нэвтрүүлгийн системтэй байдлыг хангах, сургалтын нэвтрүүлгийг боловсролын хуулийн зохицуулалттай холбоотойгоор нэлээн өндөр түвшинд хүрсэн байх ёстой” гэх зэргийг шаардлага болгон заажээ.

“Би–Би–Си”–гийн үүрэгт, олон нийтийн болон нийгмийн дунд маргаантай асуудлаар “Би–Би–Си” өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, редакторлох явдлаас зайлсхийх” гэсэн заалт байна. Энэ нь олон ургальч үзлийг хүндэтгэсэн туйлын чухал заалт юм. Өөр нэгэн сонирхолтой заалт байгаа нь Хартид “парламентын сурвалжлагыг гагцхүү мэргэжлийн сурвалжлагч хийнэ” гэжээ.

Өнөөдөр олон нийтийн телевизийн сонгодог хэлбэр гэж байхгүй. Ихэнх телевиз “Би–Би–Си”–гийн ерөнхий загварыг авч хэрэглэдэг. Улс бүрт сэтгүүлчид, сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд нь олон нийтийн телевизийнхээ бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох янз бүрийн эрэл хайгуулыг хийдэг.

Чухам манай орны хувьд энэ телевизийг байгуулахад ямар боломж байгаа, ямархуу байх вэ гэдэг дээр төсөөсөл хэлье.

1.Нэр томъёоны хувьд Монголын Үндэсний телевиз гэж байвал зүгээр юм уу. “Олон нийтийн” гэсэн нэр томъёог авч хэрэглэвэл мэдээж “Засгийн газрын бус” гэсэн утга илэрхийлж байгаа боловч бидний нэрлэж заншсанаар ҮЭ–ийн ч юмуу, олон нийтийн байгууллагын телевиз шиг ойлгогдож магадгүй тул нийт үндэснийхээ эрх ашгийг хамгаалсан гэдэг утгаараа “үндэсний телевиз” гэсэн нь зүйтэй болов уу.

2–рт, “төв” гэсний учир нь өнөөдөр манай Монгол телевизийн адил уран бүтээлийн үйлдвэрлэл явуулдаг, нэвтрүүлгээ дамжуулж цацдаг 2-3 телевиз бий болжээ.

Тэдгээрээс ялгахын тулд нөгөөтэйгүүр нэвтрүүлэг цацах хүрээ, хүртээмжийн хувьд “төв” гэсэн тодотгол хэрэгтэй санагдана.

2.Өнөөдөр МРТХЭГазар нь Засгийн газрын хуулиар зохицуулагдсан, Засгийн газрын үндсэн бүтцэд багтдаг байгууллага. Тэгэхээр, олон нийтийн байгууллагын хуулийн этгээдийн статусыг одоо гарах гэж байгаа хэвлэлийнхээ хуулиар баталгаажуулж өгөх байх гэж бодож байна. Энэ хуульд олон нийтийн телевизийн тодорхойлолтыг зайлшгүй тусгах хэрэгтэй болов уу. Монголд өөрөө өмчөө эзэмших, захиран зарцуулах эрх бүхий өөрийгөө удирдах зарчимд тулгуурласан хуулийн этгээдийн хэлбэрийг тусгасан хууль шаардлагатай. Ингэвэл одоогийн РТХЭГ, Засгийн Газар хоёр олон нийтийн телевизийг үүсгэн байгуулж болох биш үү. Байр, хөрөнгө, техникийг нь өөрт нь хандив хэлбэрээр өгч болно. Монгол телевизийн

одоогийн техник, төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгийг ч хандивлаж болно. Эцсийн эцэст, улсын төсвийн үлэмж хэсгийг татвар төлөгчид нугалж буй.

Хамгийн гол нь Засгийн газар үүнийг санаачилж, “олон нийтийн” телевиз гэсэн төсөл боловсруулж тодорхой хугацаанд хэрэгжүүлэх нь зүйтэй. Энэ шилжилтийг сайтар бодож, ухаалаг хэрэгжих механизмыг нь шийдэхгүй бол хожим хойно нөхөж баршгүй сөрөг үр дагавар гарч мэднэ.

2. Санхүүжилтийн асуудал .

Хамгийн бэрх ярвигтай мэт боловч хялбархан шийдвэрлэж болмоор.

1994 оны байдлаар манайд 130000 гаруй телевизор бий гэсэн тоо байдаг. Гэвч Монголын өргөн нутаг тархай бутархай суудаг, дээр нь банк, шуудан холбооны салбар шаардлагын түвшинд хүрээгүй үед телевизор эзэмшигчдээс хураамж бүрэн олж авна гэдэг туйлын хэцүү нь мэдээж. Гэвч түүнийг ямар нэг аргаар олж авах хэрэгтэй. Нөгөөтэйгүүр, үзэгчид өөрсдийнх нь нэвтрүүлгийг нь хүлээн авч үзсэнийхээ төлөө мөнгө төлдөг зарчим уран бүтээлчдийн сэтгэхүйд бодитой нөлөө үзүүлж, чанартай, сайн нэвтрүүлэг бэлтгэх хүчин зүйл болж мэднэ. Бас үүнд өөр нэг ашиг бий. Нэгэнт мөнгөө төлж буй иргэн хэн байлаа ч, өөрийнхөө оюуны хэрэгцээ, шаардлагыг хангахуйц үнэн бодит мэдээлэл, мэдлэг, боловсрол дээшлүүлж, чөлөөт цагаа зугаатай өнгөрүүлэхэд нь тусгай сургалтын болон цэнгээнт нэвтрүүлгийг чанарын өндөр түвшинд шаардах болно. Тэгвэл бид эхний ээлжинд татвар хураамжаас зөвхөн цалин шагналаа олгодог болж болно шүү дээ. Үгүй бол өөр нэг вариант байж болох юм. Програмын хараат бус бодлого гэдэг нь угтаа одоо манай телевизийн нийт хөтөлбөрт 30 гаруй хувийг эзэлдэг, мэдээлэл улс төрийн нэвтрүүлгийн тухай асуудал юм. Тэгвэл бид телевизийн мэдээллийн ашиглалтийг эдийн засгийн бие даасан байдалд оруулж, татвар хураамжаас санхүүжүүлж болно. Цаана нь үлдэх хүүхэд, залуучууд, спорт, урлаг, уран сайхны нэвтрүүлэг нэг ёсондоо төр, засгийн бодлогын салшгүй хэсэг тул улсын ивээлд байхад буруудах зүйлгүй. Бид өнөөдөр ард түмнийхээ өөрсдийнх нь сонгосон хөгжлийн замаар замнаж яваа тул олон нийтийг бодитой, чөлөөт мэдээллээр хангахыг л эрмэлзэх ёстой. ОНТВ нь “холимог санхүүжилттэй” байж болно. Ер нь ч ийм нэр томъёо олон нийтийн телевизийн практикт байдаг энэ нь:

1. Телевизор эзэмшигчдийн төлбөр / хураамж/
2. Улсын хандив / төсөв гэхээ больё/
3. Бусад

Энэ нь тодорхой хэмжээний реклам, сурталчилгаа, программ худалдаа, үйлчилгээний бүх хэлбэрээс олох орлого байж болно. Цаашдаа улсын хандивын хэмжээг багасгах бодлого барьж, зөвхөн улс орны болон дэлхий нийтийн тухайлбал, наадам, олимп болон Азийн тоглолт, дэлхийн аваргын уралдаан тэмцээн, төрийн тэргүүнүүдийн айлчлал зэрэг томоохон арга хэмжээг сурталчилахад улс тодорхой хэмжээгээр ивээн тэтгэх болно.

3. Удирдлага, зохион байгуулалт

ОНТВ–ийн удирдах дээд байгууллага нь нийт олон үзэгчдийг төлөөлсөн Үндэсний эсвэл хараат бус зөвлөл ч юмуу байж болно. Үүнийг ямар ч хэлбэрээр, хэдэн ч хүнтэй байгуулж болох биз. Ямар хугацаанд, яаж, хэн томилогдох, эсвэл нэр дэвшүүлэх, яаж ажиллах, хэн батлах зэргийг нарийн боловсруулах хэрэгтэй байх. Харин анхаарах зүйл нь энэ зөвлөлийг аль болох улс төрөөс холхон байлгахыг эрмэлзэх, болж өгвөл мэргэжлийн хүмүүсээс бүрдүүлбэл зүгээр. Дашрамд хэлэхэд энэ тухай америкийн нэг зөвлөхийн хуулийн төсөлд бас дурдсан буй.

Энэ зөвлөл нь ОНТВ–ийн удирдлагыг ардчиллын үндсэн дээр хэлэлцэж, сонгох бөгөөд хугацаа нь УИХ–ын сонгуультай давхцахгүй байх нь зүйтэй.

Ингээд гол зүйлийг базаж хэлбэл, өөрийгөө удирдах зарчимд тулгуурлан өөрөө өмчөө эзэмшиж, захиран зарцуулах эрх бүхий, өөрийгөө санхүүжүүлэх чадвартай ОНТВ–ийг хүсвэл Монголд байгуулах боломж бүрэн бий.

Эцэст нь хэлэхэд, бидэнд зоримог санаачилга, шийдвэртэй алхам хэрэгтэй. Ямар ч атугай ардчилсан нийгмийн ард түмний жинхэнэ индэр болж чадахуйц жинхэнэ Монгол телевиз манайд хэрэгтэй.

Ардчилал хөгжиж, гүнзгийрэхийн хэрээр олон нийт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж нийгмийн шударга ёсны төлөө хамтран тэмцдэг жамтай. Энэ тэмцэлд сэтгүүлчид манлайлж, худал, үнэний тухай бодитой мэдээллийг төр засгийнхаа ч түмэн олныхоо ч сонорт хүргэж, тэдний хоорондох жинхэнэ гүүр нь болох ёстой билээ.



М.Мөнхмандах (Доктор)

Олон нийтийн телевизийн тодорхойлолт Монголын радио телевизийн тухай хууль дүрмийн төсөлд

Олон нийтийн телевизийн тухай ойлголт нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдөж байна. Баруун Европын ихэнх оронд телевизийн нэвтрүүлэг өргөн олны хүртээл болж эхлэх тэр үеэс л төрийн зүгээс, телевиз бол олон нийтийн статустай байх ёстой гэсэн бодлого баримталж ирсэн. Энэхүү бодлого нь дараах үзэл баримтлалаас үүдэж байв :

1. Телевиз бол сонин хэвлэлийг бодвол хувь хүн, нийгмийн оюун санаанд илүү хүчтэй нөлөөлөх чадвартай. Иймээс энэхүү хүчтэй зэвсгийг хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхлоос ангид байлгаж, нийгмийн эрх ашигт нийцүүлэн ашиглах хэрэгтэй.
2. Телевиз бол юуны өмнө гэгээрүүлэх, соён гийгүүлэх үүрэгтэй, телевизийн үйл ажиллагаа нь эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байх ёстой.
3. Телевизийн нэвтрүүлэг дамжуулах техникийн боломж, тухайлбал долгионы хуваарилалт хязгаарлагдмал учир, байгаа долгионыг ашиглан нэвтрүүлэг явуулах эрх бүхий этгээд хувийн ашиг сонирхолд бус олон нийтэд үйлчлэх үүрэг хүлээх ёстой.

Иймээс Америкийг эс тооцвол, өндөр хөгжилтэй ихэнх оронд телевиз анх үүсч хөгжихдөө олон нийтийн статустай, өөрөөр хэлбэл хувь хүний болон улс төр, эдийн засгийн аливаа өрөөсгөл сонирхолд бус, нийгмийн бүх гишүүдэд адил тэгш үйлчлэх үүрэг хүлээсэн, энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бие даасан байдлыг нь төрийн зүгээс зохицуулан баталгаажуулсан байв. Гэтэл мэдээллийн технолог хурдацтай хөгжиж, кабель, сателлитаар нэвтрүүлэг дамжуулах боломж бий болж, арилжааны телевиз

төлөвшин зах зээлийн өрсөлдөөн ширүүссэнээр мэдээллийн орчин өөрчлөгдөж, олон нийтийн телевизийн эдийн засгийн баталгаа, нийгэмд эзлэх байр суурь ч өөрчлөгдөж эхэлсэн билээ. Эдүгээ олон нийтийн телевиз арилжааны телевизтэй үзэгч олноо "хуваалцаж", илүү олон хэрэглэгчийн анхаарлыг татан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд зах зээлийн өрсөлдөөнд оролцох шаардлагатай тулгарч байна. Телевиз бол боловсрол соёл шинжлэх ухааныг түгээгч байгууллага байхын тулд, мөн ийм үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээгээр эдийн засгийн ашигтай үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлагатай юм гэсэн ойлголт бий болов. Арилжааны телевизтэй зэрэгцэн оршиж буй олон нийтийн телевиз зах зээлийн өрсөлдөөнөөс ангид байх боломжгүй, үзэгч олныг байлдан дагуулахын тулд тэдний илүү сонирхож үздэг нэвтрүүлгийг явуулах шаардлагатай юм гэдгийг судлаач, олон нийтийн телевизийн удирдагчид ойлгож мэдэрч эхлэв. Гэвч нөгөө талаар олон нийтийн телевиз ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хувийн телевизээс ялгаатай байх ёстой, ингэхийн тулд зах зээлийн зарчимд бүрэн захирагдах бус, харин нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж, зугаа цэнгээний хэрэгсэл байхаас гадна олон ургальч мэдээллийн индэр, соёл боловсролыг түгээгч байх ёстой гэсэн үзэл хүчтэй хэвээр байна. Энэхүү зөрчилтэй байдал нь олон нийтийн телевизийн тухай болон түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн тухай ойлголт өөрчлөгдөхөд хүргэж байгаа билээ. Ийнхүү олон нийтийн телевиз анх үүсч бий болж байсан цаг нөхцөл, нийгэм, эдийн засаг, техник технологийн орчин өөр болсны улмаас олон нийтийн телевиз өөрөө ч өөрчлөгдөж буй тул эдүгээ "олон нийтийн телевиз" гэж яг юу болохыг тодорхойлох нь бэрхшээлтэй болоод байгаа билээ. Харин олон нийтийн телевизийн тухай баруун Европын улс оронд түгээмэл байдаг уламжлалт ойлголт, туршлагад үндэслэн, дараах нийтлэг гурван зарчмыг онцлон дурьдаж болно:

1. Нийтлэг хүртээмжтэй буюу универсал байх зарчим: олон нийтийн телевиз хүртээмж тархалтын хувьд болон нэвтрүүлгийн зориулалтын хувьд бүх нийтийг хамарна. Өөрөөр хэлбэл газар нутгийн байршлаас шалтгаалан олон нийтийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах хэн нэгний буюу хэсэг бүлэг хүмүүсийн эрх хязгаарлагдах учиргүй. Нөгөө талаар олон нийтийн телевизийн нэвтрүүлэг тухайн нийгмийн аливаа давхарга, сонирхлын бүлгийг ялгаварлан гадуурхахгүй, төрөл хэлбэр, утга агуулгаараа тухайн улсад амьдарч буй ямар ч нас, хүйс, шашин, үндэстэн ястны хэрэгцээг ижил тэгш хангахыг зорино.
2. Энэхүү универсал байх зарчим нь олон ургальч байх зарчимтай нягт уялдаатай. Олон ургальч байх зарчим нь өргөн утгаараа дор хаяж гурван санааг агуулна: **нэгдүгээрт** нэвтрүүлгийн олон хэлбэр (мэдээ, мэдээллийн хөтөлбөрөөс эхсүүлээд соёл боловсрол шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон урлаг уран сайхны болон хөгжөөнт нэвтрүүлэг), **хоёрдугаарт** нэвтрүүлгээ зориулан хандаж буй үзэгчдийн олон давхарга, хэсэг бүлэг (хүүхэд, залуучууд, өндөр настан, улс төр, эдийн засгийн сонирхлын янз бүрийн бүлэглэл г.м.), **гуравдугаарт** нэвтрүүлэгтээ хөндөж буй олон янзын сэдэв, утга агуулгын өргөн хүрээ (нийгэм, улс төр, эдийн засгийн тулгамдсан асуудал, түүх соёл, уламжлал). Олон нийтийн телевизийн тулгуур зарчим бол хувийн болон улс төрийн сонирхлоос хараатбус байх явдал. Олон талт, нийгмийн бүхий л давхарга, сонирхлын бүлгийн хэрэгцээг харгалзсан нэвтрүүлгийн бодлого явуулахын тулд олон нийтийн телевиз зайлшгүй бие даасан, хараат бус байх ёстой. Тийм ч учраас энэхүү хараат бус байх зарчим нь дээр дурьдсан хоёр зарчмыг биелүүлэх урьдчилсан нөхцөл болно. Улс төр, эдийн засгийн сонирхлоос хараат бус байна гэдэг нь, сайн чанартай нэвтрүүлэг бэлтгэхээс өөр ямарваа нэгэн далд зорилго, санаа агуулахгүй, өөрөөр хэлбэл нэвтрүүлгээ улс төр, эдийн засгийн сонирхлын аль нэг хэсэг бүлгийн таашаалд нийцүүлэх бодлогоос ангид байхыг

хэлнэ.

Эдгээр гурван зарчим нь олон нийтийн телевизийн тухай ойлголтыг бүрэн дүүрэн тусгаж чадахгүй хэдий ч, дэлхийн олон орны олон нийтийн телевизийн тухай хууль дүрэмд ямар нэг хэлбэрээр тусгагдсан байдаг, үндсэн шинж чанарыг агуулж байгаа юм. Ингээд энд дурдсан олон нийтийн телевизийг тодорхойлох гурван зарчим Монголд олон нийтийн телевизийг хөгжүүлэх санал, бодлогын чанартай бичиг баримт, хуулийн төсөлд хэрхэн хөндөгдөж байсныг сонирхоё.

УИХ-аас 1998 оны найдугаар сард баталсан Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд Радио Телевизийн хэрэг эрхлэх газрыг татан буулгаж, Монголын Радио, телевизийн (мөн аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дэргэдэх радио телевизийн) статусыг “үндэсний нийтийн” болгож өөрчлөхөөр баталсан билээ. Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн хэрэгжилт ихээхэн маргаан дэгдээснээс гадна, Радио Телевизийг хэрхэн олон нийтийн статустай болгож өөрчлөх тухай хууль тогтоол өдийг хүртэл гараагүй байгааг бид бүгд мэдэж байгаа. Гэсэн хэдий ч, энэхүү хууль нь Монголын хэвлэл мэдээллийн системд хувийн болон олон нийтийн статустай хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэгцэн оршихыг хүлээн зөвшөөрч, хуульчлан баталснаас гадна, төрийн мэдээллийн монополийг устгах чиглэлд чухал алхам хийж, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай маргааныг шинэ шатанд дэвшүүлсэн гэж хэлж болно.

Гагцхүү олон нийтийн телевизийг Монголд хэрхэн хөгжүүлэх тухай санаа дээрх хуультай шууд холбоотойгоор бий болсон гэвэл эндүүрэл болно. Аль 80-аад оны сүүл, 90-ээд оны эхээр нийгэм эдийн засгийн шинэчлэл, хүмүүсийн оюун санааны өөрчлөлтийг даган, хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай ойлголт өөрчлөгдөж эхэлсэн бөгөөд чухам энэ л өөрчлөлтийн явцад олон нийтийн радио телевизийн тухай санаа төрж, улам бүр баяжин ирсэн билээ. 1991 онд Монгол Телевизийн захирал асан З.Алтай Монгол Телевизийн бүтэц, зохион байгуулалт, программын бодлогод өөрчлөлт оруулах хөтөлбөр боловсруулж, тухайн үеийн баазад тулгуурлан олон нийтийн болон төрийн статустай хоёр өөр төрлийн телевизтэй болохыг санал болгож байжээ. Харамсалтай нь энэ санал төр засгийн зүгээс дэмжлэг аваагүй тэгсхийгээд замхрав. 1994 онд Монгол Телевизийн хэсэг уран бүтээлчид Монгол Телевизийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх тухай төсөл боловсруулан Засгийн газар, Радио Телевизийн Хэрэг Эрхлэх Газарт өргөн барьсан байна. Уг төсөлд тухайлбал олон нийтийн телевизийн зохион байгуулалт, программын бүтэц, удирдах байгууллагын үйл ажиллагааны зарчим, дүрмийг тодорхойлсноос гадна, яагаад ийм өөрчлөлт шаардлагатай байгааг ч тайлбарласан аж. Хэдийгээр дээр дурдсан уран бүтээлчдийн энэхүү шаардлагын тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэлээд шуугиж байсан боловч төрийн зүгээс ямар нэгэн дэмжлэг бас л гарсангүй.

Монгол Телевизийг өөрчлөн шинэчлэх тухай дээр дурдсан болон бусад санал, төслийн талаар сонин хэвлэлийн хуудаснаа хэлэлцэж, радио телевизийн шинэчлэл, тэр дундаа олон нийтийн телевизийн тухай уулзалт, сургалт, зөвлөлгөөн нэлээдгүй зохион явуулж, гадаадын мэргэжилтнүүдээс цөөн бус удаа зөвлөлгөө авсан боловч олон нийтийн радио телевизийн тухай хууль эрх зүйн зохицуулалт өдийг хүртэл төрөөгүй байгаа нь электрон мэдээллийн салбарт, тэр дундаа юун түрүүнд радио телевизийн салбарт төрийн монополийг устгах тууштай бодлого төрийн хэмжээнд үгүйлэгдсэнийх болов уу. Ардчилсан нийгмийн тогтолцоог бий болгохыг зорьж өнгөрсөн арваад жилийн хугацаанд олон нийтийн телевизийг ямар нэг хэлбэрээр хөндсөн хууль дүрмийн арваад төсөл хэвлэл мэдээллийн удирдах ажилтан, судлаач, улс төрчдийн гарт очсон байна. Эдгээрийн ихэнх нь харьцангуй бие даасан, нэг нь нөгөөхөөсөө

хамааралгүйгээр, зарим тохиолдолд давхцан гарч байснаас гадна, зарим нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр олны хүртээл болсон хэдий ч зарим нь олон нийтийн анхааралд өртөлгүй замхарсан аж. Олон нийтийн телевизийн тухай ярьж, бичиж эхэлснээс хойш өнгөрсөн хугацаа, энэ хугацаанд гарсан олон санал, төслийг бодоход, ямартай ч эдгээр баримт бичиг Монгол Улсад олон нийтийн телевизийн тухай ойлголт бүрэлдэн тогтоход тодорхой хувь нэмэр оруулсан болов уу хэмээн найдлага төрнө.

Ингээд эдгээр хууль, дурмийн төслүүдэд дээр дурдсан, олон нийтийн телевизийн мөн чанарыг тодорхойлох гурван зарчим хэрхэн тусгагдсаныг сонирхоё.

1990-ээд оны эхэн үед эрх чөлөөт хараат бус радио хөгжүүлэх зорилго бүхий, хуулийн хэмжээнд боловсруулсан анхны гэж хэлж болох төслийг 1994 онд Монгол оронд айлчилсан АНУ-ын зөвлөх ноён Роберт Мулхолланд боловсруулжээ. Энэхүү хуулийн төслийн дагуу, Монгол Улсад хувийн радио телевизээс гадна "Үндэсний Радио" болон "Үндэсний Телевиз" үйл ажиллагаа явуулна. Үндэсний радио телевиз нь санхүүжилтийнхээ "үндсэн хэсгийг" төрөөс авах боловч нэвтрүүлгийнх нь бодлогыг төр засгаас хараат бус "Радио телевизийн захиргаа" боловсруулна. Энэхүү хараат бус "Радио Телевизийн Захиргааны" долоон гишүүний гурвыг нь УИХ, дөрвийг нь Ерөнхийлөгч батлах боловч, уг "захиргаанд" төрийн албаны хүн сонгогдох эрхгүй. Төслийн нэг онцлог нь, "мэдээлэл, соёл, боловсрол, зугаа цэнгээний талаархи нийт үндэсний эрэлт хэрэгцээг үндэсний хэмжээнд хангах", "олон ургальч үзлийн зарчмыг баримтлах", "улс төрийн намуудад үзэл бодлоо илэрхийлэхэд нь ижил боломж олгох" гэх мэт ихэвчлэн олон нийтийн телевизэд оноосон байдаг үүргийг хувийн болон Үндэсний радио телевизэд аль алинд нь "даалгажээ". Уг төсөлд олон нийтийн телевизийн үндсэн зарчмуудыг (хараат бус байх, олон ургальч байх, хүртээмжтэй байх) бараг бүрэн тодорхойлсон мэт боловч, нэгдүгээрт, олон нийтийн болон арилжааны радио телевизийн зааг ялгааг тодорхойлоогүй, харин ч аль алиных нь үүргийг адилтгаж, ингэснээрээ олон нийтийн телевизийн тухай ойлголтыг бүрхэгдүүлэн орхисон аж. Олон нийтийн болон хувийн радио телевизийн тухай ойлголт тодорхой бус байна гэдэг нь, арилжааны телевиз олон нийтийнхтэй нэгэн адил, нэвтрүүлгийн тодорхой бодлого баримтлах үүрэг хуулийн дагуу хүлээдэг бол, тэд яагаад олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй адил төрөөс татаас авч болдоггүй юм бэ гэх мэт наад захын маргаан дэгдэхэд хүргэж болно. Нөгөө талаар хараат бус үйл ажиллагаа явуулахад улс төрийн хүчнээс хараат бус байх нь хангалтгүйг төсөл санаачлагч үл анзаарсан бололтой. Гэтэл нийгэм, нийт үндэсний эрх ашигт үйлчилдэг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан хараат бус байдалд улс төрийн нөлөөллөөс гадна эдийн засгийн ашиг сонирхол хамгаас аюултай гэдгийг олон нийтийн телевизтэй улс орны туршлага хэдэнтээ нотолсон билээ.

1995 онд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай асуудлыг хөндсөн хуулийн хоёр төсөл олны анхаарлыг татсан билээ. Үүний нэгийг Монгол Улсын ерөнхийлөгч асан П.Очирбат, нөгөөхийг нь УИХ-ын гишүүн Т.Ганди боловсруулсан юм.

П.Очирбатын боловсруулсан хуулийн төслийн дагуу Монголын Үндэсний радио, телевиз олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үүргийг гүйцэтгэж, мэдээлэх, танин мэдүүлэх, соёл боловсрол зугаа цэнгээний хэрэгцээг хангах, олон ургальч үзлийг баримталж, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй. Гэвч уг төсөлд олон нийтийн мэдээллийн хэрэгслийн амин чухал зарчим болох хараат бус бие даасан байдлыг үйл ажиллагааны үндсэн нөхцөл хэмээн заалгүй орхигдуулжээ. Хэдийгээр төсөлд Үндэсний Радио Телевизийн Зөвлөл нь радио телевизийн бие даасан хараат бус байдлыг баталгаажуулах үүрэгтэй хэмээн заасан байгаа боловч энэхүү хараат бус байдал нь олон нийтийн телевизийг хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээс ялгах үндсэн зарчим бус, харин өмнөх төслийн адил, Монголд үйл ажиллагаа явуулж буй бүх радио телевизэд хамаатай ерөнхий заалт аж.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах зорилго бүхий Т.Гандигийн боловсруулсан хуулийн төсөлд радио телевизийн талаар цөөн хэдэн заалт оржээ. Үүнд, Монгол Улсад төрийн, олон нийтийн болон хувийн телевиз үйл ажиллагаа явуулж болно хэмээн заасан боловч эдгээрийн зарчим, үйл ажиллагааны онцлогийг тодорхойлоогүй боловч мэдээллийн хэрэгслүүд төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай шуурхай мэдээлж байх үүрэгтэйг онцлон дурдсан нь анхаарал татаж байна.

1996 онд Монгол телевизийн захирал асан Х.Наранжаргал "Монголын үндэсний радио телевизийн дүрмийн үндсэн зарчмууд" хэмээх төсөл боловсруулжээ. Уг төсөлд зөвхөн Монголын үндэсний радио телевизийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг хэрхэн зохицуулах талаар зөвлөмжийн чанартай заалтууд орсон бөгөөд бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг хөндөөгүй байна. Төслийн дагуу, Монголын Үндэсний Радио Телевиз нь "хараат бус удирдлагын зөвлөлтэй, өөрөө өмчөө эзэмшин захирдаг, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн". Монголын Үндэсний Радио Телевиз нь улс төрийн хүчин, нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхлоос ангид байж, нэвтрүүлгийн бие даасан бодлого явуулна. Радио телевизийн нэвтрүүлэг нь олон ургальч үзлийг баримталж, янз бүрийн үзэл бодлыг илэрхийлж байх, үзэгчдийн эрх ашгийг дээдэлж, уран бүтээлийн чанарыг эрхэмлэнэ. Хэдийгээр энэ төсөлд "олон нийтийн телевиз" гэсэн нэр, томъёолол ороогүй ч, олон нийтийн телевизийн онцлог, үндсэн шинж чанарыг тодорхойлох дээр дурдсан гурван зарчим, юуны түрүүнд бие даасан, өрөөсгөл ашиг сонирхлоос хараат бус байдал, олон ургальч үзлийг баримтлах зарчим үндсэндээ тусгагдсан байгаа юм. Харин нэвтрүүлгийн хүртээмж, төрөл, утга агуулгын тэнцвэрт байдал, өөрөөр хэлбэл нийт хөтөлбөр дэх мэдээлэл, танин мэдүүлэх болон хөгжөөнт нэвтрүүлгийн тэнцвэр зэргийг шаардлага болгон тавиагүй байна.

Х.Наранжаргалын болон үүнээс хойш гарсан төслүүдэд олон нийтийн радио телевизийн тухай концепц нэлээн тодорхой болж ирсэн боловч, урд өмнөх төслүүдийн алдаа дутагдал нь давтагдсан хэвээр.

1998 онд "Олон нийтийн телевиз" хэмээх тодорхойлолтыг "Монголын олон нийтийн радио телевиз төрийн бус байгууллагын дүрэм"-д анх удаагаа хэрэглэсэн байна. Үүнд, "олон нийтийн радио телевиз нь төрийн байгууллага, улс төрийн нам, эвсэл болон бусад хөндлөнгийн этгээдээс хараат бус, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг байгууллага". Нэвтрүүлгийн бодлогын хувьд, үзэгч сонсогчдын олон талт хэрэгцээ шаардлагыг хангахуйц сэдэв агуулгын олон ургальч байдалд төдийлөн ач холбогдол өгөөгүй, харин "иргэний нийгмийн хөгжилтэй холбогдолтой бүхий л мэдээ мэдээлэл, сурталчилгааг нийтэд шуурхай түгээх", "хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах болон шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх" үүргийг онцлон зааснаас үзэхэд, олон нийтийн телевизийг улс төрийн амьдрал, төр засгийн байгууллагын үйл ажиллагааг түлхүү мэдээлэх ёстой хэмээн үзэж байна уу гэлтэй. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг төдийлөн оновчтой тодорхойлоогүй боловч "төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг менежментийн удирдлагаар хангах", "төрийн бус байгууллагуудын хоорондын харилцааг хөгжүүлэх,...ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын хүсэлтийн дагуу сургалт семинар зохион явуулах" зэрэг тэс хөндлөнгийн гэж хэлж болох зарим заалт энэ төсөлд оржээ.

Олон нийтийн радио телевизийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлох гэсэн дараагийн оролдлого 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуультай шууд холбоотойгоор гарсан, магад тийм ч учраас зорилго, агуулга нь илүү тодорхой болсон байна.

1998 оны эхээр Д.Баттулга, Э.Бат-Үүл, Т.Ганди нарын УИХ-ын найман гишүүн анхлан боловсруулсан Монголын Үндэсний Радио Телевизийн дүрмийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, 1999 оны 4-р сард уг төслийг боловсруулсан ажлын хэсгийнхэн дүрмийн төслөө өөрчилж хуулийн төсөл болгон УИХ-д ахин өргөн барьжээ.

Уг хуулийн төсөлд олон нийтийн нэвтрүүлгийн бие даасан байдлын талаар: "Үндэсний радио, телевиз нь ашгийн төлөө бус, үндэсний нийтийн мэдээллийн хэрэгсэл болохын хувьд төрөөс санхүүждэг, ... үйл ажиллагаа нь төрөөс хараат бус" байна гэжээ. Нэвтрүүлгийн бодлого, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлохдоо, Үндэсний радио телевиз нь "улс оронд болон дэлхий дахинаа болж буй үйл явдлын талаар үнэн бодитой, шуурхай мэдээлж, сонсогч, үзэгчдийн оюуны болон танин мэдхүй, гоо сайхны хэрэгцээг хангахуйц, техник, уран сайхны шаардлагад нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх", "олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, нийт үндэсний эрх ашгийг дээдлэх, ... үндэсний өв уламжлал, соёл урлагийг сурталчилна" гэсэн байна. Ийнхүү олон нийтийн радио телевизийг бусад мэдээллийн хэрэгсэл, тухайлбал арилжааны радио телевизээс ялгах үндсэн гурван зарчмыг хуулийн төсөлд зарим талаар өнгөц дурдсан (жишээн нь бие даасан байдлын тухай), зарим талаар хэт нурун ерөнхийлсөн боловч гол ялгааг оновчтой тодорхойлоогүй (тухайлбал хөтөлбөрийн өргөн хүрээ, нийт үзэгчдийн нас, хүйс, нийгэмд эзлэх байр суурь, үзэл бодлыг харгалзан сонирхлын бүхий л бүлгийг хамарч, сэдэв, утга агуулга, хэлбэрийн олон талт нэвтрүүлэг явуулах, мэдээлэл, боловсролын болон хөгжөөнт нэвтрүүлгийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх зэрэг зарчмыг огт дурдаагүй). Гэсэн хэрнээ Үндэсний Радио, Телевиз нь төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийн нийтэд хүргэх ёстойг онцлон заасан нь хууль тогтоогчид мөн л радио телевизийг төрөөс салгаж үзэж чадахгүй байсаар байгаагийн шинж болов уу.

2000 оны парламентын сонгуулийн дараа төрийн байгууллагуудын бүтэц, бие бүрэлдэхүүн өөрчлөгдөж, олон нийтийн радио телевизийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг Хууль Зүй Дотоод Хэргийн Яамны дэргэд шинээр байгуулагдсан билээ. Ингээд 2001 оны хавар "Монголын олон нийтийн радио телевизийн тухай" хуулийн төсөл бэлэн болж, түүнийг УИХ-ын мөн оны намрын чуулганаар өргөн барихаар төлөвлөж байгаа аж.

Хуулийн энэ төслийг өмнөх төслүүдтэй харьцуулбал зарим талаар нэлээд сайжирсан мэт боловч олон нийтийн радио телевизийн ойлголт, үйл ажиллагааны онцлогийг тодорхойлсон нь өмнөх хууль, дүрмийн төслүүдээс хуулбарласан шинжтэй, зарчмын хувьд илүү оновчтой, тодорхой болсон зүйл харагдахгүй байна. Уг төсөлд олон нийтийн радио телевизийг мөн л нийгэмд үйлчилдэг, улс төрийн ашиг сонирхлоос ангид, иргэдийн үнэн бодит мэдээлэл авах эрхийг хүндэтгэнэ, ил тод байдал, үндэсний эрх ашиг, олон ургальч үзлийг эрхэмлэнэ гэх зэрэг нийтлэг, урд өмнөх төслүүдэд орж байсан зарчмуудыг давтаад, харин дутагдаж байсан зүйлүүдийг сайжруулан баяжуулсангүй. Тухайлбал уг төсөлд урдын адил олон нийтийн телевизийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж болох гол аюул бол улс төрийн ашиг сонирхол хэмээн үзэж, харин эдийн засаг, бизнесийн сонирхлоос ангид байх шаардлагыг тавиагүй байна.

Цаашилбал уг төсөлд өмнөх төслийн нэгэн адил, мэдээлэх, танин мэдүүлэх нь олон нийтийн телевизийн гол үүрэг хэмээн үзсэн бөгөөд, алжаал тайлах, амралт чөлөөт цагийн хөнгөн нэвтрүүлэг, хөгжөөнт хөтөлбөрт ач холбогдол өгөөгүй, дурдаа ч үгүй өнгөрсөн нь нийт хөтөлбөрийн тэнцвэрт байдлыг гол шаардлага болгодог олон нийтийн телевизийн үндсэн зарчмыг үйл ойшоосны шинж бус уу.

Дээр дурдсан, одоогийн байдлаар олон нийтийн телевизийн тухай хамгийн сүүлийн үеийн, өөрөөр хэлбэл хамгийн сайн "боловсорсон" байх учиртай төсөлд урд өмнөх бараг бүх төсөлд чухалчлан оруулж байсан "олон ургальч үзлийг эрхэмлэх" зарчмыг мөн адил дурдсан боловч мөн л урд өмнө бүх төсөлд дутагдаж байсан зүйлийг нөхөлгүй, давтан хуулбарлажээ. Энэ нь юу вэ гэвэл, олон ургальч зарчмыг

баримтална гэдэг нь олон нийтийн телевизийн хувьд зөвхөн үзэл бодлын олон талыг баримтална гэсэн үг бус. Үүний зэрэгцээ бас нэвтрүүлгийн олон төрөл, утга агуулгын олон хувилбар, мөн хандаж буй үзэгчдийн өргөн хүрээг бодлоготойгоор хамруулна гэсэн үг. Зөвхөн ингэж чадсан тохиолдолд олон нийтийн телевиз нь, бизнесийн ашгийг үйл ажиллагааныхаа гол удирдлага болгодог арилжааны телевизээс ялгарч, төрөөс буюу олон түмнээс хураасан татвар, хураамжаар тэтгүүлэх нөхцлийг биелүүлнэ.

Ийнхүү Монгол Улсад олон нийтийн статустай радио телевизийн үйл ажиллагааг зохицуулах үүднээс санал болгож байсан хууль, дүрмийн төслүүдэд олон нийтийн радио телевизийн тухай ойлголтыг хэрхэн тодорхойлж вэ гэдгийг судлан үзэхэд, зарим нийтлэг дутагдал байгааг дүгнэн тэмдэглэе.

Энэхүү нийтлэлийн эхэнд дурдсанчлан, олон нийтийн мэдээллийн хэрэгслийг товчоор тодорхойлоход бэрхшээлтэй байдаг боловч, онцлон дурдаж болох гурван зарчим байдаг. Энэхүү гурван зарчим нь олон нийтийн телевиз нийгмийн өмнө хүлээх үүргээ биелүүлж, улмаар нийгэм, төрийн зүгээс санхүүгийн тэтгэлэг дэмжлэг авах нөхцөл болдог тул, үүнийг хууль эрх зүйн баримтад тодорхой тусгах нь зайлшгүй чухал:

1. Нэвтрүүлгийн нийтлэг буюу универсал шинжийг хадгалах зарчим (өөрөөр хэлбэл газар нутгийн байршил, нэвтрүүлгийн төрөл, утга агуулгатай холбоотой нийтлэг, хүртээмжтэй байх чадвар). Энэ талаар ихэнх төсөлд Үндэсний (олон нийтийн) радио телевиз нь "нийт үндэсний эрх ашгийг хамгаална" гэсэн ерөнхий заалт орсон байх боловч, олон нийтийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах эрхийг газар нутгийн байршилтай холбож баталгаажуулах ямар нэгэн оролдлого гарсангүй. Нөгөө талаар олон нийтийн телевизийн нэвтрүүлэг тухайн нийгмийн аливаа давхарга, сонирхлын бүлгийг ялгаварлан гадуурхахгүй, төрөл хэлбэр, утга агуулгаараа тухайн улсад амьдарч буй ямар ч нас, хүйс, шашин, үндэстэн ястны хэрэгцээг ижил тэгш хангахыг баталгаажуулсан ямар нэгэн тодорхой заалт аль ч төсөлд ороогүй, гагцхүү "үзэгчдийн эрх ашгийг ямагт дээдлэх", "үнэн зөв мэдээлэл олж авах олон нийтийн эрхийг хүндэтгэх", "иргэний нийгмийн хөгжилтэй холбогдолтой бүхий л мэдээг нийтэд түгээх" зэрэг хэт ерөнхий заалтаар олон нийтийн мэдээллийн хэрэгслийн нэгэн чухал шинж чанарыг бүрхэгдүүлжээ. Гэтэл энэхүү нийтлэг, нийгмийн аль ч давхарга, хэсэг бүлэг хүмүүст хүртээмжтэй байх зарчмыг оновчтой тодорхойлж хуульчлан тогтоохгүй бол олон нийтийн телевиз "ашигтай" үзэгчдийн сонирхолд нийцэх хөтөлбөрт түлхүү анхаарч, тухайн нийгмийн цөөнхийн сонирхлын орхигдуулах зэрэг хандлага гарч болзошгүй байдаг. (Жишээлбэл хүн ам төвлөрсөн, хот суурийн газрын үзэгчдэд зориулсан нэвтрүүлэг түлхүү явуулж, ингэснээрээ зар сурталчилгааны үнийг нэмэгдүүлж, илүү өндөр ашиг олохын төлөө үйл ажиллагаа явуулах.) Төрөөс ямар нэгэн санхүүгийн дэмжлэг авдаггүй, нэвтрүүлэгт нь нийгмийн зүгээс тавих шаардлага ч харьцангуй чөлөөтэй байдаг арилжааны телевиз, зар сурталчилгаанаас олох орлогоо боломжийнхоо хэрээр сайжруулахын тулд үзэгчдийн хамгийн их сонирхдог уран сайхны кино, хөгжөөнт нэвтрүүлэгт түлхүү анхаарч, зарим нэг хүмүүсийн (тухайлбал кино биш, сонгодог хөгжим сонирхдог хүмүүсийн сонирхлыг) огоорохоос өөр аргагүйд хүрдэг. Учир нь зар сурталчилгаанаас орж ирэх мөнгө тухайн нэвтрүүлэг явах үед дэлгэцний өмнө хэр олон хүн цугларч байгаатэй шууд хамааралтай байдаг аж. Үндэсний радио телевиз өнөөгийн байдлаар нийт орон даяар нэвтрүүлэг цацдагийнхаа хувьд зар сурталчилгааны зах зээлд ноёрхох байр суурь эзэлж байгаагаас гадна, зар сурталчилгааг тухайн нэвтрүүлгийн үзэгчдийн тоотой шууд хамааруулан тогтоодог ямар нэгэн тариф механизм өнөөдрийн байдлаар үйлчлэхгүй байгаа нь үнэн. Гэсэн хэдий ч олон нийтийн телевизийн эрх зүйн зохицуулалтыг бэлтгэж боловсруулахдаа холч, ухаалгаар хандахгүй бол нэгэн цагт үзэгчдийн хураамж, төрийн тэтгэлэг, зар сурталчилгаа аль алианаар нь санхүүждэг Монголын олон нийтийн телевиз нь нэвтрүүлгийнхээ бодлогын хувьд арилжааны телевизээс ялгарах зүйлгүй "мөнгөний машин" болсон байх вий.

2. Нийтлэг буюу хүртээмжтэй байх чанар нь олон ургальч байх зарчимтай нягт холбоотой гэж дээр тэмдэглэж байсан. Энэхүү зарчмыг олон нийтийн телевизийн тухай хууль дүрмийн бүх төсөлд багтаасан боловч бүгдэд нь зөвхөн нэг талаас нь, тухайлбал үзэл бодлын хувьд олон ургальч зарчмыг баримтална хэмээн заажээ. Тэр бүү хэл зарим төсөлд "улс төр эдийн засгийн маргаантай асуудалд олон ургалч үзлийн эрхэмлэнэ" гэж дээрх зарчмын үйлчлэх хүрээг хязгаарласан аж. Харин олон нийтийн телевизийн нэвтрүүлэгт олон ургальч байх шаардлагыг томъёолохдоо илүү өргөн хүрээгээр, зориулж буй хэрэглэгчдийн эрх ашгийн үүднээс тодорхойлдог аж. Энэ нь нэг нэвтрүүлэгт аливаа асуудлыг олон талаас авч үзэж, үзэл бодлын илрэлийг өнцөг бүрээс нь тайлбарлахаас гадна, нийт хөтөлбөрт утга агуулга, сэдвийн өргөн хүрээг харгалзаж, нэвтрүүлгийн янз бүрийн хэлбэрээр, үзэгчдийн янз бүрийн давхаргад хандаж, тэдний сонирхлыг бүхий л талаар хөндөж чадвал, олон ургалч үзлийн эрхэмлэн дээдэлсний илрэл болно гэсэн үг юм байна. Нэг нэвтрүүлэг үзэл бодлын хувьд тэнцвэртэй байхаас гадна тухайн телевизийн нийт нэвтрүүлгийн бодлого тэнцвэртэй байж гэмээнэ олон нийтийн эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулж чадна. Дээр тайлбарласнаар, арилжааны телевиз зар сурталчилгааны ашгаа нэмэхийн тулд хөгжөөнт нэвтрүүлэг "хөөж", зарим сэдэв, нэвтрүүлгийн төрлийг орхисноос нийт хөтөлбөр тэнцвэрээ алдаж, ингэснээр нэг хэсэг хүмүүсийн сонирхол, хэрэгцээг хангах нэвтрүүлэг орхигдох хандлагатай байдаг. Харин үзэл бодлыг тэнцвэртэй тусгахаас гадна нийт хөтөлбөрийнхөө тэнцвэртэй байдлыг хадгалахыг үүрэг болгон хуулиар баталгаажуулах нь олон нийтийн телевизийн мөн чанарыг хадгалахтай шууд холбоотой байдаг.

3. Нийт үндэсний эрх ашигт үйлчилж, нийгмийн бүхий л давхарга, хэсэг бүлгийн сонирхол хэрэгцээг ижил тэгш хангахын тулд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь хараат бус бие даасан үйл ажиллагаа явуулах чадвартай байх ёстой. Бие даасан хараат бус байдал нь олон нийтийн телевизийн тулгуур зарчим хэмээн дээр тэмдэглэсэн. Энд авч үзсэн хууль, дүрмийн ихэнх төсөлд олон нийтийн телевизийн бие даасан байдлыг юуны түрүүнд улс төрийн нөлөөлөлтэй холбож үзсэн, харин зарим төсөлд "ашгийн төлөө бус байгууллага" хэмээн олон нийтийн байгууллагыг хуулийн этгээдийн хувьд тодорхойлсныг эс тооцвол, нийтлэлийн бодлогын хувьд эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байх тодорхой заалт хуулийн аль ч төсөлд ороогүй байна. Дэлхий нийтийн жишгээс үзэхэд, олон нийтийн телевиз зөвхөн мэдээлэх, соён гийгүүлэх үүрэг бүхий, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байгууллага хэмээн үзэж байсан нь алдаа болж, эдүгээ цөөн бус оронд олон нийтийн телевиз хямралын байдалд ороод байгаа билээ. Гэтэл телевиз бол өрсөлдөөн, эдийн засгийн ашиг сонирхолд хөтлөгдөж болох бизнесийн нэгэн төрөл, тийм ч учраас олон нийтийн телевизийг зах зээлийн хуульд бус нийгмийн эрх ашигт үйлчлүүлэхийн хүсвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд норматив үүрэг тогтоох нь зайлшгүй чухал байдаг аж. Учир нь нэг талаар зах зээлийн хууль нийгмийн эрх ашигт тэр болгон үйлчлэхгүй, нөгөө талаар телевизийн санхүүжилт хангалттай байвал эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байна гэсэн горьдлого ч үнэн хэрэгтээ туйлшралаас хамгаалдаггүй аж.

Ийнхүү өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд радио телевизийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, төрийн харъяаллаас гаргаж олон нийтийн статустай болгон хөгжүүлэх санал, хууль дүрмийн төслүүд нэг нь нөгөөгөө нөхөн, улам бүр сайжирч боловсронгуй болж иржээ хэмээн дүгнэхэд бэрх байна. Зөвхөн олон нийтийн телевизийн тухай ойлголт, үйл ажиллагааны зарчмыг хууль дүрмийн одоогийн болон өмнөх төслүүдэд хэрхэн тодорхойлсныг сонирхоход ийм дүр зураг гарч байгаа билээ. Хэдийгээр олон нийтийн телевиз гэдэг Монгол орны хувьд цоо шинэ зүйл ч гэсэн, гадаадын байгууллага

мэргэжилтнүүдээс хангалттай олон удаа зөвлөмж авч, хурал цуглаан, уулзалт ярилцлага хийж байсныг бодвол одоогийн бидний хүрээд байгаа түвшин чамлалттай. Нөгөө талаар олон давхардсан, бие даасан хууль дүрмийн төсөл хэрхэн төрж, хувь заяа нь ямаршуу маягаар шийдвэрлэгдэж байсныг харахад радио телевизийг төрийн мэдлээс гаргаж, олон нийтийн статустайгаар хөгжүүлэх цэгцтэй, тууштай төрийн бодлого үгүйлэгдэж байсыг юун түрүүнд анзаарч болно.



ГАРЧИГ

1. **Оршил**
2. **Ю. Эрдэнэтуяа / дэд доктор /
Монголын телевизийн өчигдөр, өнөөдөр...**
3. **Вернер Рамхорст (Европын зөвлөл)
Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай ойлголт, түүний үүрэг**
4. **Тоби Мендель (“19 ДҮГЭЭР ЗҮЙЛ” байгууллага)
Олон нийтэд үйлчилдэг телевиз радио:
хуулийн харьцуулсан судалгаа**
5. **Хелен Дарбишире (ОУСХ-ны шинжээч)
Радио, телевизийн нэвтрүүлгийн эрх чөлөөг хангах,
хамгаалах арга хэмжээ**
6. **Х.Наранжаргал / Сэтгүүлч/
Монголд олон нийтин радио, телевиз байгуулах нөхцөл, боломж”**
7. **М.Мөнхмандах. (МХХ)
Олон нийтийн телевизийн тодорхойлолт
Монголын радио телевизийн тухай хууль дүрмийн төсөлд**

Эхийг “Глоб Интернейшнл”ТББ-д бэлтгэж “Golden eye” хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Уг номыг авахыг хүсвэл доорхи хаягаар манайд хандана уу.

Хаяг. Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж.
Сант-Асар ХҮТөв 310 тоот.

Утас: 324627,324764

Факс:976-1-324764

E-mail: globe@magicnet.mn
globe@mongolnet.mn

Web site: <http://www.globeinter.com/>